Дархан-Уул аймгийн
Засаг даргын Тамгын газар

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР

# ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
# 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

*2022 он 12 сар 15*

## ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН

***Зорилго: Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд бүх нийтийг хамруулах, хэнийг ч орхигдуулахагүй байх зарчмыг баримтлан, эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.***

2022.12.15.

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хэрэгжилт | Гүйцтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 1 . Хүн амыг амьдралын хэв маягаас үүдэлтэй өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл таатай орчинд ажиллаж, амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд салбар дундын хамтын ажиллагааг хангана.** | | | | | | | |
| 1.1.1 | Аймгийн Эрүүл мэндийн салбар зөвлөлийн тогтвортой үйл ажиллагаа хангаж ажиллана | 400.000 | -Хурлын тоо<br>-Гарсан зөвлөмж | Хурал-1 Зөвлөмжийн тоо 7 | Хурал-2 Зөвлөмжийн тоо | Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/360 дугаар захирамжийн дагуу аймгийн Эрүүл мэндийн салбар зөвлөл 2 удаа хуралдаж, хурлаар Хүн амын халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг оношилгооны зохион байгуулалт хэрэгжилт, Эх хүүхдийн эндэгдлийг бууруулах талаар аймгийн хэмжээнд зохион байгуулж буй арга хэмжээ, Хүн амын зөв зохистой хооллолт, Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх арга хэмжээ, БЗДХ-ын өвчлөлийн өнөөгийн байдал, тусламж үйлчилгээ, хяналт илтгэл сургалт нөлөөллийн үйл ажиллагааны үр дүн зэрэг 5 асуудлыг хэлэлцсэн. Салбар зөвлөлөөс гарсан зөвлөмжийн хэрэгжилт 100% байна. | 100% |
| 1.1.2 | МУ-ын Эрүүл мэндийн сайдын 2021.09.09-ны өдрийн А/559 дугаар тушаалын дагуу “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөө орон нутгийн онцлогт тохируулан боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллана. | 1 сая | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь шалгуур үзүүлэлт | - | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 80%, шалгуур үзүүлэлт | Эрүүл мэндийн сайдын 2021.09.09-ны өдрийн А/559 дугаар тушаалаар “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилт 17 үйл ажиллагаа төлөвлөн ажиллаж, хэрэгжилт 95%-тай байна.<br>Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжье сэдвээр 21 байгууллагын 2345 албан хаагч, үе тэнгийн 50 сургагч багш, 512 сурагчид, зорилтот бүлгийн 428 иргэдийг сургалтад хамруулсан байна.<br>АИХ, ЭМГ, ЦГ, Гүүд нэйборс ОУБ-тай хамтран ерөнхий боловсролын сургуулийн 1200 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сурагчдад сургалт зохион байгуулж, сургалтад оролцсон 200 сурагчдаас мэдлэгийн түвшинг үнэлэхэд мэдлэгийн дундаж түвшин 18%-иар нэмэгдсэн.<br>Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэг үзлэгт 850 эрэгтэйчүүд хамрагдаж, 6 шинэ сүрьеэ илэрч эмчилгээ хяналтад 100% авсанаар 90 хүнийг халдварлах эрсдлээс сэргийлсэн.<br>БЗДХ-аас сэргийлэх үзлэг шинжилгээнд 320 эрэгтэйчүүд хамрагдаж илэрсэн өвчлөлийг 100 хяналтад авч эмчилсэн байна.<br>НЭ “Эрчүүдээ хайрлая” өдөрлөгөөр урьдчилан сэргийлэх үзлэгт 300 хүн хамрагдаж илэрсэн өвчлөл 92, эрүүлжилт 52.3%-тай байна. Түрүү булчирхайн дурангийн хагалгаанд 14 хүн орсон эмчилгээний үр дүн 100%<br>Нэгдсэн эмнэлэг Эрэгтэйчүүдийн кабинетийг 9 сараас нээн ажиллуулсан ба Урологийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт 74 эрэгтэйчүүд хамрагдсан байна.<br>Үр дүн: Нийт 4535 иргэн сургалтад, 1515 иргэн үзлэг,шинжилгээнд хамрагдаж үүнээс өвчлөлтэй 36 иргэнд эмчилгээ, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. | |
| 1.1.3 | МУ-ын Эрүүл мэндийн сайдын 2021.06.10-ны өдрийн А/360 дугаар тушаалын дагуу “Хавдрын эсрэг” арга хэмжээний төлөвлөгөө орон нутгийн онцлогт тохируулан боловсруулж, хэрэгжилтийг хангаи ажиллана. | 1 сая | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь, шалгуур үзүүлэлт | - | Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 80%, шалгуур үзүүлэлт | Эрүүл мэндийн сайдын 2021.06.10-ны өдрийн А/360 дугаар тушаалын дагуу “Хавдрын эсрэг” арга хэмжээг 6 зорилт 61 үйл ажиллагаа төлөвлөн, хэрэгжилт 90%-тай байна.<br>Хавдрын эмчийн амбулаторийн үзлэг 3508. Хорт хавдрын шинэ тохиолдол 207, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 27 тохиолдлоор нэмэгдсэн. Нас барсан тохиолдлын тоо 144, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23 тохиолдлоор нэмэгдсэн. Хорт хавдрын шинэ тохиолдол 15.9% эрт үе, 84.1% хожуу үедээ оношлогдсон. Одоо 1004 иргэн хавдрын эмчийн хяналтад байна. Хөдөлмөр зохицуулалт хийгдсэн хүн 164. Нийт хөнгөвчлөх тусламж үйлчилгээнд хамрагдсан хүн 3950. Хорт хавдраар эмчлүүлэгчдийн эмчилгээнд 84.951.863 төг, хими эмчилгээнд 17.664.533 төг зарцуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2022 оны 11 сарын байдлаар: Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 20-оос дээш насны 31500 эмэгтэй хамрагдахаас 28249 буюу 89.7% ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.0 хувиар өссөн байна. Өөрчлөлттэй гарсан 32 эмэгтэйг 2-р шатлалд, хавдар оношилогдсон 2 үйлчлүүлэгчийг ХСҮТ рүү илгээсэн.<br>Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 30-60 насны 6795 эмэгтэй хамрагдахаас 4140 буюу 60.9% буюу өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.5 хувиар өссөн байна. Хавдрын урьдал 142, байран өмөн 1 илэрсэнг эдийн шинжилгээ 15, үрэвслийн эсрэг эмчилгээ 103, Leep эмчилгээ 5 хүнд хийгдсэн байна. Элэгний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 40-65 насны 29157 иргэн хамрагдахаас 27490 буюу 94.3% хамрагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7%-иар буурсан байна. Шинээр В вирусын хяналтанд 25, С вирусын хяналтанд 53 орсон ба<br>Эмчилгээнд хамрагдсан 8 хүн эрүүлжсэн.<br>Элэгний В вирусын шалтгаант архаг үрэвсэлтэй 388, Дельта вирус хавсарсан 135, элэгний хатуурлатай 201, элэгний С вирусын архаг үрэвсэлтэй 103, хурц үрэвсэлтэй 11 иргэн амбулаторын эмчийн хяналтад байна.<br>Үр дүн: Хөнгөвчлөх 8 ортой эмчилгээний тасагт 435 хүнд хөнгөвчлөх эмчилгээ, 46 хүнд хими эмчилгээ хийж тусламж үйлчилгээ үзүүлж байна. Хавдрын эмчийн амбулаторийн үзлэг 3508 иргэн үзүүлж тусламж үйлчилгээ аьсан байна. Хорт хавдраар эмчлүүлэгчдийн эмчилгээний зардал 102.616.396 төгрөг зарцуулсан байна. | |
| 1.1.4 | Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх арга “Зөв зохистой хооллож, эрүүл идэвхитэй амьдарцгаая”-Эрүүл байгууллага, ажлын байр | 2 сая | Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан иргэд | Хамрагдсан 800 | Хамрагдалт 1200 | Албан хаагчдын ажлын байранд эрүүл мэндийг дэмжих зорилгоор “Эрүүл идэвхтэй амьдарцгаая” 6 сарын аянг зохион байгуулж, Халдварт бус өвчнөөс сэргийлье ажлын байрны сургалтад 23 байгууллагуудын 1345 албан хаагчид, ажилчид хамрагдсан. Мөн эдгээр байгууллагуудын 711 албан хаагчдын Body | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аян зохион байгуулна | | | | | Analyses аппаратаар биеийн найрлага хэмжиж, Хооллолтын судалгаа авсан. Судалгааны үзүүлэлтээр хэвийн жинтэй 415 хүн 58.3%, илүүдэл жин, таргалалттай 152 хүн 21.4%, хэт тарган 144 (19.6%). Зан үйлийн асуултаар үзэхэд тамхи татдаг 284(39.9%), дам тамхидалтанд өртдөг 51(7.2%). Хооллолтын цахим судалгаанд оролцсон 489 албан хаагч ажилчдын өглөөний цайгаа тогтмол уудаг 153 хүн 31.3%, хааяа уудаг 237 хүн 48.5%, огт уудаггүй 99 хүн 20.2%, Өдөр бүр исгэлэн сүүн бүтээгдэхүүн өдөр бүр хэрэглэдэг 40 хүн 8.1%, хааяа 171 хүн 35%, огт хэрэглэггүй 277 хүн 56.6% судалгааны үр дүнтэй байна.<br>Үр дүн: Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих зорилгоор Эрүүл идэвхтэй амьдарцгаая 6 сарын аян зохион байгуулж, сургалтад 23 байгууллагуудын 1345 албан хаагчид, ажилчдыг хамруулж, хооллолтын байдлыг тодорхойлох судалгаанд хамруулсан. | |
| 1.1.5 | Харшлаас сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана | - | Зохион байгуулсан арга хэмжээ, хамрагдсан иргэд | Хамрагдсан 500 | Хамрагдалт 1000 | Эрүүл мэндийн сайдын 2021.12.31-ний өдрийн А/816 дугаар тушаалын дагуу “Харшлаас сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөө 4 зорилтын 17 үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжилт 95%-тай байна. Арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлье сургалт, үзлэгийг 24 аж ахуй нэгж албан байгууллага, 5 өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 5381 хүнд зохион байгуулсан. Арьс харшлын эмчийн урьдчилан сэргийлэх үзлэгт 4507 иргэд хамрагдаж, шинэ өвчлөл 87, архаг сэдрэлтэй 168 хүн эмчилгээ хяналтад авсан. | 100% |
| 1.1.6 | Нийтийн эрүүл мэндийн чиглэлээр гарч байгаа тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж, хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана. | - | Хяналтын тоо<br>Өгсөн зөвлөмж | - | Зөвлөмжийн хэрэгжилт | Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын их хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолын дагуу<br>1. “Эрүүл идэвхтэй амьдрал арга хэмжээний төлөвлөгөө” ЭМС-ын 2021 оны А/780дугаар тушаалаар батлагдсан. хэрэгжилт 90%<br>2. “Хавдрын эсрэг арга хэмжээний төлөвлөгөө” ЭМС-ын 2021 оны А/360 тушаалаар батлагдсан. хэрэгжилт 90% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3.“Орчны эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөө” ЭМС-ын 2021 оны А/349 душаар тушаалаар батлагдсан. хэрэгжилт 90%<br>4.“Харшлаас сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө” ЭМС-ын 2021 оны 816 дугаар тушаалаар батлагдсан. хэрэгжилт 90 %<br>5.“Эх хүүхдийн нөхөн үржихүйн эрүүл мэнд арга хэмжээний төлөвлөгөө” ЭМС 2021 оны А/760 тушаал. хэрэгжилт 90%<br>6.“Эрүүл чийрэг эр хүн арга хэмжээний төлөвлөгөө” ЭМС-ийн 2021 оны 559 тушаал.хэрэгжилт 90 %<br>ЭМЯ, НЭМҮТ, ХӨСҮТ, ЭХЭМҮТ-ээс 73 албан бичиг ирсэн ба 53 арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, 39 хариутай албан тоотыг цаг хугацаанд нь хариу тайлан мэдээлэл явуулсан.<br>Үр дүн: Монгол улсын Засгийн газрын 2021-2024 онд хэрэгжүүлэх 6 арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 90%-тай байна. | |
| **Зорилт 2. Иргэдийн оролцоотойгоор Халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх, иргэдийг эрүүл идэвхитэй амьдралын хэв маягт суралцахад дэмжин ажиллах** | | | | | | | |
| 2.1.1 | Ковид-19 халдварын тандалт судалгааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийж, халдварыг бууруулах хариу арга хэмжээг зохион байгуулна | 1000 000 | Судалгаанд суурилсан хариу арга хэмжээний үр дүн | Зохион байгуулсан арга хэмжээ 12 Хамтран ажилласан байгууллага 20 | Зохион байгуулсан арга хэмжээ 15 Хамтран ажилласан байгууллага 25 | Коронавируст халдвар /Ковид-19/-ын нийт 11056 тохиолдол бүртгэгдсэн байна. Үүний 1613 буюу 14.6% нь ПГУ шинжилгээгээр, 9443 буюу 85.4% нь түргэвчилсэн шинжилгээгээр батлагдсан. 1953 хүн эмнэлэгт, 10281 хүнийг гэрээр эмчилж, эдгэрч хяналтаас гарсан байна.<br>Халдвар бүртгэгдсэн аж ахуй нэгж байгууллагууд, хүүхдийн байгууллагуудад голомтын халдваргүйтгэл 9000 мкв талбайд хийсэн байна.<br>Ковид-19 халдварын тандалт судалгааг өдөр бүр 39 ерөнхий боловсролын сургууль, 26 сургуулийн өмнөх боловсролын байгууллагатай хамтран хийж хариу арга хэмжээг зохион байгуулах, халдваргүйтгэл ариутгал хийж, зөвлөмж чиглэл өгч ажилласан.<br>Эрүүл мэндийн байгууллагууд, хууль хүчний байгууллагуудын 987 ажилтан албан хаагчдад Ковид-19 халдвар илрүүлэх тандалтын шинжилгээг зохион байгуулж 25 буюу 2.5% | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | халдвар илэрч хариу арга хэмжээг авч ажилласан.<br>Баяр наадмын үйл ажиллагаа явагдах газруудад урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийг давхардсан тоогоор нийт 11000мкв талбайд хийсэн.<br>Засаг даргын захирамжаар Ажлын хэсэг “SARS-CoV-2 вирусийн омикрон ВА4, ВА5 хувилбараар үүсгэгдсэн халдварын улмаас үүсэх эрсдэл ямар вэ?” гэсэн сэдвээр эрсдэлийг тодорхойлж ӨНДӨР эрсдэлтэй үнэлэгдсэн. Үнэлгээний үр дүнд цаашид хэрэгжүүлэх нийт 15 заалт бүхий үйл ажиллагаа, төлөвлөгөөний саналыг АОК-т хүргүүлсэн. Хэлэлцүүлэгт ЭМГ, ОБГ, МХГ, ХХААГ, ТХ, ЦГ, Статистикийн хэлтэс зэрэг 10 байгууллагын 15 мэргэжилтэнүүд оролцсон.<br>Долоо хоног бүр Короновируст халдварын тархалын үе шатны үнэлгээг ЭМС-ын 2022 оны 207 дугаар тушаалын дагуу хийж байгаа бөгөөд 2022 оны 47-р долоо хоногийн байдлаар Дархан-Уул аймгийн хэмжээнд шинээр илэрсэн тохиолдлын тоогоор ногоон түвшинд байна. | |
| 2.1.2 | Шинэ болон сэргэн тархаж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, дархлаажуулалтад хамруулах үйл ажиллагааг зохион байгуулна | | Дархлаажуулалтын хамрагдалтын тоо, хувь | 80% | 88% | Заавал хийгдэх товлолын дархлаажуулалтад 25408 хүүхэд хамрагдахаас 25358 хүүхэд хамрагдсан 99.8%-тай байна. Урвал хүндрэл гараагүй.<br>Тархвар судлалын заалтаар В гепатит вакцинд 6000, ВГВ-н иммуноглобулин 55, галзуугийн эсрэг вакцинд 318, хачигт халдвараас сэргийлэх вакцинд 21 хүн хамрагдсан.<br>Томуугийн дархлаажуулалтад 13690 хүн хамрагдахаас 13504 хүн хамрагдаж хамрагдалт 98.6% байна.<br>Сайн дурын дархлаажуулалт ВГВ 169 хүн, балнадын эсрэг вакцинд 65 хүн хамрагдсан.<br>Короновируст халдвар /Ковид-19/-ын эсрэг дархлаажуулалт насанд хүрэгчид давхардсан тоогоор 171142 хүн, 12-17 насны 16931 хүүхэд, 5-11 насны 565 хүүхэд тус тус хамрагдсан байна.<br>Коронавируст халдвараас сэргийлэх, дархлаажуулалтын нэмэлт тунг идэвхижүүлэх зорилгоор Эрүүл мэндийн байгууллагууд 16 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | удаагийн эрүүл мэндийн цахим ярилцлага, зөвлөгөө, ХӨСҮТ-тэй хамтран 16 төрлийн Дархлаажуулалтын ач холбогдол цахим постер бэлтгэн Эрүүл мэндийн газрын болон бусад Дархан хот, Дархан-уул аймаг, дархан хотын хамгийн том групп зэрэг 17 цахим хуудаст тус тус байршуулсан. Хандалтын тоо 68216 | |
| 2.1.3 | ХӨСҮТ-тэй хамтран зорилтот (0-5 насны хүүхэд, жирэмсэн эх, 65+ насны ахмад) бүлгийн хүн амд улирлын томуугийн эдийн засгийн дарамтыг тооцоолох судалгаа хийнэ | ХӨСҮ Т. Глоба ль сан дэмжл эгтэй | Судалгаан ы үр дүн | - | Хийгдсэн судалгаан д хамрагдса н иргэдийн тоо, үр дүн | ХӨСҮТ-тэй хамтран Дархан-Уул аймгийн зорилтот (0-5 насны хүүхэд, жирэмсэн эх, 65+ насны ахмад) бүлгийн хүн амд улирлын томуугийн эдийн засгийн дарамтыг тооцоолох судалгааг авах, өрхийн эмч мэргэжилтнүүдийг бэлтгэх арга зүйн сургалтыг зохион байгуулсан. Улирлын томуугийн эдийн засгийн дарамтыг тооцоолох судалгааг 0-5 нас 55, жирэмсэн 46, 65-с дээш ахмад 53, нийт 154 хүнээс авч ХӨСҮТ-д хүргүүлсэн. | 100% |
| 2.1.4 | Улирлын болон томуугийн цар тахлын хүндрэлийн үнэлгээг PISA мартицаар тогтмол хийж ХӨСҮТ-д мэдээлж ажиллана | - | PISA мартицын үнэлгээ | -ТТӨ-ний 10,000 хүн ам дахь өвчлөл 99,3-156,6<br>-АЗЦХХ 10,000 хүн ам дахь өвчлөл 8,9-21,2 | -ТТӨ-ний 10,000 хүн ам дахь өвчлөл 57,2-99,2<br>-АЗЦХХ 10,000 хүн ам дахь өвчлөл 3,2-8,8-с ихгүй байлгах | Улирлын болон томуугийн цар тахлын хүндрэлийн үнэлгээг PISA матрицаар тогтмол хийж ХӨСҮТ-д мэдээлж ажилласан.<br>2022.02 сард ХӨСҮТ баг бүрэлдэхүүн ирж ажиллан аймгийн томуугийн 9 тандалтын нэгжийн 5 жилийн томуугийн тоо баримт дээр тулгуурлан өөрийн PISA үнэлгээний босго үзүүлэлттэй болсон. Үүнд :<br>- Улирал хоорондын үе – 10.000 хүн ам дахь өвчлөл ТТӨ 0-39.8, АЗЦХХ 0-2.8<br>- Идэвхжлийн үе – 10.000 хүн ам дахь өвчлөл ТТӨ 39.9-73.1, АЗЦХХ 2.9-6.4<br>- Алаг цоог дэгдэлт – 10.000 хүн ам дахь өвчлөл ТТӨ 73.2-171.1, АЗЦХХ 6.5-13.8<br>- Аймгийн хэмжээний дэгдэлт – 10.000 хүн ам дахь өвчлөл ТТӨ 171.2-302.7, АЗЦХХ 13.9-17.7<br>- Тахал тархалт – 10.000 хүн ам дахь өвчлөл ТТӨ 302.8≤, АЗЦХХ 17.8≤<br>2022 оны 47-р долоо хоногийн байдлаар аймгийн хэмжээнд ТТӨ-ний 10000 хүн ам дахь өвчлөл 39.7 промил, АЗЦХХ 4.3 промил бүртгэгдэж PISA матриц үнэлгээгээр "УЛИРАЛ ХООРОНДЫН ҮЕ" буюу ногоон түвшинд үнэлэгдсэн байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.5 | Бэлгийн замаар дамжих халдварыг илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийг хамруулах арга хэмжээг төр, ТББ, ажил олгогчидтой хамтран зохион байгуулж, халдвартай иргэдийг эмчилгээнд бүрэн хамруулж, эмчилгээний үр дүнг тооцон ажиллана | ХӨСҮТ. Глобаль сан дэмжлэгтэй | Идэвхитэй илрүүлэг үзлэгт хамрагдалтын тоо Эмчилгээний хувь | Идэвхитэй илрүүлэг үзлэгт хамрагдалтын тоо 14000 хүн эмчилгээнд 100% | Идэвхитэй илрүүлэг үзлэгт хамрагдалтын тоо 1600 хүн эмчилгээнд 100% | ХӨСҮТ, Төгс бүсгүйчүүд ТББ-тай хамтран 150 ЭБҮ-г шинжилгээнд хамруулан 13 шинэ өвчлөлийн тохиолдлыг илрүүлэн эмчилгээнд 100% хамруулж хяналтанд авсан.<br>Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын жирэмсний хяналтад шинээр орсон 905 (давхардсан тоо 1492) жирэмсэн эмэгтэйд БЗДХ/ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд хамруулахад 25 шинэ өвчлөл бүртгэгдсэнг 100% эмчлэн эрүүлжүүлсэн. Урьд оны мөн үетэй харьцуулахад 4 тохиолдлоор /42.8%/-иар нэмэгдсэн байна.<br>БЗДХ өвчнөөс урьдчилан сэргийлье сэдвээр 15 удаа 600 сурагч, 150 оюутан залуучууд, Ерөнхий боловсролын сургуулийн 15 багш, аж ахуй нэгж байгууллагын 107 албан хаагч, 29 эмч эмнэлгийн мэргэжилтнүүд, ЭБҮ 117, жирэмсэн 558, нийт 3381 хүнд сургалт зохион байгуулсан. БЗДХ/ДОХ-оос урьдчилан сэргийлэх гарын авлага 1000ш иргэдэд тараасан.<br>ХДХВ/ДОХ-ын халдвартай хяналтад байгаа иргэдийн 93%-д нууцлалтай холбоотой утсаар зөвөлгөөг өгсөн. Сэтгэл ханамж 96%-тай байна.<br>Аймгийн хэмжээнд зонхилон тохиолдох халдварт өвчин тэмбүү 66, трихоманиаз 58, заг хүйтэн 52, нийт 176 шинэ тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх онтой харьцуулахад 17 тохиолдлоор бага 8%-иар буурсан. БЗДХ-ын өвчлөлийн шинэ 176 тохиолдлыг илрүүлэн, 100% эмчлэн хяналтанд авсан.<br>Дэлхий ХДХВ/ДОХ-ын асуудалд хандуулах өдрийг угтан 6333 иргэдэд сургалт, сурталчилгааг хийж, мэдээлэл түгээж ажилласан. ЭМЯ, НЭМГ, НЭМҮТ, ХӨСҮТ, 3 дүүргийн , хойд бүсийн 3 аймгийн АЗДТГ, БЗДХ-ын мэргэжлийн эмч нарт Глобаль сангийн дэмжлэгтэй ХДХВ-ийн тусламж үйлчилгээний талаар хэвлэлийн бага хурал, сургалт хэлэлцүүлэг зохион байгуулсан. | 100% |
| 2.1.6 | Халдварт бус өвчнийг бууруулахад эрүүл | 800 000 | Хэлэлцүүлгийн үр дүн | ХБӨ-ний үзүүлэлт | ХБӨ-ний үзүүлэлт | ЕБС-ийн “Үдийн хоол” хөтөлбөрийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний өнөөгийн байдал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэндийн байгууллагуудын уялдаа хэлэлцүүлэг зохион байгуулна | | | | | цаашдын төлөвлөлт хэлэлцүүлгийг БШУГ, МХГ, Стандарт хэмжилзүйн газартай хамтран зохион байгуулж удирдах албан тушаалтан 20 хүн оролцсон.<br>"Аюулгүй бай-Эрүүл бай" хүүхдийн осол гэмлийг бууруулах чиглэлээр 5 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилт 100%.<br>Ковид-19 халдвараас сэргийлэх дархлаажуулалтад иргэд, зорилтот бүлгийн хүн амын хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор хэлэлцүүлэгт албан байгууллага, иргэдэд 5 удаа 456 хүн хамрагдсан.<br>Дархлаажуулалтын нэмэлт тунгийн ач холбогдол тулгамдаж буй асуудал, иргэдийн эргэлзээ сэдвээр сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулж 120 хүн оролцсон.<br>ЭМС-ын А/139 дугаар тушаалын дагуу "Хүн амын эрт илрүүлэг үзлэг шинжилгээ оношилгоонд хамрагдах иргэдийн анхаарах асуудлууд" хэлэлцүүлгийг зохион байгуулж 74 иргэд хамрагдсан. | |
| 2.1.7 | Архи тамхины хор хөнөөлийн талаар нөлөөллийн сургалт үйл ажиллагааг идэвхижүүлнэ | 500.000 | Зохион байгуулсан үйл ажиллагааны үр дүн | Хамрагдсан хүний тоо 400 | Хамрагдсан хүний тоо 600 | Эрүүл мэндийн газар, Дархан сумын ИТХ, Цагдаагийн газар, Гүүднэйборс ОУБ-тай хамтран Электрон тамхи, утаат тамхины талаарх сургалтыг зохион байгуулж ЕБС-ийн 1200 сурагч, 128 оюутан хамрагдсан.<br>Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн тасаг, Шинэ амьдралын эхлэл ТББ-тай хамтран мэргэжлийн эмчийн сэтгэлзүйн зөвлөгөө уулзалтыг 3 удаа Архины хамааралтай 29 иргэдэд зохион байгуулсан.<br>Архигүй амьдралыг цогцлооё цахим аян зохион байгуулж, Архины хор уршиг, Намайг алгас, архи согтууруулах ундаа залуус бидний сонголт биш, архи асуудал шийдэх гарц биш зэрэг 12 төрлийн зөвлөмж, 7 төрлийн шторк бэлтгэн, Дархан-Уул Аймаг, Дархан хот, Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудас, Дархан хотын хамгийн том зар зэрэг 17 цахим хуудаст байршуулан хүн амд түгээн ажилласан. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн боловсруулсан 9 төрлийн инфографик | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөмжийг Дархан-Уул аймгийн 23487ш иргэдэд тараасан.<br>Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг 296 хүнд үзүүлсэн байна. Архины хамааралтай 109 үйлчлүүлэгч сэтгэл заслын эмчилгээнд хамрагдсан.<br>Нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн тасаг, Цагдаагийн газартай хамтран архины эмчилгээний 6 ортой өрөөг нээн, 21 үйлчлүүлэгчийг хэвтүүлэн эмийн болон сэтгэл заслын эмчилгээнд хамруулсан. | |
| 2.1.8 | “Идэвхитэй хөдөлгөөн, алхалт аян“ арга хэмжээг сурталчлах үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага иргэдийн оролцоотойгоор зохион байгуулна | 2 сая | Зохион байгуулсан арга хэмжээний үр дүн | Хамрагдсан хүний тоо 400 | Хамрагдсан хүний тоо 600 | • Монгол улсын Ерөнхий сайдын санаачлагаар “Илүүдэл жингүй эртэч Монгол” аянд нэгдэж 60 аж ахуй нэгж байгууллагуудын 360 удаагийн дасгалд 34229 албан хаагчид, иргэд хамрагдсан.<br>• ”Дэлхийн эрүүл мэндийн өдөр, хүн амын дунд зонхилон тохиолдож буй халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл зөв дадал бий болгох зорилгоор "Эрүүл мэндийнхээ төлөө- Алхангаа ярилцъя" өглөөний алхалтыг Эрүүл мэндийн газар, Биеийн тамир спортын газар хамтран 36 төрийн байгууллагуудын 725 ажилтан, алба хаагчид хамрагдсан.<br>• “Сүрьеэгүй Дарханчууд” Нарны алхалтад 296 сурагч, 15 багш ажилчид, СОС хүүхдийн хотхоны 17 багш хүүхдүүд өглөөний алхалт, ажлын байрны, аэробик дасгалд хамрагдсан.<br>• Эрүүл мэндийн яам, Чихрийн шижинтэй тэмцэх үндэсний төв болон Орбис Интернейшнл байгууллагаас хамтран хэрэгжүүлж буй “Чихрийн шижин болон чихрийн шижингийн шалтгаант ретинопатийн тусламж үйлчилгээний загвар бий болгох” төслийн хүрээнд “Эрүүл мэндийн боловсрол –Ирээдүйн эрсдэлээс сэргийлнэ” уриатайгаар бүх нийтийн алхалтыг зохион байгуулж, алхалтад 28 байгууллагын 454 ажилчин, алба хаагчид, 100 гаруй иргэд хамрагдсан. | 100% |
| 2.1.9 | Хүн амын эрүүл зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл сургалт, ”Эрүүл | 5 сая | Сургалт мэдээллийн төрөл, | Хүн амын эрүүл | Хүн амын эрүүл зан үйлийг | • Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд иргэдийн оролцоо нээлттэй хаалганы өдөр, хэлэлцүүлэгт "Эрүүл амьдрах нь энгийн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэндийн өдөр"-ийг сурталчлах хэвлэл мэдээлэл бүх сувгаар хүртээмжийг нэмэгдүүлнэ | | хамрагдсан хүний тоо | зан үйлийг төлөвшүүлэх мэдээлэл сургалт-61% | төлөвшүүлэх мэдээлэл сургалт-80% | алхмаас эхэлнэ" уриан дор Нийгмийн эрүүл мэндийн төв, 5 өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран Залуучууд театрт зохион байгуулж, 126 иргэд оролцлоо. Хэлэлцүүлгээр дотор, ахмад, хавдар, уушги, арьс харшлын мэргэжлийн эмч нар зөвлөгөө өгч, захын цусанд сахар, элэгний B,C илрүүлэх тестийн шинжилгээнд хамруулж, цусны артерийн даралт үзэж эрүүл мэндийн зөвлөгөөг 5 өртөөгөөр иргэдэд хүргэлээ.<br>• Аймгийн ИТХТ-ийн 2013 оны 15 дугаар тогтоолын дагуу сар бүр Дархан сумын ЗДТГ, Онцгой байдлын газар, Дархан дулааны станц ТӨХК, ахмадын хөгжлийн төв зэрэг 12 байгууллагад "Эрүүл мэндийн өдөр" дэвтэр, туг 14 хоногийн хугацаатай аялуулж, эрүүл мэндийн сургалтыг 13417 хүнд, орчны цэвэрлэгээ 11 удаа, алхалтыг 3 удаа тус тус зохион байгуулсан.<br>• Зонхилон тохиолдох Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтад нийт 63781 хүн хамрагдсан. Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн боловсруулсан цахим зөвлөмжийг орон нутгийн цахим 17 сувгаар түгээсэн. Эрүүл мэндийн байгууллагууд цахим хуудсанд 84 төрлийн зөвлөмж, 61 төрлийн шторк байршуулж, хандсан хүний тоо 142173 байна.<br>• Эрүүл мэндийн газар, орон нутгийн RGB, DBS телевизүүд, цэц.мн сайттай гэрээний дагуу хамтран Тодруулга ярилцлага 71 удаа, хэвлэлийн бага хурал 5 удаа, нэвтрүүлэг 30 удаа, үйл ажиллагааны мэдээ мэдээлэл 91 удаа, шторк зөвлөмж 61 удаа тус тус явагдсан байна. | |
| 2.1.10 | Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, ундны ус ариун цэврийн байгууламжийн төлөвлөгөө хэрэгжүүлэх, стандартын дагуу жорлон муу усны нүх барьж | 1000 000 | Ундны ус, хөрсний бохирдлоос үүдэлтэй өвчлөл өссөн, | Ундны ус, хөрсний чанарын үзүүлэлт | Салбаруудын хамтарсан үйл ажиллагааны үр дүн | • "Цэнхэр алт болох усаа хайрлая" уриатайгаар Эрүүл мэндийн газар, ШУТИС-ийн Дархан салбар, Дархан Ус суваг ХХК, Төв номын сантай хамтран Оюуны-Ирээдүй цогцолбор сургуулийн 6-12 ангийн 762 сурагчдад сургалт зохион байгуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ашиглах, нийтийн эзэмшлийн зам талбайд нус цэр хаяхгүй байх хөдөлгөөн өрнүүлнэ | | буурсан үзүүлэлт | | | • Госхот, Мэдстоб, Түвшинхолбоо өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран гэр хорооллын 48 усны худагт очиж "Ундны усны савны цэвэрлэгээ, халдваргүйтгэл" сэдвээр 184 айл өрхийн 2431 хүнд мэдээлэл сургалт зохион байгуулж, 7 төрлийн зөвлөмж 2687ш тараасан<br>• Эрүүл мэндийн газар, өрхийн эрүүл мэндийн төвүүд хамтран "Эрүүл орчинтой хашаа" 5 сарын аян зохион байгуулж, 512 өрхийн 827 хүнд сурталчилгаа зохион байгуулж, Эрүүл орчинтой хашаатай айл өрхийн 12 материалыг хүлээн авч, ажлын хэсгээр хэлэлцэж, 2022 оны "Эрүүл орчинтой" хашаагаар 3 өрхийг шалгаруулсан. | |
| 2.1.11 | Хүн амын дунд Зөв зохистой хооллолтын судалгаа хийж, үр дүнг тооцож ажиллана. | 3 сая | Судалгааны үр дүн<br>Хамрагдсан байгууллага, хүний тоо | - | Судалгааны үр дүн<br>-<br>Хамрагдсан байгууллага хүний тоо | • Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газрын 2022 оны А/29 дугаартай "Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн үдийн хоолны илчлэг, шимт бодисыг тодорхойох" удирдамжийн хүрээнд "Үдийн хоол хөтөлбөр" хэрэгжүүлдэг 21 ерөнхий боловсролын суруулийн 363 бүлэгт 11907 хүүхэд үдийн хоол хөтөлбөрт хамрагддаг. Нийт 52 тогооч ажиллаж байна. 12 сургууль буюу 57.1% нь хоолны технологийн карттай. 20 буюу 95.2% нь хүүхдийн хоолны илчлэгийг техтологи карт болон хүнсний найрлагын хүснэгт ашиглан тооцсон байна. 5 сургууль буюу 23.8% нь хүнсний бүтээгдэхүүний шинжилгээний бичгийг бүрэн гүйцэт дагалдуулж авч хадгалдаг байна. 13 буюу 61.9% нь чанар аюулгүй байдлын шаардлага хангасан агуулах, хөргүүр, хөргөх төхөөрөмжтэй, хоолны дээж авч бүртгэл хөтөлдөг байна. Хяналт шинжилгээнд хамрагдсан 21 ерөнхий боловсролын сургуулиудын үдийн хоолноос нийт 47 дээж авч Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулсан. Лабораторийн шинжилгээгээр үдийн хоолны дээжний илчлэг 457.4-977.4 ккал байна.<br>Дүгнэлт: Лабораторийн шинжилгээгээр Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | A/166, A/559, 222 тушаалын гуравдугаар хавсралт "Ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдийн хоногийн хэрэгцээг хангах хүнсний бүтээгдэхүүний жишиг хэмжээ"-нээс нийт 12 сургуулийн хоолны илчлэг нь 34.8-149.6 ккалиар буюу 2.2-8.8%-иар бага, 9 сургуулийн үдийн хоол 297.08-942.3 ккал хооронд байна. Үүнээс 5 буюу 24 хувь нь 610 ккал байх нормативыг хангасан, 16 буюу 76 хувь нь дээрх нормативыг хангаагүй байна.<br>• Эрүүл мэндийн газраас ажлын байранд эрүүл мэндийг дэмжих зорилгоор “Эрүүл идэвхтэй амьдарцгаая” аян өрнүүлж, албан хаагчид, ажилчдын зөв зохистой хооллолтын цахим судалгаанд 1345 хүн хамрагдсанаас 731 хүн 54.3% нь эрэгтэй, 614 хүн 45.7% нь эмэгтэй байна. Насны ангилалаар авч үзэхэд 15-16 насны 101 хүн 7.5%, 17-20 насны 211 хүн 15.7%, 20-30 насны 299 хүн 22.2%, 30-40 насны 366 хүн 27.2%, 40-50 насны 281 насны 20.9%, 50- аас дээш насны 87 хүн 6.5% байна. Та өглөөний цайгаа уудаг эсэх гэсэн асуултанд тогтмол уудаг 518 хүн 38.5%, хааяа уудаг 592 хүн 44.0%, амждаггүй 138 хүн 10.3%, өглөө юм идэж чаддаггүй 97 хүн 7.2% тай байна. Өдөрт уух шингэний хэмжээний талаар асуултад 1-2 аяга 310 хүн 23.0%, 3-4 аяга 453 хүн 33,7%, 4-5 аяга 370 хүн 27,5%, 6 ба түүнээс дээш аяга 212 хүн 15.8%, хариулсан байна. Исгэлэн сүүн бүтээгдэхүүн тогтмол хэрэглэдэг эсэх 170 хүн 12.6%, хэрэглэдэггүй 751 хүн 55.8%, 424 хүн 21.5% нь хааяа хэрэглэдэг байна. | |
| **Зорилт 3. Иргэн бүр урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх, эрүүл мэндийн үзлэг оношлогоонд хамрагдалтыг нэмэгдүүлж, чанар үр дүнг дээшлүүлэх** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.1 | Иргэн бүрийг хүн амын дунд зонхилон тохиолдож буй халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна. | - | Үзлэг оношлогоонд хамрагдсан хүний тоо | - | Үзлэг оношлогоонд хамрагдалтыг 80% хүргэх | • Нийгмийн эрүүл мэндийн төв хөдөөгийн алслагдсан хүн амд явуулын амбулаториор эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нийт 113 айл өрхийн 1137 иргэнд үзүүлсэн. Илэрсэн өвчлөл 141, хэвтэж эмчлүүлэх шаардлагатай 7 ахмад настанг уламжлалтын тасагт эмчлүүлсэн. Хамрагдалт 100%<br>• Малчдын эрүүл мэндийн сарын хүрээнд Хөдөөгийн малчин иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулж, зорилтот бүлгийн 150 өрхийн 6328 иргэнд хүрч ажилласан. Артерийн гипертензи, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэгт 45, ВС вирус илрүүлэг шинжилгээ 123, сахар холестеринд 172 хүн хамруулж эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Хамрагдалт 100%<br>• Эрт илрүүлэг урьдчилан сэргийлэх үзлэгт 0-17 насны 16525 , 18-31 нас 1783, 31-45 нас 1159, 46-60 нас 906, 61 дээш насны 634, нийт 21007 хүн хамрагдаж эрт илрүүлгийн хамрагдалтийн хувь 20.1% байна. | 70% |
| 3.1.2 | Өсвөр нас, оюутан залуучууд, эрчүүд, ахмад настан зорилтот бүлэгт чиглэсэн урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоог зохион байгуулна | 2 сая | Үзлэгт хамрагдсан хүний тоо, эрүүлжилтийн хувь | 10000 хүн | Зорилтот бүлгийн үзлэгийг 70%-д хүргэх | Арьс харшлын өвчнөөс урьдчилан сэргийлье сургалт, үзлэгийг 24 аж ахуй нэгж албан байгууллага, 5 өрхийн эрүүл мэндийн төвүүдийн 5381 хүнд зохион байгуулсан. Арьс харшлын эмчийн урьдчилан сэргийлэх үзлэгт 4507 иргэд хамрагдаж, шинэ өвчлөл 87, архаг сэдрэлтэй 168 хүн эмчилгээ хяналтад авсан.<br>Уушгины эмгэг илрүүлэх зорилтот бүлгийн үзлэгт 3129 хүн хамрагдсанаас 172 сэжигтэй тохиолдолд сорьцын шинжилгээ хийж 15 шинэ сүрьеэ илрүүлж, 100% эмчилгээ хяналтанд авсан.<br>Орхон сум, Түвшин холбоо өрхийн хавцал чулуу суманд ургац хураалт, хүнсний ногоо хураалт, хадлан тэжээлийн бэлтгэлийн ажилд дайчлагдан ажиллаж буй оюутан залуусыг үзлэгт хамруулах арга хэмжээг зохион байгуулж нарийн мэргэжлийн 5 эмчийн бүрэлдэхүүнтэй баг урьдчилан сэргийлэх үзлэгийг 120 оюутанг хамруулж үзлэг, зөвөлгөө өгч ажилласан байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Хүчний байгууллагын албан хаагч, их дээд сургуулийн оюутнуудын дунд "Тэгш байдлыг хангая" уриан дор дэвжээ тэмцээн, 12 ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд Гар зургийн уралдаан зохион байгуулсан. Үр дүн: Зорилтот бүлгийн үзлэгт 10000 хүн хамруулахаас 7756 иргэн хамрагдаж хамрагдалт 77.5% байна. | |
| 3.1.3 | Аж ахуй нэгж байгууллага өөрийн ажилчдыг зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэгт хамруулахад дэмжлэг үзүүлнэ | 2 сая | Үзлэгт хамрагдсан ААНБ, хүний тоо, эрүүлжилтийн хувь | Үзлэгт хамрагдсан 500 албан хаагчид | Үзлэгт хамрагдсан 800 албан хаагчид | 2-3 настай хүүхдүүдийг шинээр СӨББ-д авахтай холбоотой урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээг зохион байгуулж төр, хувийн хэвшлийн 4 лабораторид нийт 1948 хүүхдийг хамруулан өвчлөл илэрсэн 72 хүүхдийг илрүүлж, эдгэрэлт 100% байна. Эрүүл мэндийг дэмжих төвд 21 аж ахуйн нэгж байгууллага хамтран ажиллаж 884 албан хаагчдаа үзлэгт хамруулсан байна. | 100 |
| 3.1.4 | ХБИ-ийн зорилтот бүлгийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулна | 2 сая | Үзлэгт хамрагдсан хүний тоо, эрүүлжилтийн хувь | - | 100 | Нөхөн үржихүйн эрүүл мэнд сэдэвт сургалтыг тэргэнцэртэй иргэдийн холбоотой хамтран зохион байгуулсан. "Гэр бүл төлөвлөлт, Хөх умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг, Эрүүл зөв зохистой хооллолт" зэрэг сэдвээр сургалт зохион байгуулж, 18 эмэгтэйд эмэгтэйчүүдийн тусгайлсан үзлэг хийж ЭХО-д харан эмчилгээ зөвлөгөө өгсөн. Гэрэлтэй, Түвшинхолбоо, Хонгор ЭМТ-үүд харьяа өрхийн 485 ХБИ-г урьдчилан, сэргийлэх үзлэгт хамруулсан. Үр дүн: ХБИ-ийн зорилтот бүлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт 503 иргэн хамрагдсан байна. | 100 |
| 3.1.5 | Эрүүл хүүхэд – Эрүүл шүд аяныг зохион байгуулж үр дүнг тооцож ажиллана. | 1 сая | -Эрүүлжсэн хүүхдийн тоо<br>-Үзлэгт хамрагдсан хүүхдийн тоо | Үзлэгт-5494 Эрүүлжилт 39.2% | Үзлэгт-5500 Эрүүлжилт 40% | Дархан суманд Эрүүл хүүхэд – Эрүүл шүд аяны хүрээнд АШУҮИС-тай хамтран 263 хүүхдэд, Орхон суманд 168 хүүхдэд шүдний үзлэг хийж 100% эмчлэн эрүүлжүүлсэн. Эрүүл хүүхэд – Эрүүл шүд аяны хүрээнд "Шүдний эрүүл ахуй шүдээ зөв угаая" сэдвээр 2354 хүүхдэд сургалт зохон байгуулсан. Нэгдсэн эмнэлэг нь Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" аяны хүрээнд 2-12 насны хүүхдийн дунд амны хөндийн эрүүл ахуйг сахих дадал хэвшилд сургах, шүдний өвчлөлөөс урьдчилан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сэргийлэх зорилгоор эмнэлгийн цахим хуудсанд мэдээ, мэдээлэл байршуулан иргэдэд “Амны хөндийн эрүүл мэнд” сэдэвт сургалт зохион байгуулж нийт 5858 хүнд зөвлөгөө өгч ажилласан. Амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 4016 хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлж эмчилсэн. Үүнээс: Цоорлын эмчилгээг 925, сувгийн эмчилгээг 2650, урьдчилан сэргийлэх, эрдэсжүүлэх түрхлэгийг 940 хүүхдэд хийж 2400 хүүхэд бүрэн эрүүлжсэн.<br>Орхон СЭМТ-д Эрүүл хүүхэд-Эрүүл шүд хөтөлбөрийн хүрээнд ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар шүдний шинэ тоног төхөөрөмжөөр хангагдсан ба шүдний эмчийг авч шүдний кабинетаар 265 иргэн үйлчлүүлсэнээс 120 нь хүүхдэд тусламж үйлчилгээ үзүүлсэн эрүүлжилт 51.8%байна.<br>Хонгор СЭМТ Орон нутгийн хөгжлийн сангийн 59,8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шүдний бор машинаар хангагдаж, шүдний эмчийг орон тоогоор авч ажиллуулж байна. 189 хүүхэд шүдний эмчийн үзлэгт хамрагдаж эмчилгээ хийлгэсэн. Эрүүлжилт 135 хүүхэд буюу 71.4%<br>Шарын гол суманд 323 хүүхдэд шүдний үзлэг хийж эмчлэн эрүүлжилт 52.4% байна.<br>Үр дүн: Эрүүл хүүхэд – Эрүүл шүд аяны хүрээнд 5079 хүүхэд шүдний тусламж үйлчилгээ авсан ба эрүүлжилт 58.8%.<br>Сургалт, сурталчилаанд 8212 хүүхэд хамрагдсан байна. | |
| 3.1.6 | Түрхэц эерэг сүрьеэгийн халдвар авсан хавьтлыг далд халдварын эмчилгээнд хамруулна | ХӨСҮТ. СТН төсле өр | Хамрагдсан хүний тоо | - | Эмчилгээнд хамрагдалтыг 50%-д хүргэх | • Дижитал зөөврийн рентген аппаратаар Сүрьеэгийн илрүүлэг үзлэгт 5056 зорилтот бүлгийн иргэд хамрагдсанаас 252 сэжигтэй тохиолдлоос сорьцын шинжилгээг хийж 25 шинэ сүрьеэ илрүүлж, 100% эмчилгээ хяналтанд авсан.<br>• Сорьц тээвэрлэлт: Өрх, сумдын эрүүл мэндийн төвүүдээс 111 удаагийн давтамжаар 407 хүний сорьц тээвэрлэн 27 сүрьеэг илрүүлэн 100% эмчилгээ хяналтанд авсан байна.<br>• Өрхийн хавьтал:Түрхэц эерэгийн хавьтлын 30%ийг хяналтанд авахаар төлөвлөснөөс | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 146 эерэг хавьтлаас 69 буюу 47.2%-ийг далд халдварын эмчилгээнд хамруулсан.<br>• Ойрын хавьтал: Орон гэргүй 1 өвчтөний хавьтал 17 хүнээс 1 өвчлөл илрүүлэн эмчилгээ хяналтанд авсан. | |
| **Зорилт 4. Хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, үзлэг оношлогооны хүртээмжийг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| 4.1.1 | ЕБС-иудын "Үдийн хоол" хөтөлбөрийн эрхзүйн орчин, хяналт, стандартыг сайжруулахад мэргэжлийн байгууллагатай хамтран уулзалт зохион байгуулах, хяналтыг сайжруулна | 800.000 | Ерөнхий боловсролын сургуулийн үдийн хоол хөтөлбөрийн хамтарсан хяналт үнэлгээний үр дүн | ЕБС-иудын "Үдийн хоол" хөтөлбөр хууль шинээр батлагдсан. | 6-11 насны хүүхдийн шим тэжээлийн хүртээмж, хяналтын үр дүн | ЕБС-ийн "Үдийн хоол" хөтөлбөрийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний, өнөөгийн байдал цаашдын төлөвлөлт хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлэгт Аймгийн ЗДТГ-ын нийгмийн бодлогын хэлтэс, Боловсрол соёл шинжлэх ухааны газар, Мэргэжлийн хяналтын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, ЕБС-иудын захирал, удирдлагууд 28 шийдвэр гаргагч удирдах ажилтанууд оролцсон. "Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн үдийн хоолны илчлэг, шимт бодисыг тодорхойох" удирдамжийн хүрээнд 13 сургуулийн 8230 хүүхдэд өгч буй үдийн хоолны илчлэг тодорхойлох, хоол үйлдвэрлэл үйлчилгээний ажиллагаанд хамтран хяналт шинжилгээ хийж, 13 сургуулийн үдийн хоолноос 37 дээж авч МХГазрын итгэмжлэгдсэн лабораторит "Хоолны илчлэг" тодорхойлуулахад: 457.4 – 977.5 ккал, тооцооллын аргаар 13 сургуулийн хүүхдэд өгч буй нэг өдрийн хоолны илчлэг 420.5-931.1 ккал, шимт бодис болох уураг 19.9 г, өөх тос 16.97 г, нүүрс ус 83.43 г-тай байна.<br>Үр дүн: Ерөнхий боловсролын 13 сургуулийн үдийн хоол хөтөлбөрийн нэг өдрийн хоолны илчлэг 420.5-931.1 ккал, шимт бодис болох уураг 19.9 г, өөх тос 16.97 г, нүүрс ус 83.43 г-тай байна. Дээрх тооцооллоос харахад зарим сургуулиудын хоолны илчлэгийн хэмжээ 610 ккал хэмжээнээс бага байна. "Хоолны цэс төлөвлөлт, түүхий эдийн сонголт, хүүхдийн хоол хүнснээс авбал зохих шим тэжээл, илчлэгийн хэмжээг зөв тооцох"мэргэжил арга зүйгээр ханган ажилласан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.2 | Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоол тэжээлийн байдлын судалгаа хийж, судалгаанд үндэслэн “Хүүхдийн зохистой хооллолт, Эрүүл хүнс-Эрүүл шүд” арга хэмжээг салбарын оролцоотой зохион байгуулна | 700.000 | ЕБС-ийн хүүхдийн хоол тэжээлийн байдлын судалгааны үр дүн, зөвлөмж | Улсын хэмжээнд илүүдэл жинтэй 6-11 насны эзлэх хувь хот суурин газар 23.9%тай байна | 6-11 насны хүүхдийн өсөлт хоцрогдолтын тархалтын хувь | Хүүхдийн зөв зохистой хооллолтын норм стандарт, “Хүүхдийн хоолны давсыг анхаарья, Насанд хүрэгчдын хоолны давс агууламж стандарт” сэдвээр ЕБС, СӨББ-ын тогооч нар, эмнэлэг сувиллын тогооч нарыг хамруулсан 2 удаагийн сургалтаар 90 тогооч нарт сургалт зохион байгуулсан.<br>Өсвөр насны хүүхдийн зохистой хооллолт сургалтыг ЕБС-иудын эмч нартай хамтран 1 сургуулийн 1212 сурагчдыг хамруулсан.<br>Үр дүн: ЕБС-иудын 16 эмч нарт сар бүр хүүхдийн хоол тэжээлийн байдал, хүүхдийн өсөлт хөгжлийн үзүүлэлт үр дүнг сайжруулах талаар арга зүйн сургалтыг зохион байгуулсан. БШУГ-тай хамтран цахимаар, тамхимаар 4 удаа 6-11 насны хүүхдийн 127 эцэг эхчүүдэд сургуулийн насны хүүхдийн өсөлт хөгжлийн үзүүлэлт, өсвөр насны хүүхдийн зохистой хооллолт сургалтыг зохион байгуулсан | 100 |
| 4.1.3 | Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхдийн сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, мансууруулах сэтгэц нөлөөт бодисын хэрэглээг бууруулах чиглэлээр холбогдох хүүхдийн байгууллагуудтай хамтран нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна | 800.000 | Нөлөөллийн арга хэмжээний үр дүн тайлан | 378 хүн | 20 удаа 1000 хүн | Өсвөр насны хүүхдийн сэтгэцийн эрүүл мэнд, архи тамхины хор уршиг сэдвүүдээр Ерөнхий боловсролын сургуулийн 1212 сурагчдад сургалт зохион байгуулсан.<br>Дэлхийн зөн ОУБ, Госхот өрхийн эрүүл мэндийн төвтэй хамтран “Дэлгэцийн донтолт” сургалтыг 12-р сургуулийн 208 сурагчдад зохион байгуулсан.<br>Сэтгэцийн тасгаас Цэц.мн сайтаар 3 удаа, орон нутгийн ТВ-д ярилцлага, зөвөлгөө, мэдээ мэдээлэл 4 удаа өгч ажилласан.<br>ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад Эссэ бичлэгийн уралдаан зарлаж 6 сургуулийн 312 хүүхэд оролцсон.<br>Үр дүн. Сургалт мэдээлэлд 1734 хүүхэд хамрагдсан. | 100 |
| 4.1.4 | Хүүхдийг осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна. | 1 сая | Зохион байгуулсан үйл ажиллагаанд хамрагдсан иргэд | 500 | 1000 | Монгол улсын Засгийн газрын 224 дүгээр тогтоолоор баталсан “Аюулгүй бай-Эрүүл бай” осол гэмтлийн төлөвлөгөөг Дархан сумын Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Нэгдсэн эмнэлгийн гэмтлийн тасаг зэрэг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгууллагуудын нэгдсэн уулзалт зохион байгуулж, аяны төлөвлөгөө 5 арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилт 100%.<br>“Осол гэмтлээс сэргийлье сургуулийн насны хүүхдийн ахуй осол бэртлээс сэргийлье” сэдвээр ЕБС, СӨББ-ын эмч, нийгмийн ажилтнууд 3 удаагийн сургалтад 56 ажилтан, ерөнхий боловсролын 1184 сурагчид хамрагдсан байна. 6 сэдвээр 15 удаагийн Эмчийн цахим зөвлөгөө LIVE бэлтгэн, орон нутгийн болон ЭМБ-уудын цахим хуудас, Дархан хотын хамгийн том зар зэрэг 17 цахим хуудаст байршуулан хүн амд түгээн ажилласан. Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн боловсруулсан 5 төрлийн инфографик зөвлөмжийг 256348ш иргэдэд тараасан. Дархан сумын ЗДТГ-аас гаргасан хуваарийн дагуу Бүх нийтийн цэвэрлэгээ арга хэмжээнд 62 төрийн байгууллагын 1836 албан хаагч нар нийтийн эзэмшлийн болон иргэд ихээр зорчдог 51294 м2 зам талбайн цас мөсийг цэвэрлэж ажилласан. ХХҮГ-тай хамтран нийтийг хамарсан ажилд хүнсний эрхийн бичиг авдаг 80 иргэнийг түр ажлын байраар хангаж 3 хоногийн хугацаанд 78 байршилд 15600м2 зам талбайн цас мөсийг цэвэрлэх арга хэмжээнд хамруулсан байна. | |
| 4.1.5 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэн эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод орчны тохижилт (тэргэнцэрт зориулсан үүдний хэсэг, хананы бариул, дуугүй хөтөч, тусгайлсан жорлон, дуут дохио гэх мэт)-ыг сайжруулна. | 1 сая | ХБИ-ийн тусламж үйлчилгээ авах нөхцөл сайжруулахтай холбоотой тохижилт хийгдсэн ЭМБ-ын тоо | 4 ЭМБ | 4 ЭМБ-д ХБИ-ийн тусламж үйлчилгээ авах нөхцөл сайжруулахтай холбоотой тохижилт хийх | Нэгдсэн эмнэлэг нь үйлчлүүлэгчийн ая тухыг хангах, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэн ажиллахаар дараах тохижилтыг хийсэн. Үүнд: Тэргэнцэртэй хүн орж гарахад саадгүй орчин бүрдүүлэх зорилгоор Мэдрэлийн тасаг үүдний хаалгаа шинэчилж /1,850,000 төгрөг/-ний тохижилт хийсэн. ХБИ зориулсан 6 төрлийн тоног төхөөрөмж хандиваар авч эмчилгээ үйлчилгээнд хэрэглэсэн. Тунгалаг аялгуу ХХК-тай хамтран 172 гаруй сонсголын бэрхшээлтэй иргэдэд сонсголын аппарат өгсөн. Хүлээн авах тасгийн гадна үүдэнд ХБИ тэргэнцэртэй иргэдэд | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зориулсан хонх байрлуулсан. Амбулатори 2 дуугүй хөтөчийг байрлуулсан.<br><br>Орхон СЭМТ нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан түрдэг тэргэнцэр-2ш, хооллолтын ширээ-1ш, дугуйт тэргэнцэр-1ш, 00 өрөөний суултуурын урд хэсэгт бариулыг байрлуулсан. Хараагүй иргэд болон сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан бариал үсгийн хавтанг хүлээн авах тасагт байрлуулсан.<br><br>Аминхолбоо ӨЭМТ Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан явган хүний зам, налуу шат, машины зогсоолын тэмдэг, тэмдэглэгээ болон нойлын суултуур, угаалтуурын бариулуудыг шинээр хийсэн.<br>Госхот ӨЭМТ Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн явах налуу замыг завсарласан.<br>Хүүхдийн тасгийн эмч нар өрх сумын эмч нарт Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд нийгэм хамгаалал, хүүхдийн суурь өвчний эрт үеийн оношлогоо эмчилгээ сэдвээр сургалт хийсэн. | |
| **Зорилго 2. Хүн амд нэн шаардлагатай, хүн төвтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ.** | | | | | | | |
| **Зорилт 2.1. Эмнэлгийн анхан болон хоёрдугаар шатлалын эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, багцын стандартыг хангуулах үйл ажиллагааг зохион байгуулах** | | | | | | | |
| 2.1.1 | Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулах гүйцэтгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хяналт тавин ажиллана. | - | Өрхийн гүйцэтгэлийн гэрээний үнэлгээний хувь | Өрхийн гүйцэтгэлийн дундаж үнэлгээ 90-100% үнэлэгдэж, бүрэн хангалттай дүгнэгдсэн. | Дундаж үнэлгээ 95% | Эрүүл мэндийн сайдын 2022 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн “Журам, гэрээний загвар, шалгуур үзүүлэлт батлах тухай” А/104 дүгээр тушаалын дагуу аймгийн Засаг дарга, ЭМГ, ӨЭМТ хамтарсан гурвалсан гэрээ байгуулан ажиллаж байна.<br>2022 оны 08 сарын 16 өдрийн Засаг даргын 01-А/227 захирамжаар Өрхийн эрүүл мэндийн төвтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг дүгнэх ажлын хэсгийг шинэчилэн байгуулсан.<br>ЭМС-н А/104 дугаар тушаалын 3-р хавсралтаар батлагдсан гүйцэтгэлийн шалгуурын дагуу | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Өрхийн Эрүүл Мэндийн Төвтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийн хяналтыг ажлын хэсэг ажиллан үнэлгээ хийсэн. ӨЭМТ багцын хэрэгжилт 95.3%.<br>Үр дүн: ӨЭМТ-д ЭМС-н А/104 дугаар тушаалын дагуу Аймгийн Засаг Дарга, ЭМГ-ын даргатай гүйцэтгэлийн гэрээг байгуулан 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гарган, төлөвлөгөөний хэрэгжилт 95.3%-тай байна. | |
| 2.1.2 | Сумын эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээний багцын хэрэгжилтийг хангуулах, /эх хүүхдийн, шүдний, уламжлалт эмчилгээний/ тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж , стандартын хэрэгжилтийг хангуулж ажиллана. | 500.000 | СЭМТ багцын хэрэгжилийн хувь | СЭМТ багцын хэрэгжилийн хувь 97.0% | СЭМТ багцын хэрэгжилийн хувь 97.5 % | Сумын ЭМТ багцын хэрэгжилт 97.1%-тай байна. 3 СЭМТ СЭМТ-үүд тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж шүдний эмчийг орон тоогоор ажилллуулан, иж бүрэн тоног төхөөрөмжөөр ханган тусламж үйлчилгээг 2387 иргэнд үзүүлсэн байна. Үүнд:<br><br>Хонгор орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 60,0 сая төгрөгийн шүдний тоног төхөөрөмжөөр хангагдан 189 хүүхэд шүдний эмчийн үзлэгт хамрагдаж эмчилгээ хийлгэсэн. Эрүүлжилт 135 хүүхэд буюу 71.4%. Орон нутгийн хөгжлийн сангаар төсөв /24,4 сая/ төгрөг бүхий 5 төрлийн тоног төхөөрөмжийг тусламж үйлчилгээндээ хэрэглэж 680 гаруй иргэнд тусламж үйлчилгээ үзүүлсэн.<br><br>Орхон СЭМТ нь шүдний эмчийг орон тоогоор ажиллуулж шинээр 7 хоногт 1 удаа явуулын байдлаар тусламж үйлчилгээг 64 иргэнд үзүүлсэн ба шүдний кабинетаар 265 иргэн үйлчлүүлж, эрүүлжилт 78,1% байна.<br><br>Шарын голын шүдний үзлэг 1869 илэрсэн өвчлөл 103, эрүүлжилт 72% .<br><br>Үр дүн: СЭМТ-үүд тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж шүдний эмчийг орон тоогоор ажилллуулан, иж бүрэн тоног | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төхөөрөмжөөр хангаг тусламж үйлчилгээг 2387 иргэнд үзүүлсэн байна. | |
| 2.1.3 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангуулж , чанар хүртээмжийг сайжруулж ажиллана. | 100.000 | НЭ стандартын хэрэгжилтийн хувь | НЭ стандартын хэрэгжилтийн хувь 94.0% | НЭ стандартын хэрэгжилтийн хувь 95% | Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагааны стандартын хэрэгжилт 96.2%-тай байна. Иргэдэд тусламж үйлчилгээг ойртуулах, аюулгүй байдлыг хангах зорилгоор амбулатроийн нэг давхарт оношилгооны хэсэг, цахим үйлчилгээг /дуран, дүрс оношилгоо,рентген,лабортори/ төвлөрүүлэн тусламж үйлчилгээг үзүүлж байна. Дурангийн оношилгооны төв шинээр байгуулж, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлсэн. ХБЗ-ын дуран 2209, бүдүүн шулуун гэдэсний дуран 104 хүнд оношлогоо хийж урьд онтой харьцуулахад 3.5%-иар нэмэгдсэн. Дурангаар коагуляцийн аргаар 1 хүнд цус тогтоож эмчилгээ,ургацаг авах ажилбар 5 хийсэн байна.<br>Эрүүл мэндийн сайдын Эрүүл чийрэг эр хүн арга хэмжээний хүрээнд поликлиникийн тасагт ЭМС-ын А/449 тоот тушаалын дагуу эрэгтэйчүүдийн кабинетыг 9 сараас нээн ажилуулж, урологийн нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт 74 эрэгтэйчүүд хамрагдсан байна. ЭМГ-ын удирдлагын зөвлөлийн хурлаар Өсвөр үеийн кабинет ажилуулахаар шийдвэрлэсэн.<br>ЭМЯ-ны хөрөнгө оруулалтаар Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулан нийт 21007 хүн хамрагдсан байна. Мөн Амбулаторийн тасагт эмэгтэйчүүдийн кабинет нээж, 1740 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн ба умай хүзүүний эсийн шинжилгээг 149 хүнд авсан байна.<br>Амбулаторит шинээр тархины судасны допплер шинжилгээг нэвтрүүлж нийт 46 өвчтнийг хамруулсан. Зүрх судасны нэгжийн үйл ажиллагааг идэвхижүүлж 24 цагийн ЗЦБ, 24 цагийн даралтны аппарат, зүрхний хэт авиан шинжилгээ, ачаалалтай ЗЦБ зэрэг багажийн шинжилгээг албан ёсоор амбулаторийн тусламж үйлчилгээнд оруулан тогтмолжуулан ажилласан. Зүрхний судасны үзлэгийн MN кардио программын шивэлтийг 3500 хүнд хийж оношлогоог баталгаажуулсан. Чихрийн шижингийн нүдний хүндрэлийг илрүүлэх зорилгоор 611 өвчтөнд фундоскопийн аппаратаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нүдний угийг үнэлж нүдний ретинопати хөнгөн хэлбэр 58, хүндэвтэр хэлбэр 20, хүнд хэлбэрийн 12 илрүүлсэн. | |
| 2.1.4 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр гарч байгаа тушаал шийдвэрийг зохион байгуулах , хэрэгжүүлэх үйл явцад дэмжлэгт хяналт тавьж ажиллана | 2 сая | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ | Тушаал шийдвэрийн хэрэгжилтийн хувь 93% | Тушаал шийдвэрийн хэрэгжилтийн хувь 95% | ЭМС-ийн албан даалгавар 5, Эмнэлзүйн заавар 15 , Ковидын халдвартай холбоотой түр заавар журам 5, төлөвлөгөө 3, Эрт илрүүлэг үзлэг зохион байгуулах тухай 4, Ковидын дархлаажуулалтай холбоотой 2 тушаал, зөвлөмж 21 , хамтран ажиллах тухай 21 албан бичгийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. шийдвэрийг хэрэгжүүлэн Хэрэгжилт 90%.<br>Эрүүл мэндийн сайдын албан даалгаврын дагуу 6 чиглэлээр 23 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжилт 98%-тай байна.<br>ЭМС-ын 2022 оны А/139 ,ЭМГ-ийн даргын А/54, А/55, А/59 дугаар тушаалын дагуу Дархан-Уул аймагт эрт илрүүлэг үзлэг зохион байгуулах үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалт ,мэргэжил арга зүйгээр хангаж, дэмжлэгт хяналтыг 8 удаа 11 төрлийн зөвлөмж өгч ажилласан. | 100 |
| **Зорилт 2.2. Анхан шатлалд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдийн чирэгдлийг бууруулах** | | | | | | | |
| 2.2.1 | Өрх, сумын эрүүл мэндийн төвд үзүүлэх эмнэлгийн анхан шатлалын тусламж, үйлчилгээнд Мобайл технологийн хэрэгжилтийг нэмэгдүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана. | - | Хамрагдсан хүний тоо | Мобайл - 2685 | 2700 | Алслагдсан хэсгийн хөдөөгийн хүн амд зөөврийн мобайл ЭХО , ЭКГ-г тусламж үйлчилгээг **нийт** 384 өрх 2767 иргэнд үзүүлж, хоёрдугаар шатлалын эмчээс цахимаар 62 иргэнд зөвөлгөө авсан байна. | 100 |
| 2.2.2 | Алслагдсан орон нутгийн хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Явуулын эрүүл мэндийн тусламж | 3 сая | Тусламж үйлчилгээ авсан хүний тоо | Нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт-2000 | Нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт-2500 Өрх, сумын | Алслагдсан хэсгийн хөдөөгийн хүн амд “Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-г халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг болон эмзэг бүлгийн иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийх зөөврийн мобайл ЭХО , ЭКГ-ийн тусламж үйлчилгээг үзүүлж, алслагдсан багийн 746 өрхийн 2819 иргэнд үзүүлж, илэрсэн өвчлөлийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйлчилгээ”-г нэмэгдүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана. | | | Өрх, сумын эмчийн үзлэгт-2500 | эмчийн үзлэгт-2600 | эрүүлжилт 54% байна. Тусламж үйлчилгээг үзүүлж байгаа явцын хяналтыг 2 удаа дэмжлэгт хяналт хийж мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. Үүнд:<br>**Госхот**: Үзлэгт 223 айл өрхийн давхардсан тоогоор 1283 хүн хамрагдсанаас өндөр настан ахмад 22, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 23, 45 хүүхэд үзсэн. АЗӨ 11 хүүхдэд эмчилгээ зааж, зөвөлгөө өгсөн. Үзлэгт хамрагдсан иргэдээс давхардсан тоогоор 37 өвчлөл илэрсэн, эмчлэн эрүүлжүүлсэн.<br>**Хонгор ЭМТ**: Явуулын амбулаторийн тусламж үйлчилгээг нийт 9 удаа 261 өрхийн 607 иргэн үзлэгт хамрагдсан<br>Илэрсэн өвчлөл 160, эмчилгээ зааж зөвөлгөө өгсөн 87, хэвтэн эмчлүүлсэн-11, өдрийн эмчилгээнд хамрагдсан-34, дээд шатлалд илгээсэн 28 иргэн байна.<br>**Шарын гол ЭМТ:**<br>Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээгээр Хөхний өмөн, артерийн гипертензи, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэг, ВС вирус илрүүлэх шинжилгээ, сахар холестирины шинжилгээг 168 өрхийн 542 иргэдэд үзүүлсэн. Ковид 19 халдварын 3, 4-р тунгийн дархлаажуулалтанд хамруулах ажлуудыг тус тус хийсэн.<br>**Орхон ЭМТ**: Явуулын амбулаторын үйлчилгээг хөдөөгийн 94 өрхийн 387 иргэнд үзүүлсэн байна. Энхтал багийн архаг хууч өвчтэй 39 иргэнд сар бүр Энхтал багийн эмчийн байранд ЭМТ-ийн дарга үзлэг хийж хөнгөлөлттэй үнийн эмийн жорыг бичиж үйлчилж байна.<br>Давхардсан тоогоор 330 иргэнд үзлэг хийж хөнгөлөлттэй үнийн эмийн жорыг бичиж үйлчилсэн байна.<br>Үр дүн: “Явуулын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ”-г 746 өрхийн 2819 иргэнд үзүүлж, илэрсэн өвчлөлийн эрүүлжилт 54% байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.2.3 | Анхан шатны тусламж үйлчилгээнд Монг-ПЭН, Халдварт бус өвчин, зүрх судасны өвчнөөс сэргийлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулан үр дүнг тооцож ажиллана. | 20 сая | Хамрагдсан хүний тоо, хувь Хяналтад орсон хүн | Хамрагдалтын хувь 68 | Хамрагдалтыг 70% хүргэнэ. | МОНПЭН санаачлагын хүрээнд ХБӨ/ЗСӨ-өөс сэргийлэх, хянах тусламж үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай багцыг ЭМАШТҮ-ний түвшинд хэрэгжүүлэхэд мэргэжил аргазүйгээр хангах, үр дүнг тооцож, зөвлөмж өгөх зорилгоор сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд дэмжлэгт хяналт, үнэлгээ хийж 18 төрлийн зөвлөмж хүргүүлж ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилтийн дагуу дэмжлэгт хяналтыг 2 удаа зохион байгуулсан. Дэмжлэгт хяналтыг 4 чиглэлээр 18 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийж 8 төрлийн зөвлөмж өгч арга зүйгээр хanган ажилласан. ЭМГ-аас Монпэн санаачлагын хэрэгжилтийг сайжруулах, эмч мэргэжилтний чадавхийг сайжруулахаар сургалт зохион байгуулж,14 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Монпэн санаачлагын хүрээнд ашиглагдаж буй MN.Cardio цахим програмын ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор УГТЭ-н мэргэжилтэнтэй хамтран ZOOM-р сургалт зохион байгуулж 17 эмч хамрагдсан. MN.Cardio цахим програмд нэвтрэх эрхийг өрх, сумын ЭМТ-ийн 12 эмчид шинээр нээж, ашиглах видео хичээлийг хүргүүлсэн. | 70 |
| **Зорилт 2.3. Эмнэлгийн тусламж үйчилгээнд оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах, дэвшилтэт технологийг хөгжүүлэх, Эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх, мэдээлэл солилцох үйл ажиллагааг зохион байгуулна.** | | | | | | | |
| 2.3.1 | Нэгдсэн эмнэлгийн оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулах, дэвшилтэт технологийг нутагшуулахад лавлагаа шатлалын эмнэлгээс мэргэжлийн багуудыг урьж хамтран ажиллана. | 200 сая | Дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн байдал | Нэвтрүүлсэн шинэ технологи 4 | Нэвтрүүлэх шинэ технологи-4 | Нэгдсэн эмнэлэг нь УНТЭ-тэй гэрээ байгуулан ажиллаж байна. Эмгэг нярайн тасаг, мэдрэл тасаг, сэргээн засах тасаг, амаржих, сувилахуй алба дээд шатны байгууллага болох “Амгалан амаржих газар”, ХСҮТ, АШУҮИС-н Монгол-Японы эмнэлэг, ШУГТЭ, УНТЭ, ЭХЭМҮТөвтэй ажлын байрны туршлага судлан мэдлэг, үр чадвараа дээшлүүлсэн.<br>УНТЭ-ийн чих хамар хоолойн их эмч нар “Дэлхийн сонсгол хамгаалах өдөр”-ийг угтан Нэгдсэн эмнэлгийн чих хамар хоолойн эмч нартай хамтран<br>➢ Сонсгол сайжруулах нөхөн сэргээх хагалгаа-3<br>➢ Тонзилэктоми хагалгаа-6<br>➢ Хамрын муруйлт засах хагалгаа 2 хийж эмчилгээний үр дүн 100%. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Гэмтлийн тасгийн их эмч нар нөхөн сэргээх протезийн төвтэй хамтран түнхний үе, өвдөгний үе солих хагалгааг 7 өвчтөнд амжилтай хийсэн.<br>Мэс заслын эмч нар УНТЭ-ийн эмч нартай хамтран бүдүүн гэдэсний хавдрын хагалгааг 3 өвчтөнд хийсэн.<br>ЭМЯ-ны санхүүжилтээр мэс заслын тасагт бөөр, шээсний доод замын дурангийн хагалгааны багаж тоног төхөөрөмж суурилуулан УНТЭ-ийн Урологи-андрологийн төвийн багтай хамтран түрүү булчирхайг дурангаар авах мэс засал , давсагны чулуу авах мэс заслыг нэвтрүүлэн 4 иргэнд мэс засал хийсэн байна.<br><br>Нутагшуулсан дэвшилтэт технологи:<br><br>-“Эгэм далны шонтонгийн холбоосны тасралыг эгэмний шудтэй хадаасаар хадаж бэхлэх” мэс засал 4. Эдгэрэлтийн хувь 100%<br><br>- Ходоодны бүрэн урагдлыг оёж сэргээх мэс засал 1<br>-Гар сарвууны шөрмөс, мэдрэл судас залгах мэс заслын хагалгаа 14<br>- Олон хавирганы, тойг ясны хугарлыг цагираган титан бэхэлгээгээр бэхлэх мэс заслын хагалгааг 8<br>-Хэвлийн диализын гуурс тавих, солих, Бөөрний шээлгүүрт гуурс тавих<br>-Урологийн дурангийн мэс засал / түрүү булчирхай, давсаг/<br>- Чих хамар хоолойд хэнгэрэг нөхөх мэс заслыг шинээр нэвтрүүлэж УНТЭ-ийн эмч нартай хамтран хэнгэрэг нөхөх мэс заслыг 5 хүн, залгиурын буглаа 12 хүнд<br><br>-Ухархайн хана нөхөн сэргээх мэс засал 1 хүнд тус тус хийсэн байна. | |
| 2.3.2 | Эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх, мэдээлэл солилцох эргэн мэдээлэх хянах журмыг батлуулан тусламж, үйлчилгээний | 3 сая | - Үйлчлүүлэгчийг шилжүүлэх, мэдээлэл солилцох бүртгэл | Улаанбаатар хот руу 3073 иргэн 13/А маягтаар явж үйлчлүүл | УБ явах урсгалыг 10%-иар бууруулах | Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Эрүүл мэндийн байгууллага болон шатлал хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх журам” А/813 дугаар тушаалаар батлагдсан журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх, мэдээлэл | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чирэгдлийг бууруулж мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана. | | | сэн байна. | | солилцох эргэн мэдээлэх хянах журмын хэрэгжилтийг хангуулахаар ЭМТҮХ-ээс дэмжлэгт хяналтыг 2 удаа 5 төрлийн зөвлөмж өгч ажилласан. Хөдөлмөрийн чадвар түр алдалтын хуудас, жирэмсэн эхийн амаржсаны хуудас бүрэн цахимжсан. Иргэний авах лист буюу эмнэлгийн хуудас нь цахимаар тухайн иргэний ажлын газар болон нийгмийн даатгалын хэлтэст цахимаар очиж байна.<br>“МетроПраграммд 13А Б маягтын хөгжүүлэлт хийгдэж байгаа.<br>Иргэдэд тусламж, үйлчилгээг түргэн шуурхай, хялбар олгоход чиглэлээр Call-pro үйлчилгээг нэвтрүүлж дуудлагын 2 оператор цахим бүртгэлийн 5 бүртгэгчтэй болж хүлээгдэлийг бууруулах чиглэлээр ажиллаж үйлчлүүлэгчийг эргэн дуудах, цаг авсан үйлчлүүлэгчтэй 1 хоногийн өмнө холбогдон үзүүлэх цагийг баталгаажуулж арга хэмжээг авч ажиллаж байна.<br>Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Цахим бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-0119 үйлчилгээнд Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг холбогдож дуудлагын утсаар цаг авсан иргэд 35856, биеэр ирж цаг авч үйлчлүүлсэн иргэд нийт 294486 байна. Оройн амбулаториор цахимаар цаг авч үйлчлүүлсэн нийт иргэд 2625.<br><br>13А маягтаар Улаанбаатар хот руу 5191 иргэн үйлчлүүлсэн. Б мягтаар 141, Өрх сумаас 13А мягтаар 18525 иргэн ирж үйлчлүүлсэн. Урьд оны мөн үетэй харьцуулахад 11.5%-иар өссөн байна. | |
| **Зорилт 2.4. Жирэмсэн эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний чанар үр дүнг сайжруулах** | | | | | | | |
| 2.4.1 | Жирэмсний эрт үеийн хяналт цахим болон кабинетийн хамралтыг нэмэгдүүлж, яаралтай эрэмбэлэн ангилалтыг | 1 сая | Эрт хамралтын хувь | 95.0% | 96% | Жирэмсний эрт үеийн хяналтын хамралт 94.6% байна.Мөн эрт үеийн хамрагдалтыг нэмэгдүүлэх зорилгоор Өрх сумын ЭМТ-ийн эх баригч, эмч нарт "Жирэмсний хяналт" сургалтыг зохион байгуулсан. Жирэмсэн, төрөлт, төрсний дараах үе болон эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээг | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулахад мэргэжил арга зүйгээр хханган ажиллана. | | | | | сайжруулах зорилгоор 2022 оны 3 болон 4 саруудад эх барихын 10 эмч ӨЭМТ,сумдын ЭМТ-ын дарга нар болон ЭМТҮХ-ийн мэргэжилтэнгүүдийн хамтрасан хурлыг зохион байгуулж ,хяналтыг сайжруулах чиглэлээр 4 шийдвэр гаргаж хэргэжилт 100%. | |
| 2.4.2 | Эхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр гарч байгаа тушаал, шийдвэрийг хэрэгжүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | 1 сая | Тушаалын хэрэгжилтийн хувь | 95.0% | 96.0% | ЭХЭМҮТ-өөс тандалт судалгааны баг НЭ-ийн төрөлтийн түүх болон нярайн түүх бичилт, анхан шатны бичиг баримтын хөтлөлт, тушаал удирдамжийн хэрэгжилтэд дэмжлэгт хяналт хийж, дүгнэлт зөвлөмж өгсөн. Өгсөн зөвлөмжийн дагуу 3 СЭМТ-д дэмжлэгт хяналт хийж, ажил сайжруулахаар 11 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжилт 95% байна.<br>Мөн дотоодын хяналтыг НЭ-ийн төрөх тасаг болон Поликлиникийн ӨӨЖХ-ийн 4 кабинет, 5 ӨЭМТ, 3 СЭМТ-д нийт 3 удаа хийж, 5 төрлийн зөвлөмж өгөн, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байна. Зөвлөмжийн хэрэгжилт 100%. Улаанбаатар хотод зохион байгуулсан Эх хүүхэд өсвөр үеийн 5-р чуулганд оролцож, зөвөлгөөнөөс гарсан зөвлөмж шийдвэрийг эх барих эмэгтэйчүүдийн их эмч болон эх баригч нарт сурталчилах өдөрлөгийг зохион байгуулж нийт 24 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>ЭМГ-ын даргын баталсан удирдамжын дагуу Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд 4 удаа ХШҮ-ний багтай хамтран эх барих эмэгтэйчүүд, жирэмсэн эхийн хяналтын явцад дэмжлэгт хяналт хийж 8 төрлийн зөвлөмж өгч зөвлөмжийн хэрэгжилт 84 хувьтай байна.<br>Зөвлөмжийн дундаж хэрэгжилт 93% байна. | 90 |
| 2.4.3 | Жирэмсэн үеийн ХДХВ, тэмбүү, гепатитын В, С, вирусийн илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, бэлгийн | 1 сая | Хамрагдсан иргэдийн тоо Эрүүлжилт | Тэмбүү 9 Гепатитын В, С, вирустэй 74<br><br>Эрүүлжилт 98.6% | Эрүүлжилт 100% | Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын жирэмсний хяналтад шинээр орсон 1585 (давхардсан тоо 3170) жирэмсэн эмэгтэйд Зонхилон тохиолдох БЗДХ/ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээг авахад 45 шинэ өвчлөл бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад 6 тохиолдолоор /14,4%/-иар нэмэгдсэн байна. Зонхилон тохиолдох БЗДХ-ын 156 шинэ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хавьтагчийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний үр дүнг тооцож ажиллана. | | | | | тохиолдлын 28,8 % жирэмсэн эмэгтэйчүүдийн өвчлөл ээлж байна. Өвчлөлийг 100% хяналтад авч эмчлэн эрүүлжүүлсэн. | |
| 2.4.4 | Эхийн эндэгдэл, жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой хүндрэл гарахаас сэргийлэх чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулна. | 5 сая | Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо Хамрагдсан эмч эмнэлгийн ажилтны тоо | 12 удаа 86 эмч эмнэлгийн мэргэжилтэн | 12 удаа 100 эмч мэргэжилтэн | Жирэмсэн, төрөлт, төрсний дараах үе болон эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээг сайжруулах зөвөлгөөнийг зохион байгуулж 18 удирдах ажилтан оролцож, зүрхний эмгэгтэй жирэмсэн эмэгтэйчүүдийг хянадаг зүрхний эмчтэй болсон.<br>ЭХЭМҮТ болон Амгалан амаржих газар ЭБЭ-ийн эмч, эх баригч нар ажлын байрны дадлагажих сургалтад 2 эмч хамрагдсан. Богино хугацааны мэргэшүүлэх, дээшлүүлэх сургалтад 3 эмч хамрагдсан.<br>ЭМЯ, ДЭМБ-аас НЭҮНШТ-ийн хэрэгжилтийг эрчимжүүлэх 2 өдрийн сургалтанд 3 эмч хамрагдсан.<br>ЭМЯ, ЭХЭМҮТ-өөс зохион байгуулсан эхийн ноцтой хүндрэл нас баралтаас сэргийлэх сэдэвт 3 удаагийн цахим хуралд давхардсан тоогоор 24 Эх барих эмэгтэйчүүдийн эмч, эх баригч нар хамрагдсан.<br>Эх барих эмэгтэйчүүдийн нийгэмлэгтэй хамтран жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслэл сэдэвт танхимын сургалтад 10 байгууллагын 10 эх баригч, бага эмч мэргэжилтэнг хамруулсан байна. | 90 |
| 2.4.5 | Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд “Гарц” арга хэмжээг хувийн хэвшлийн эмнэлгүүдтэй зохион байгуулахад мэргэжил арга зүйгээр ханган дэмжлэгт хяналтаар ажиллана. | 10 сая | - Хамрагдсан хүний тоо, хувь - Эрүүлжилт | -1676 буюу 93.3%<br>- Эрүүлжилт 100% | -Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийг 100% хамруулна.<br>Эрүүлжилт 100% | Зорилтод бүлгийн эмэгтэйчүүдэд “Гарц” арга хэмжээг хувийн хэвшлийн эмэгтэйчүүдийн 9 эмнэлэгтэй хамтран зохион байгуулсан. Үзлэгтэй холбоотой хэвлэлийн бага хурал зохион байгуулсан. Үзлэгт хамрагдвал зохих 638 эмэгтэйчүүдээс хамрагдсан 576 буюу 90.5% байна. Үүнээс 171 өвчлөл илэрснийг 100 % эмчлэн эрүүлжүүлсэн. Зорилтод бүлгийн эмэгтэйчүүдийг гэр бүл төлөвлөлтийн жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэлд 367 хамруулсан . Үүнд: бэлгэвч 39 | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүнд 591ш, тариа 86 хүнд, ерөндөг 79 хүнд, жирэмснээс хамгаалах эм 123 хүн, суулгац 40 хүнийг тус тус хамруулсан байна. | |
| 2.4.6 | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг гэр бүл төлөвлөлт, жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэлд хамруулахад мэргэжил арга зүйгээр хангаж үр дүнг тооцож ажиллана. | 16 сая | -Хамрагдсан тоо, төрөл | ЖСА 9471 буюу 37% хамрагдсан. | ЖСА хэрэгслэлийн хангалтыг 50% хүргэнэ | Нөхөн үржихүйн насны нийт 9561 эмэгтэйн бүртгэлийг шинэчилж эмзэг болон эрсдэлт бүлгээр асуумжийн дагуу гаргаж жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга хэрэглэж гэр бүл төлөвлөлтөд 582 эмэгтэй хамрагдсан байна. Үүнээс зорилтот бүлгийн 114 эмэгтэй ЖСАХ-д хамрагдсан. ГБТ-ийн орчин үеийн аргуудаар зөвлөгөө өгөх, мэдлэг ур чадвар сургалтыг Эх барих эмэгтэйчүүдийн нийгэмлэгтэй хамтран эмэгтэйчүүдийн эмч, эх баригч, эмэгтэйчүүдийн сувилагч 36 хамрагдсан. Нөхөн үржихүйн эрүүл мэнд сэдэвт сургалтыг тэргэнцэртэй иргэдийн холбоотой хамтран зохион байгуулсан. “Гэр бүл төлөвлөлт, Хөх умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэг, Эрүүл зөв зохистой хооллолт” зэрэг сэдвээр сургалт зохион байгуулж, 18 эмэгтэйд эмэгтэйчүүдийн тусгайлсан үзлэг хийж ЭХО-д харан эмчилгээ зөвлөгөө өгсөн.<br>Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийг гэр бүл төлөвлөлт, жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэлд хамруулах сургалтыг 12 удаа зохион байгуулж, 1586 эмэгтэйчүүд хамрагдсан. Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн 63.7% ЖСА-д хамруулсан. Орон нутгийн ТВ-ийн ярилцлага, хэлэлцүүлэгт 3 удаа оролцож мэдээлэл өгсөн. | 100 |
| 2.4.7 | Эмэгтэйчүүдийн үзлэгийн кабинет шинээр нээж, үйл ажиллагааг тогтворжуулахад | 10 сая | Шаардагатай тоног төхөөрөмжийн хангалт | - | -Кабинет үйл ажиллагаа эхэлж | Эмэгтэйчүүдийн үзлэгийн кабинетыг нээн 3 төрлийн тоног төхөөрөмжөөр ханган, нийт 1740 эмэгтэйд үзлэг хийж, эрт илрүүлэг умайн хүзүүний эсийн шинжилгээг 56 эмэгтэйгээс авсан байна. 1-р улиралд ажиллаж эхэлсэн. Одоогоор | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэжил арга зүйгээр хангаан ажиллана. | | | | 3 төрлийн тоног төхөөрөмж өөр хангана | зуны ээлжийн амралт, эмчийн дутагдлаас ӨӨЖХК-ийн эмч нар жирэмсэн эх болон эмэгтэйчүүдийг давхар үзэж хянаж байна. | |
| **Зорилт 2.5. Хүүхэд, нярайн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, бага насны хүүхдийн суурь өвчин, гүйлсэн булчирхайн эмгэгийг эмчлэх тусламж үйлчилгээний чанар үр дүнг сайжруулах** | | | | | | | |
| 2.5.1 | Нярайн тусламж үйлчилгээг өргөжүүлж, нярайн скрининг (түнх, зулай ЭХО, нярайн сонсголын скрининг) үзлэгийн чанар үр дүнг сайжруулахад мэргэжил арга зүйгээр хангаан үр дүнг тооцож ажиллана. | 10 сая | -Нярайн скрининг хамрагдсан хүүхдийн үр дүн, хувь | Сурфактант 15 73.3%<br>Билимет р 856<br>Фото эмчилгээ 602<br>Түнх 1681<br>Зулай 34<br>Сонсгол 60 | Төрсөн нярайд скрининг үзлэг 100% хийх | Нярайн гаж хөгжлийг эрт үед нь илрүүлэх, урьдчилан сэргийлэх сонсголын скренинг үзлэгийг 42 нярайд хийж 4 нярай сонсгол бэрхшээлийг эрт илрүүлж зөвлөгөө өгөв.<br>Нярайн зулайн ЭХО 26 хүүхдэд хийж хүнд хэлбэрийн 2 гажгийг илрүүлэн дээд шатлалын эмнэлэгт шилжүүлсэн.<br>- CPAP эмчилгээ 17 нярай<br>- Коффейн цитрат 48 нярай<br>- Сурфактант эмчилгээг 17 нярайд хийж эмчилгээний үр дүнг 75%.<br>Бүтэлттэй төрсөн нярайн тархийг хамгаалах зорилгоор кортоксин 114 нярайд, Магнизм 3 тун эмчилгээг 28 нярайд хэрэглэж эмчилгээний үр дүн 100%.<br>Түнхний дутуу хөгжлийг эрт илрүүлэх хэт авиан скрининг оношилгоо буюу Түнхний ЭХО-г 1279 нярайг 100% хамруулсан.<br>Шинээр төрсөн 1738 нярайгаас 425 нярайд фото эмчилгээ хийж эмчилгээний үр дүн 100%. | 100 |
| 2.5.2 | 9, 18, 36 сартай хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, өвчлөл илэрсэн хүүхдүүдийг эмчлэн эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | 2 сая | -Хамрагдсан хүүхдийн тоо<br>Эрүүлжүүлсэн хүүхдийн тоо | 200 | 900 | Хүүхдийн тасагт 5 өрхийн эмнэлгийн залуу эмч ирж хамтарсан үзлэг хийж, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний талаар сургалт хийж арга зүйн зөвлөгөө өгсөн. Аминхолбоо өрхийн эмнэлэгт НЭ-ийн хүүхдийн тасгийн эрхлэгч үзлэг хийж хөгжлийн хоцрогдолтой 41 хүүхдийг эрт үед нь илрүүлж эмчилгээ, зөвлөгөө өгч ажилласан.<br>9,18,36 сартай хүүхдүүдийн хөгжлийн хоцрогдолыг эрт илрүүлэх үзлэгт 4345 хүүхэд суурь өвчлөл илэрсэн 315 хүүхдийг эмчилгээ хийж, хөгжлийн хоцрогдолтой 3 хүүхдийг дээд шатлалын эрүүл мэндийн байгууллагад илгээсэн. | 100 |
| 2.5.3 | Гүйлсэн булчирхайн эмгэгийг “Нэг цэгийн үйлчилгээ”-ээр эмчлэн | 1 сая | -Эмчилгээнд | 166 хүүхэд хамрагдсан. | Хамруулах хүүхдийн тоо | ӨЭМТ СЭМТ Өрх сумын эрүүл мэндийн төвийн гүйлсэн булчирхайн нэг цэгт 185 хүүхэд эмчилгээнд хамрагдаж, эмийн эмчилгээгээр 126, мэс заслын хагалгаагаар 24 хүүхэд, уламжлалт | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | эрүүлжүүлэхэд мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана | | хамрагдсан хүүхдийн эрүүлжилтийн хувь | Эрүүлжилт 55% | Эрүүлжилт 60% | болон нөхөн сэргээх эмчилгээнд 35 хүүхэд хамрагдсан ба эрүүлжилт 73% | |
| 2.5.4 | Суурь өвчтэй бага насны хүүхдүүдийг эмчлэн эрүүлжүүлэх, зуны чийрэгжүүлэх сувилалд хамруулна. | 5 сая | - Хамрагдсан хүүхдийн тоо | 343 хүүхэд | 450 хүүхэд | АЗДТГ-ын дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн газар, өрхийн эрүүл мэндийн төвүүд хамтран эрүүлжүүлэн чийрэгжүүлэх зуны сувилалд 7 ээлжээр 603 хүүхэд хамрагдсан. Сувилалд хамрагдсан хүүхдүүдийн 92% нь 200-900 гр жин нэмэгдэж, хөлрөх, цочромтгой болох, шээс үнэртэй гарах зовиурууд багассан зэрэг үр дүн гарсан. Сувилалд хамрагдсан хүүхдийн эцэг эхчүүдэд Хүүхдийн зонхилон тохиолдох өвчлөл, хүндрэлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн зөв зохистой хооллолт, чийрэгжүүлэлтийн талаар эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг хийсэн. | 100 |
| 2.5.5 | Өрх сумын эрүүл мэндийн төвүүдэд хүүхдийн эмчийн өдөрлөгийг зохион байгуулж, суурь өвчтэй хүүхдийн хяналтыг сайжруулна | 5 сая | -Өдөрлөгт хамрагдсан эмч эмнэлгийн мэрэгжилтэн хүүхдийн тоо | 300 хүүхэд | 400 хүүхэд | "ХҮҮХДИЙН ЭМЧИЙН ӨДӨРЛӨГ"-ийг ӨЭМТ-үүдэд зохион байгууллаа. Үзлэгт 380 хүүхдийг хамруулж, эцэг эх асран хамгаалагч нарт мэдлэг олгох сургалтыг зохион байгуулсан.<br>Мөн хөгжлийн бэрхшээлтэй 36 хүүхдэд бариа засал хийж, "Хүүхдийн хоолны шим тэжээлийн бодисын ач холбогдол, хүүхдийн хоолыг чанартай бэлтгэх нь" сэдвээр тус тус сургалтуудыг явуулсан. | 100 |
| 2.5.6 | Шинэчилсэн ХӨЦМ болон олон нийтэд суурилсан ХӨЦМ-өөр сургалт зохион байгуулна. | 10 сая | -Сургалтын тоо<br><br>- сургалтанд хамрагдсан эмч тусгай мэргэжилтнүүдийн тоо | 5 -6 удаа Эцэг эх-200 Эмч, мэргэжилтэн-30 | 8-10 удаа 500 эцэг эх эмч мэргэжилтэн-200 | Шинэчилсэн ХӨЦМ-ийн сургагч багшаар 2 удаа нийт 4 их эмчийг бэлтгэж анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлж байгаа давхардсан тоогоор 86 их эмч сувилагч нарыг хамруулсан байна.<br><br>Өрх, сумын эрүүл мэндийн төвүүд харьяа цэцэрлэгүүдийн хүүхдийн эцэг эх асран хамгаалагч нарт ХӨЦМ-ийн сургалтыг :<br>• ХӨЦМ-ийн аюултай ерөнхий шинж<br>• Хүүхдийн халууныг хянах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | -сургалтанд хамрагдсан эцэг эхчүүдийн тоо | | | • Хүүхдийн рахитын шинж<br>• Ханиад томуунаас урьдчилан сэргийлэх<br>• Суулгалт өвчнөөс урьдчилан сэргийлэх<br>• Уушигны хатгаа өвчнөөс урьдчилан сэргийлэх<br>• Хүүхдийн хооллолт<br>• Амин дэмийн хэрэглээ сэдвүүдээр хийсэн.<br>Сургалтанд 15 цэцэрлэгийн 933 эцэг эхчүүд хамрагдсан.<br>“Goodnewbors” төслийн багтай хамтран зорилтот бүлгийн 100 хүүхдийг витаминжуулж, эцэг эх, асран хамгаалагч нарт олон нийтийн ХӨЦМ-ийн сургалтыг зохион байгуулсан. ХӨЦМ-ийн тандалтыг 5 өрхийн эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдэд хийсэн. Тандалтанд 32 эмч эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан. | |
| 2.5.7 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сэргээн засах эмчилгээнд хамруулах, тэдний эцэг асран хамгаалагчдыг асаргаа сувилгаа хийх сургалтад хамруулна. | 1 сая | -Эмчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо | -132 хүүхэд сэргээн засах бариа гэрээр хийсэн. | 150 хүүхдэд сэргээн засах бариа хийх | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах кабинетаар 316 хүүхдэд сэргээн засах эмчилгээ хийсэн.<br>➢ Гилжгий-28<br>➢ Өсөлт хөгжилтийн хоцрогдол-35<br>➢ Толгойн бариа--31<br>➢ Майга тавхай-4<br>➢ Цэр суллах доргионт массаж--38<br>➢ Хүчилтөрөгчийн дутмагшил-61<br>➢ булчингын чангарал-32<br>1 хүүхэд буюу 72.8 % эдгэрсэн байна. “Зөв хооллолт, асаргаа сувилгаа сэргээн засах эмчилгээг гэрийн нөхцөлд хийх арга зүй” зөвлөгөөг 147 эцэг эх, асран хамгаалагчдад өгсөн. | 100 |
| **Зорилт 2.6. Олон улсад хүлээн зөвшөөрсөн эмнэлзүйн заавар, стандартад суурилсан, оношилгоо, эмчилгээг нэвтрүүлэх** | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.6.1 | Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд тусламж үйлчилгээний эмнэл зүйн олон улсын удирдамж "Up to Date" платформыг нэвтрүүлж бүх эмч нар ашиглах боломжийг хангана. | 10 сая | "Up to Date" платформыг нэвтрүүлж, ашигласан байдал | -"Up to Date" платформыг 67 эмч хэрэглэж байна | "Up to Date" платформыг хэрэглэдэг эмчийг 15%-иар нэмэгдүүлэх | НЭ-т тусламж үйлчилгээний эмнэл зүйн олон улсын удирдамж "Up to Date" платформыг 116 эмч, 5 өрх 3 сумын хэмжээнд "Up to Date" платформыг нийт 36 эмч ашиглаж байна. Урьд онтой харьцуулахад "Up to Date" платформыг хэрэглэдэг эмнэлгийн мэргэжилтэн 2 дахин нэмэгдсэн байна. | 100 |
| 2.6.2 | Яаралтай тусламжийн нэгжийг бэхжүүлэхээр тоног төхөөрөмж, автомашины парк шинэчлэлийг хийж, . тусламж үйлчилгээний чанарыг сайжруулна. | 50 сая. | шаардлага хангасан автомашин, тоног төхөөрөмж өөр хангасан байх | Нэгдсэн эмнэлэг 1автомашинаар Орхон сумын эрүүл мэндийн төв-1 хангагдсан. | Тоног төхөөрөмж 2, автомашин 1 | Нэгдсэн эмнэлгийн яаралтай тусламжийн менежментийг сайжруулах зорилгоор Яаралтай тусламжийн тасаг 4 их эмч, 9 сувилагчтайгаар тусламжийг үзүүлж байна.<br><br>Яаралтай түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлдэг 13 ажилтан нийслэлийн түргэн тусламжийн төвийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судалсан. Яаралтай түргэн тусламжийн тасагт зөөврийн амьсгалын аппарат 1, явуулын зүрхний бичлэг 1, Өвчтөний хяналтын монитор 1 хангагдсан.<br><br>Нэгдсэн эмнэлэг 2022 оны 03 сарын 20-нд түргэн тусламжийн 5 машинд монитор хүлээн авсан. БНСУ-ын Кёнги аймгийн буцалтгүй тусламжаар 2 ширхэг түргэн тусламжийн машин, ЭМЯ-аас 1 ш машин хүлээн авч парк шинэчлэл хийсэн байна. Гэрэлтэй ӨЭМТ СЗДТГ-аас prius 30 автомашин хандивласан.<br><br>**Үр дүн**: 3 төрлийн аппарат, тоног төхөөрөмжөөр хангагдаж, 4 автомашинаар парк шинэчлэл хийсэн. | 100 |
| **Зорилт 2.7. Уламжлалт анагаах ухаан, хөнгөвчлөх, сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах** | | | | | | | |
| 2.7.1 | Уламжлалт анагаах ухааны үйл ажиллагааг өргөжүүлэн, хүний нөөцийг дэмжихэд | 5 сая | -Сургалтад хамрагдсан ажилтны тоо | Уламжлалтын 30 ортой тасагтай болсон. | -Сургалтад хамрагдсан ажилтны тоо-14 | Хүний нөөцийг чадавхижуулах танхимын сургалтад 8, цахим сургалтад 12 мэргэжилтэн хамрагдсан. Гамшгийн үеийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээ богино багц цагийн сургалтад 3 сувилагч хамрагдсан. Уламжлалт эмчилгээний тасаг нь 30 ортой, 1 их эмч, 6 сувилагч, 1 үйлчлэгчтэйгээр үйл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэжил арга зүйгээр хангаж ажиллана . | | -Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо | 288 иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлсэн | -Тусламж үйлчилгээ авсан иргэд гүйцэтгэлээр | ажиллагаа явуулж 10 нэр төрлийн цахилгаан болон гэрэл эмчилгээний аппаратыг ажиллуулж байна.<br>Улаан гэрлийн шарлага-26.8%<br>Цахилгаан төөнө-38.8%<br>Цахилгаан бумба-59.6%<br>Парафин-29.9%<br>Даралтат массаж аппарат-68.6%<br>Хэт авиан аппарат-8.6%<br>Цахилгаан зүү-2.9%<br>Искра-19.7%<br>УВЧ-2.8<br>Хүзүү, нурууны татлага-1.9%-тай хэвтэн эмчлүүлэгчдэд уламжлалт эмчилгээтэй хавсран хийснээр эмчилгээний үр дүн сайжирсан. Нийт 889 хүнд тусламж үйлчилгээ үзүүлсэн. 2022 оны 10-р сараас Уламжлалтын амбулатори ажиллуулж эхэлсэн ба нийт 51 хүнд амбулаторийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна.<br>**Үр дүн**: Сургалтад давхардсан тоогоор 23 эмнэлгийн мэргэжилтн хамрагдсан. Уламжлалтын тусламж үйчилгээг 889 иргэнд үзүүлсэн байна. | |
| 2.7.2 | Хөнгөвчлөх эмчилгээний тасгийн , тусламж үйлчилгээг сайжруулах хими эмчилгээний төрлийг нэмэгдүүлж иргэдийн чирэгдлийг бууруулна. | 2 сая | Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо | - Хөнгөвчлөх эмчилгээний 8 ортой тасагтай болсон.<br>Тусламж үйлчилгээ 857 иргэн | Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо 1000 | Хөнгөвчлөх эмчилгээний тасаг байгуулагдан, их эмч 1, сувилагч 4, туслах сувилагч 1 орон тоотойгоор тусламж, үйлчилгээг үзүүлж байна. Тусламж, үйлчилгээний төрлөөр нь харуулбал:<br>• Хэвтэн эмчлүүлсэн 438<br>• Хими эмчилгээ хийлгэсэн 49<br>• Хэвлийн шингэн соруулах хатгалт 2<br>• Плеврийн хөндийн хатгалт 2<br>• Стомоор клизм тавиулах 2<br>• Арьсан дор зүү тавих 10<br>• Асаргаа сувилгаа хийсэн 438<br>• Холголт цооролтоос сэргийлэх зөвлөгөө 152<br>• Сэтгэл зүйн зөвлөгөө 438<br>• Нас барах үеийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн 39 хүнд үзүүлсэн байна.<br>"Хавдрын үеийн сувилахуйн тусламж, үйлчилгээ" сэдэвт чадавхжуулах сургалтыг "Симуляцийн сургалтын төв"-д зохион байгуулж өрх, сумын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эрүүл мэндийн төвийн 22 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдсан.<br>Дарханы гэр бүлийн радио 104.5-тай хамтран хавдрын эрт илрүүлэлт урьдчилан сэргийлэлтийн талаар шууд лайв нэвтрүүлэгт орж, зөвлөгөө мэдээлэл өгсөн. Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эмч сувилагч нарын сэтгэл санааг өргөх, хувь хүний хөгжлийн талаар JCI байгууллагын төслийн багтай хамтран сургалт зохион байгуулж, нийт 6 хүн хамрагдсан. ХСҮТ-ийн хими хөнгөвчлөхийн тасагт ажлын байрны 5 хоногийн сургалтанд сувилагч 2, туслах сувилагч 1 хамрагдсан.<br>**Үр дүн:** Хөнгөвчлөх эмчилгээний тасагтай болж 438 үйлчлүүлэгч хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ, амбулаториор 3100 иргэнд үйлчилсэн байна. Хөнгөвчлөхийн тасагт туслах сувилагч ажиллуулдаг болсон.Хими эмчилгээ хийж байна./49 иргэнд/ | |
| 2.7.3 | Сувилахуйн тусламж үйлчилгээний гардан үйлдлийн стандартын хэрэгжилтийг үнэлж, сургалт зохион байгуулах, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад мэргэжил арга зүйн болон дэмжлэг үзүүлж ажиллана . | 500 мян | Сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо, үнэлгээний хувь | Нийт давхардсан тоогоор 177 сувилагч, эмнэлгийн ажилчид хамрагдсан. Дотоодын хяналтын үнэлгээ 91.5% | -Сургалтад 200 эмнэлгийн мэргэжилтэн<br>Үнэлгээ 94% хүргэх | Сувилахуйн тусламж үйлчилгээний гардан үйлдлийн стандартын сургалтыг 14 удаа зохион байгуулж, нийт 493 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдаж, сургалтын өмнөх мэдлэг 70.5 %, сургалтын дараа 85.6% болж, 15% ахисан үр дүнтэй байна.<br>Сувилахуйн тусламж үйлчилгээний гардан үйлдлийн стандартын хэрэгжилтийг 15 чиглэлээр 67 удаа үнэлэхэд дундаж үнэлгээ 89%-тай байна. Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад нийт 48 удаа мэргэжил арга зүйн дэмжлэг, зөвлөмж өгч ажилласан. | 90 |
| 2.7.4 | “Сувилахуйн технологи 2022” шинэ бүтээлийн | 5 сая | -Шинэ бүтээлийн тоо | -10 бүтээл | -10 | Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн дунд “Сувилахуйн технологи-2022” шинэ санаа, бүтээлийн үзэсгэлэнг зохион байгуулж, 16 тасгийн 50 гаруй сувилагч, эмнэлгийн тусгай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | уралдааныг зохион байгуулна. | | | | | мэргэжилтнүүд багаараа оролцож, 18 чиглэлийн 46 бүтээлүүдийг дэлгэн танилцуулсан. Уралдаанд оролцсон бүтээлүүдийг үйлчлүүлэгчдэд ээлтэй аюулгүй байдал, эрүүл ахуй, халдвар хамгааллын чанарын шаардлага хангасан байдал, тусламж үйлчилгээ үзүүлэх цаг хугацааг хэмнэсэн байдал, эдийн засгийн тооцоо, бусдад туршлага болохуйц шаардлагыг хангасан байдал зэрэг үзүүлэлтүүдээр дүгнэж урамшуулсан. | |
| 2.7.5 | Сувилахуйн эмнэл зүйн хэлэлцүүлэг хийж үр дүнг тооцож ажиллана. | 2 сая | - Хэлэлцүүлгийн тоо, үр дүн | -2 удаа | -3 удаа | Эрүүл Мэндийн Даатгалын Үндэсний Зөвлөлийн 01, 05 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, цахим хэрэглээний чадавхийг сайжруулах зорилгоор "Цахим программын хэрэглээ-тулгамдсан асуудал" сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг Мэдээлэл технологийн алба, Даатгалын баг, Сувилахуйн алба хамтран зохион байгуулж, 24 сувилагч мэргэжилтэн хамрагдсан.<br>"Үйлчилгээ үзүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах нь" сэдэвт 21 хоногийн аян зохион байгуулж, сургалт 11, санамж, дуугүй хөтөч, гарын авлага, аргачлал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, эрсдэлээс сэргийлсэн ажил 18, бүтээлч ажил 30 хийгдсэн байна.<br>Нийт 9 тасаг 19 төрлийн оношийн хүрээнд 4 удаа хэлэлцүүлэг хийсэн байна. Давхардсан тоогоор сувилахуйн 71 оношоор 65 удаа оролцож, эмнэлзүйн үр дүн 67% хүрсэн байна. | 100 |
| 2.7.6 | Сэргээн засах тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаан ажиллана. | 10 сая | Тусламж үйлчилгээ авсан иргэдийн тоо Нэмэгдсэн тоног төхөөрөмж | 8534 хүн Тоног төхөөрөмж 10 төрөл | 10000хүн Тоног төхөөрөмж 5 | Сэргээн засах тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахаар 7 зорилт, 23 ажлыг төлөвлөн ажиллаж байна. Сэргээн засах эмчилгээний тасагт 14 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр иргэдэд үйлчилгээ үзүүлдэг ба шинээр Түрүү булчирхайн үрэвсэлт өвчний үед хэрэглэх шарлагын /XZPUKGNG/ аппарат нэмэгдэж эмчилгээнд 150 хүн хамрагдсан байна. Сэргээн засах эмчилгээний тасагт MNS4621:2008 түгээмэл үйлдлийн стандартын дагуу:<br>-Гэрэл эмчилгээ-14088<br>-Парафин эмчилгээ-2962 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | -Цахилгаан эмчилгээ-3610<br>-Бариа засал-5869<br>-Хүзүүний татлага-867<br>-Нурууны татлага-1106<br>-Урьдчилан сэргийлэх багцад-258<br>-Хөдөлгөөн засал-785<br>Давхардсан тоогоор 29645 үйлчлүүлэгчдэд сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. **Үр дүн**: Урьд оны мөн үетэй харьцуулахад тусламж үйлчилгээний төрөл 1-ээр нэмэгдэж, давхардсан тоогоор 29645 үйлчлүүлэгчдэд сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. | |
| **Зорилт 2.8. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулж, үйлчлүүлэгч төвтэй тусламж үйлчилгээг үзүүлэх** | | | | | | | |
| 2.8.1 | Тусламж, үйлчилгээний чанарын тасралтгүй хөгжлийг дэмжсэн магадлан итгэмжлэл бүхий чанарын нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн болон дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллана. | 500 мян | Чанарын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт хувь | 75% | 85% | Магадлан итгэмжлэлийн хугацаа дууссан хувийн хэвшлийн Цээнэ, Цанид, Бид, Оточ манал эмнэлэг, Шарын гол сумын ЭМТ, Госхот ӨЭМТ, Мэдстоб ӨЭМТ, Шарын голын Тулга сувилал зэрэг 8 эрүүл мэндийн байгууллага магадлан итгэмжлэгдэх өөрийн үнэлгээг боловсруулах магадлан итгэмжлэлийн материал бүрдүүлэх зэрэгт мэргэжил арга зүйн туслалцааг үзүүлсэн. Дээрх эрүүл мэндийн байгууллагуудыг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг цахимаар зохион байгуулан Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 сарын 22 –ны өдрийн А\160 , 2022 оны 05-р сарын 30-ны А/294, 2022 оны 10-р сарын 14-ны А/506, 2022 оны 10-р сарын 27-ны А/526 тоот тушаалаар магадлан итгэмжлэлийн хугацаа 2-4 жилийн хугацаагаар сунгагдан ирсэн.<br>Үр дүн: Магадланд 8 ЭМБ орж магадлан итгэмжлэлийн хугацаа 2-4 жилийн хугацаагаар сунгагдан ирсэн. Чанарын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилт 85.3% | 100 |
| 2.8.2 | Эрүүл мэндийн байгууллага бүрт Халдварын сэргийлэлт хяналтын баг, Чанар, | 1 сая | -Хяналт, зөвлөмжийн тоо | ЭМБ-д 10 баг ажиллаж байна.54 төрлийн | Хяналт-4 удаа зөвлөмж гүйцэтгэлэ эр | Эрүүл мэндийн байгууллагуудын цар тахлын үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний болон эрүүл мэндийн байгууллагуудын халдвар хамгаалалын дэглэмийг сайжруулах ЭМС-ын А/33, А/36 тоот тушаалын хэрэгжилтийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | аюулгүй байдлын албаны үйл ажиллагааг тогтмолжуулан хяналт тавьж ажиллана. | | | зөвлөмж өгсөн. | | хангахаар НЭ-н эмчлэн тусгаарлах эмнэлэг, ӨЭМТ, СЭМТ, Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага зэрэг нийт 11 эмнэлэгт халдварын сэргийлэлт, хяналтыг нийт 14 удаа хийж 8 төрлийн зөвлөмж өгч, халдварын сэргийлэлтийн сургалтыг нийт 75 эрүүл мэндийн ажилтанд хийсэн. Эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах чанарын хяналтыг НЭ, Сумын ЭМТ-д 4 удаа хийж тусламж үйлчилгээг сайжруулах 3 төрлийн 12 зөвлөмжийг өгч, зөвлөмжийн хэрэгжилт 87% байна. Эрүүл мэндийн байгууллагуудын халдварын сэргийлэлтийг сайжруулах зорилгоор А/537 тоот тушаалын дагуу магадлан итгэмжлэх сунгах 6 ЭМБ-д дэмжлэгт хяналтыг хийж 52 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт хийж арга зүйн зөвлөгөө өгсөн. Эмнэлгийн халдвараас сэргийлэх сэргийлэх, хяналт тавих зорилгоор эмч, мэргэжилтнүүдэд мэдлэг олгох сургалтыг ЭМГ-аас зохион байгуулж, 45 эмч, сувилагч, эрүүл мэндийн байгууллагын ажилтан хамрагдсан.<br>Үр дүн: Нийт 21 эрүүл мэндийн байгууллагын 172 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд сургалт мэдээлэл хийж, 3 чиглэлээр 20 төрлийн зөвлөмж хүргүүлж, зөвлөмжийн хэрэгжилт 93%-тай байна. | |
| 2.8.3 | Эмнэлгийн тусламж үйлчилгээнд чанар сайжруулах аргуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэгт удирдлагаар хангаж ажиллана. | 500 мян | чанарын аргуудын төрөл тоо<br><br>-үр дүн | Чанарын арга-4 | Чанарын арга-4 | Цахим сувилгааны түүх хөтлөлт, эмийн захиалга хийх арга зүйн сургалтанд 13 тасгийн 24 сувилагч,<br>-Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх, аюулгүй ажиллагааны сургалтанд нийт 6 тасгийн 34 сувилагч,<br>-“Эрсдлийн менежмент”, ”Ажлын байрны эрсдлийг хэрхэн илрүүлэх” сургалтанд сувилахуйн албаны дарга, ахлах сувилагч 22,<br>-“Хүчилтөрөгч эмчилгээ”-ний сургалтанд нийт 198 сувилагч,<br>Нийт 14 удаагийн сургалтанд 278 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдаж, сургалтын өмнөх мэдлэг 70.5%, сургалтын дараа 85.6% болж, 15% ахисан үр дүнтэй байна.<br>НЭ-т “ Чанарын талон” хэрэгжүүлэх удирдамж, журмын дагуу 2022 онд ЭМТҮЧАБ-ын албаны | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хурлыг 6 удаа хийж, ЭМС-ын А/406 тоот тушаалыг зөрчсөн гэж үзээд 3 эмнэлгийн мэргэжилтний чанарын талонаар арга хэмжээ авсан байна.<br>ЭМГ, ЭМТҮХ-ээс зохион байгуулсан “Иргэдийн индэр” уулзалт ярилцлагыг 2 удаа зохион байгуулж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон, Бүх нийтийн эрт илрүүлэг үзлэгийн танилцуулга, хийж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг иргэдэд танилцууллаа. Нийт давхардсан тоогоор 237 иргэн хамрагдсан байна. Ижил мэргэжилтний үнэлгээг сувилахуйн тусламж үйлчилгээний хүрээнд Нийт 218 сувилагч хамрагдаж 2 шалгуураар үнэлгээ хийхэд дундаж үнэлгээ 82.0%. | |
| 2.8.4 | Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын /9 сарын 17/ өдөрлөг зохион байгуулна. | 200 мян | Өдөрлөг зохион байгуулсан тайлан, оролцсон иргэдийн тоо | Оролцсон хүний тоо 100 | - Оролцох хүний тоо 150 | ЭМЯ-аас 2022 оныг “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах” жил болгон зарласантай холбогдуулан Нэгдсэн эмнэлгийн сувилахуйн албанаас сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулахад сувилагч, тусгай мэргэжилтэн бүрийн үүрэг оролцоо, санаачилга, хариуцлагыг нэмэгдүүлэх, өөрсдийн ажлын байран дээр үнэлгээ хийлгэх зорилгоор **“Үйлчилгээ үзүүлэгчдийн аюулгүй байдлыг хангах нь”** сэдэвт 21 хоногын аян зохион байгуулж 225 хүн хамрагдсан.<br>ЭМС-ын 2019 оны А/566 дугаар тоот тушаалын дагуу Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрсдлийг бүртгэх, хариу арга хэмээг авах зааврыг үндэслэн Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангахаар эрсдэлийн 15 үнэлгээг хийсэн.<br>✓ Өндөр эрсдэл-1<br>✓ Дунд эрсдэл-9<br>✓ Бага эрсдэл-6 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эмнэлгийн ажилтны аюулгүй байдлыг хангах чиглэлээр 65 эрсдэлийн үнэлгээг гаргасан. Үйлчлүүлэгчийн аюулгүй байдал өдөрлөг зохион байгуулж 211 иргэдэд мэдээлэл, зөвөлгөө өгч ажилласан байна. | |
| 2.8.5 | Иргэдэд Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сурталчлах өдөрлөг, Чанарын аян зохион байгуулж ажиллана. | 500 мян | Оролцсон иргэдийн тоо | - | Оролцсон иргэдийн тоо-200 | Нэгдсэн эмнэлэг, ӨЭМТ, СЭМТ-д эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээ, оншилгоо эмчилгээ, тоног төхөөрөмжийн шинэчлэл зэргийг иргэдэд мэдээлэх зорилгоор нээлттэй хаалганы өдөрлөгийг 4 удаа зохион байгууллаа. Өдөрлөгт нийт 1754 иргэн хамрагдаж мэдээлэл авсан ба 200 үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн үнэлгээг авч, 150 иргэнд анхан шатны үзлэг оношилгоо хийж, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт мэдээллийг зохион байгуулсан. | 100 |
| 2.8.6 | Эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлэгчид болон эмч ажилтны сэтгэл ханамжийн судалгааг улирал бүр авч үр дүнг тооцож үйл ажиллагааг зохион байгуулж ажиллана. | 100 мян | Судалгаанд орллцсон иргэд, ажилчдын тоо | | Сэтгэл ханамжийн судалгааны үр дүн | ЭМС-н А/578 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтын дагуу Эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгч, амбулаториор үйлчлүүлж буй үйлчлүүлэгчээс авах сэтгэл ханамжийн үнэлгээг батлагдсан асуумжийн дагуу нийт 1097 иргэнээс авсан байна.<br><br>4 ЭМБ-ын эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 397 иргэнээс сэтгэл ханамжийн үнэлгээг авахад маш сайн 34%, сайн 55%, дунд 8.4% , муу 2.6% үнэлгээтэй байна.<br><br>9 ЭМБ-ын амбулаториор үйлчлүүлж буй 700 үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн үнэлгээ авахад 59.6% нь 2 буюу түүнээс дээш удаа үйлчлүүлсэн, 40.4% нь анх удаа үйлчлүүлсэн байна. Сэтгэл ханамжийн үнэлгээ маш сайн 29%, сайн 48.6%, дунд зэрэг 17% үнэлгээтэй байна. | 90 |
| 2.8.8 | Эрсдлийн менежментийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, эрсдлээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна | 200 мян | Оролцсон ажилчдын тоо | - | Оролцсон ажилчдын тоо-200 | ЭМС-ын 2019 оны А/566 тушаалын 2-р хавсралтын хэрэгжилтийг хангаж Эрсдлийн менежмент сургалтыг 2 удаа зохион байгуулж, эмнэлгийн 114 ажилтан хамрагдаж . Эмнэлгийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилтны аюулгүй байдлыг хангах чиглэлээр 65 эрсдэлийн үнэлгээг гаргасан. Унаж бэртэх эрсдэлээс зөвлөгөө, мэдээллийг 2041 үйлчлүүэгчдэд хүргэж ажилласан. Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах ЭМГ-ын даргын тушаал гарч бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлж хэрэгжилтийг ханган ажилласан. | |
| | **Зорилго 3. Эрүүл мэндийн салбарын эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэдлэг, чадвар, хандлага бүхий хүний нөөцийг бэлтгэх, тасралтгүй сургаж чадавхижуулна.** | | | | | | |
| | **Зорилт 3.1. Салбарын болон байгууллагын түвшинд хүний нөөцийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх арга зүйг нэвтрүүлэх.** | | | | | | |
| 3.1.1 | Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана. | 1.0 сая | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь | 97% | 98% | Монгол улсын Засгийн газрын 2019 оны 193 дугаар тогтоолоор батлагдсан Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хүний нөөцийн Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг сайжруулах хөтөлбөрийг хамтын ажиллагааны түншлэлд тулгуурлаж хэрэгжүүлэх, Эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн мэдээллийн санг боловсронгуй болгох, Хүний нөөцийг хөгжүүлэх 3 чиглэлээр 6 үйл ажиллагааны чиглэл бүхий стратеги төлөвлөлтийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хэрэгжилт-90%.<br>• Засгийн газрын 2022 оны А/107 тогтоолоор эрүүл мэндийн салбарын эмч, ажилчдын цалингийн доод жишиг сүлжээ батлагдсан ба бүх шатлалын эмч эмнэлгийн ажилчдын үндсэн цалинг 8,2-13,2%-иар, өрхийн эрүүл мэндийн төвийн эмч ажилчдын цалин 30-40% хүртлэх хувиар тус тус нэмсэн.<br>• Аймгийн Онцгой комисс, засаг даргын захирамжаар Олон улсын сувилагчийн өдрийг тохиолдуулан аймгийн хэмжээнд Ковид-19 цар тахлын үед ажилласан 585 сувилагч тусгай мэргэжилтэн тус бүр 100,000 төгрөгийн урамшуулал олгосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн сайдын 2004 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 77 дугаар тушаалаар шинэчлэгдэн батлагдсан жагсаалтад орсон хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилладаг ажилчдад Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2019 оны 472 тогтоолын дагуу нэмэгдэлүүдийг цаг тухай бүрд нь тооцон олгож байна. Ажилчдын ажлын үр дүн гүйцэтгэлийг үнэлэн 60% хүртлэх хувиар урамшуулал олгож байна.<br>• Орон нутагт тогтвор суурьшилтай 5 жил тасралтгүй ажилласан эмч эмнэлгийн ажилчдад эрүүл мэндийн тухай хуулийн 29,2 дахь, 29,5 дахь заалтын дагуу нийт 224 ажилчдад тэтгэвэр тэтгэмжийн нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.<br>• Нэгдсэн эмнэлэг нийт 5 эмнэлгийн ажилтанд 2412000 мянган төгрөгний нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон.<br>• Эмч эмнэлгийн ажилчдыг витаминжуулалт 7,500,0 мянган төгрөг<br>• Гэр хорооллын судалгаа гарган АЗДТГ-тай хамтран 60 тонн нүүрс 154 эмч эмнэлгийн ажилчдад олгосон | |
| 3.1.2 | Эмч эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны сургалт хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана | 10.0 сая | Бэлтгэсэн мэргэжилтэн | 21 эмч мэргэжилтэн суралцаж байна | Нэн шаардлагатай 5 эмч мэргэжилтэнг бэлтгэх | Хүний нөөцийн сургалт, хөгжлийн төлөвлөлтийг 5 зорилт 25 үйл ажиллагаа боловсруулж ЭМГ-ын даргаар батлууж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. ЭМГ-ын хүний нөөцийн сургалт хөгжлийн бодлогын стратеги, зорилтын хүрээнд нэмэлтээр 4 зорилт 22 чиглэл үйл ажиллагаа бүхий мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө, шинэ ажилтныг дадлагажуулах журам зэргийг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2022-2023 оны хичээлийн жилд ЭМХТ-д үндсэн 10 мэргэжлийн чиглэлээр 14 их эмч, нэмэлт захиалгаар 4 их эмч, төрөлжсөн мэргэжлийн 12 чиглэлээр 14 их эмч нэмэлтээр 4, 13 мэргэжлийн чиглэлээр 19 сувилагч тусгай мэргэжилтэн, мэргэжил дээшлүүлэх сургалтад 4 чиглэлээр 5 их эмч, 7 чиглэлээр 12 сувилагч тусгай мэргэжилтэн суралцсан. Ариутгал, халдваргүйтгэл, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дархлаажуулалтын чиглэлээр хувиараа 7 эмнэлгийн мэргэжилтэн суралцсан.<br>Үр дүн: 2022 онд 41 их эмч, 31 сувилагч тусгай мэргэжилтэн төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад хамрагдсан. | |
| 3.1.3 | Эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхижуулах “Чадварлаг сувилагч” төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | 30,0 сая | -Багц цагийн биелэлт<br>-Сургалтын тоо<br>-Хамрагдсан мэргэжилтний тоо | Багц цагийн биелэлт 100%<br>-Сургалтын тоо 10<br>-Хамрагдсан хүний тоо-152 | Багц цагийн биелэлт 100%<br>-Сургалтын тоо 10<br>-Хамрагдах хүний тоо-200 | Сувилагч, тусгай мэргэжилтнүүдийг хувийн суурь чадамж, ёс зүй, хандлагын чиглэлээр чадавхжуулах зорилтын хүрээнд:<br>• ШУГТЭ-ийн сувилахуйн албатай хамтран ЭМГ, НЭ-ийн сувилахуйн алба, өрх, сум, НЭМТ-ийн 32 ахлах сувилагч нарыг удирдлага манлайллын сургалтанд<br>• ЭМГ-ын дэргэдэх ёс зүйн салбар хорооноос ЭМС-ын А/406 дугаар тушаал “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн дүрэм” 250 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдэд<br>• “Эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлага, ёс зүй” сэдэвт 1 багц цагийн сургалтанд 185 сувилагч<br>**Нийт 467 ажилтан хамрагдсан**.<br>**Чадавхжуулах сургалт:**<br>• НЭҮНШТҮ сэдэвт сургалтад 15 сувилагч<br>• Сувилахуйн тусламжийн стандарт, удирдамж, зааврыг хэрэгжүүлэх чиглэлээр 300<br>• Өрх, сумын эрүүл мэндийн төвийн сувилагч нарыг мэргэшүүлэх, чадавхжууулах 109<br>• Цахим сувилгааны түүх хөтлөлт, “Цахим программын хэрэглээ-тулгамдсан асуудал” сэдэвт сургалт, хэлэлцүүлэгт 24 сувилагч,<br>• Цус цусан бүтээгдэхүүн сэлбэх, аюулгүй ажиллагааны сургалтад 34 сувилагч,<br>• “Эрсдлийн менежмент”, ”Ажлын байрны эрсдлийг хэрхэн илрүүлэх” сургалтанд 22 ахлах сувилагч,<br>• Нэгдсэн эмнэлгийн инженер техникийн албатай хамтран 130 сувилагч | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • “Антбиотикийн зохистой хэрэглээ, сорил тавих арга техник” сургалтад 147 сувилагч<br>• “Хүчилтөрөгч эмчилгээ”-ний сургалтад нийт 198 сувилагч хамрагдаж, сургалтын өмнөх мэдлэг 70.5%, сургалтын дараа 85.6% болж, 15% ахисан үр дүнтэй байна.<br>**Нийт 979 сувилагч тусгай мэргэжилтэн хамрагдсан**.<br>ШУГТ-ээс зохион байгуулсан “Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал” сэдэвт үндэсний VIII зөвлөлгөөнд ЭМБ-уудын төлөөлөл 13 сувилагч оролцсон.<br>Сувилагч мэргэжлийн тэргүүлэх зэргийн шалгалтад 11, ахлах зэргийн шалгалтанд 10 сувилагч буюу нийт 21 сувилагч тэнцсэн байна.<br>“Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулъя” зөвөлгөөн аймгийн хэмжээнд зохион байгуулж, ЭМБ-уудын төлөөлөл 250 гаруй сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн хамрагдсан.<br>Сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийн дунд “Сувилахуйн технологи-2022” шинэ санаа, бүтээлийн үзэсгэлэнг зохион байгуулж, 16 тасгийн 50 гаруй сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүд багаараа оролцож, 18 чиглэлийн 46 бүтээлүүдийг дэлгэн танилцуулсан. | |
| 3.1.4 | Эмч мэргэжилтнүүдийг чадавхижуулах , ур чадварыг дээшлүүлэх “Тасралтгүй суралцагч-эмч” төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | 30,0 сая | -Багц цагийн биелэлт<br>-Сургалтын тоо<br>-Хамрагдсан эмч мэргэжилтний тоо | Багц цагийн биелэлт 100%<br>-Сургалтын тоо 8<br>-Хамрагдсан | Багц цагийн биелэлт 100%<br>-Сургалтын тоо 8<br>-Хамрагдах | ЭМЯ, ЭМХТөвөөс Эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийн цахим бүртгэлийн програмыг улс орон даяар нэвтрүүлж байгаатай холбогдуулан эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулах, кредит багц цаг тооцох сургалтууд цахимд байршуулж, Багц цагийн сургалтад 100% хамрагдсан.<br>2022-2023 оны хичээлийн жилд ЭМХТ-д үндсэн 10 мэргэжлийн чиглэлээр 14 их эмч, нэмэлт захиалгаар 4 их эмч, төрөлжсөн мэргэжлийн 12 чиглэлээр 14 их | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хүний тоо-92 | хүний тоо-100 | эмч нэмэлтээр 4, мэргэжил дээшлүүлэх сургалтад 4 чиглэлээр 5 их эмч нийт 41 их эмч суралцсан байна. Солонгос улсын Кёнги аймгаас зохион байгуулсан сургалтад 15 эмч хамрагдаж төгссөн. “Хүний эрхийн боловсрол олгох” сургалтад 150 удирдах ажилтан болон эмч нар хамрагдсан. ЭМХТ-өөс зохион байгуулсан “Төрийн үйлчилгээ орон нутагт” сургалтад 100 эмч мэргэжилтэн, аймгийн удирдах ажилтны зөвөлгөөнд 85 удирдах ажилтан эмч нар тус тус хамрагдсан байна. Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэл, стратегийн худалдан авалт, эмнэлгийн хагас бие даасан байдлыг бэхжүүлэх чиглэлээр төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагын удирдлагын багийг чадавхижуулах сургалтад 50 ажилтан, Хүний эрхийн боловсролыг дээшлүүлэх сургалтад Эрүүл мэндийн салбарын 21 удирдах ажилтан, Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооноос зохион байгуулж буй "Гамшгийн үеийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүй" сэдэвт сургалтад 84 эмч хамрагдсан байна. Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан “PROMOTION-2022” Эрдэм шинжилгээний бага хурал АШУҮИС-ийн Дархан салбар сургуультай хамтран зохион байгуулж 12 эмч илтгэл хэлэлцүүлсэн. **Үр дүн**: Олгох болон мэргэшүүлэх сургалтад 41 их эмч, танхимын сургалтад сургалтад 420 их эмч, удирдах ажилтны зөвөлгөөнд 85 эмч, Эрдэм шинжилгээний бага хуралд 12 эмч хамрагдаж мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна. Цахим сургалтад 38 удаа 235 эмч хамрагдсан байна. | |
| 3.1.5 | Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг тасралтгүй | 500.0 мян | Сургалтад хамрагдсан | 1 удаа 482 эмч, | 1 удаа 485 эмч | Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн харилцаа хандлага сайжруулах, ЭМС-ын А/406 тушаалаар | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах, мэргэжлийн нийгэмлэг, холбоодын оролцоог нэмэгдүүлэх татан оролцуулна. | | мэргэжилтний тоо | мэргэжилтэн | мэргэжилтэн | 20 удаагийн сургалтад 343 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй төлөвшил, хариуцлага" 1 сарын аяны хүрээнд 2 зорилт, 14 үйл ажиллагаа төлөвлөн ажилласан. Уг аяны хүрээнд Нэгдсэн эмнэлэг **“ХАРИЛЦААГ ЭРХЭМЛЭГЧ ЁС ЗҮЙЧ ХАМТ ОЛОН”** аяныг зохион байгуулж, Эрүүл мэндийн байгууллагын ажилчдын дунд **ёс зүйн хороо хаягтай вэб хуудсаар** цахим хуудас нээж 21 удаагийн зөвлөмж, сургалтын мэдээллээр хангаж нийт 120.630 хандалт авсан байна.<br><br>ЭМС-ын А/406 тушаалаар 89 ажилтнаас тестийн үнэлгээ авахад 64,8% байна. Шинээр орсон 25 эмч эмнэлгийн мэргэжилтэнд ЭМС-ын А/406 тоот тушаалыг судлуулан үнэлгээ хийж, сургалт зохион байгуулахад сургалтын өмнө болон дараах сорилын мэдлэгийн түвшин 35%-иар дээшилсэн байна.<br><br>ӨЭМТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтний дунд ёс зүйн харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор АХА тэмцээн зохион байгуулж нийт 41 эмч эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.<br><br>ЭМЯ-ны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооноос 05-р сарын 21 өдөр нийт 250 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд “Гамшгийн үеийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүй” сэдэвт 2 багц цагийн сургалтыг зохион байгуулсан.<br><br>**Үр дүн**:5 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж давхардсан тоогоор 748 эмч, мэргэжилтэн хамрагдсан. Мэдлэгийн түвшин 35%-иар нэмэгдсэн байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.6 | Орон нутагт эмнэлгийн тусламж, үйлчилгээнд гардан ажиллаж буй сувилагчийн тоог нэмэгдүүлж, эмч, сувилагчийн харьцааг 1:2-т хүргэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 5.0 сая | -Эмч сувилагчийн харьцаа | -Шинэ сувилагч 35<br><br>-Эмч сувилагчийн харьцаа 1:1.8 | -Эмч сувилагчийн харьцаа 1:2 хүргэх | Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд гардан ажиллаж буй сувилагчийн тоог нэмэгдүүлэх зорилгоор:<br>1. Төрөлжсөн мэргэшлийн сургалтанд 13 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн<br>2. Төрөлжсөн мэргэшлийн дээшлүүлэх сургалтад 7 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэнг сургалтад хамруулсан байна.<br>Аймгийн хэмжээнд их эмч 308, сувилагч 458, эмнэлгийн тусгай мэргэжилтэн 168. эмч сувилагчийн харьцаа 1:2 байна. | 100 |
| 3.1.7 | Эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжлийн чиглэлээр гадаад, дотоодын богино болон урт хугацааны сургалтад хамруулж чадавхижуулахад дэмжлэг үзүүлж ажиллана | 20.0 сая | Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо | -Гадаадад 5 эмч мэргэжилтэн<br>-Дотоодын урт хугацаа 21, богино хугацааны сургалтад 6 | Дотоодын урт хугацаа 5, богино хугацааны сургалтад 20 мэргэжилтэнг хамруулах | 2022-2023 оны хичээлийн жилд ЭМХТ-д үндсэн 10 мэргэжлийн чиглэлээр 14 их эмч, нэмэлт захиалгаар 4 их эмч, төрөлжсөн мэргэжлийн 12 чиглэлээр 14 их эмч нэмэлтээр 4, 13 мэргэжлийн чиглэлээр 19 сувилагч тусгай мэргэжилтэн, мэргэжил дээшлүүлэх сургалтад 4 чиглэлээр 5 их эмч, 7 чиглэлээр 12 сувилагч тусгай мэргэжилтэн суралцсан. Мөн гадаадын өндөр хөгжилтэй улс орнуудад эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг суралцуулах мэргэжлийн чиглэлээр эмч, мэргэжилтнүүдээс санал, авч нэгтгэн ЭМХТөвд хүргүүлсэн. Цахимаар БНСУ-ын Кёнги аймагтай хамтын ажиллагааны хүрээнд 24 эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, Япон улс, Америк улсын тоног төхөөрөмжийн сургалт, БНСУ-ын ковидын цар тахлын хариу арга хэмжээний 4 удаагийн сургалтанд 45 мэргэжилтэн хамрагдсан. “Дотоод шүүрлийн өвчнүүдийн орчин үеийн судалгаа” сэдвээр БНСУ-д 100%-ийн тэтгэлгээр илтгэл тавьж 2 оролцож ирсэн.<br><br>Үр дүн: 41 их эмч, 31 сувилагч тусгай мэргэжилтэн төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтад хамрагдсан.<br>БНСУ, Япон, Америк улсаас зохион байгуулсан цахим сургалтад нийт 69 эмч мэргэжилтэн хамрагдсан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.1.8 | Орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнийг дээд шатлалын эмнэлэгт ажлын байранд дадлагажуулан сургахад мэргэжлийн холбоодтой хамтран ажиллана. | 10.0 сая | Сургалтад хамрагдсан мэргэжилтний тоо | 21 | 30 | УНТЭ-ийн чих хамар хоолойн их эмч нар "Дэлхийн сонсгол хамгаалах өдөр"ийг угтан Нэгдсэн эмнэлгийн чих хамар хоолойн эмч нартай хамтран<br>➢ Сонсгол сайжруулах нөхөн сэргээх хагалгаа-3<br>➢ Тонзилэктоми хагалгаа-6<br>➢ Хамрын муруйлт засах хагалгаа 2 хийж эмчилгээний үр дүн 100%.<br>Гэмтлийн тасгийн 3 их эмч нар нөхөн сэргээх протезийн төвтэй хамтран түнхний үе, өвдөгний үе солих хагалгааг 7 өвчтөнд амжилтай хийсэн.<br>Мэс заслын 4 эмч нар УНТЭ-ийн эмч нартай хамтран бүдүүн гэдэсний хавдрын хагалгааг 3 өвчтөнд хийсэн.<br>ЭМЯ-ны санхүүжилтээр мэс заслын тасагт бөөр, шээсний доод замын дурангийн хагалгааны багаж тоног төхөөрөмж суурилуулан УНТЭ-ийн Урологи-андрологийн төвийн багтай хамтран түрүү булчирхайг дурангаар авах мэс засал , давсагны чулуу авах мэс заслыг нэвтрүүлэн 3 иргэнд мэс засал хийсэн байна. Орхон аймгийн "Медипас" эмнэлэгт 1 аргазүйч, ЭМТҮХ-ийн 6 мэргэжилтэн ХСҮТ, ЯТТ, УГТЭ-д туршлага судлах, ажлын байрны сургалтад хамрагдсан. НЭ-ийн ЯТТ-ийн эмч,мэргэжилтэн 6 ажилтан Улаанбаатар хотод ЯТТ-ийн үйл ажиллагаатай танилцаж туршлага судалсан. ШУГТ-ээс зохион байгуулсан "Сувилахуйн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдал" сэдэвт үндэсний VIII зөвлөлгөөнд ЭМБ-уудын төлөөлөл 13 сувилагч оролцсон. Дархан Нэгдсэн эмнэлгээс 3 шатлалын эмнэлгүүдэд 2 удаа 26 эмнэлгийн тусгай мэргэжилтэн туршлага солилцсон.<br>Үр дүн: Ажлын байрны дадлагажих сургалтад 61 эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. | 100 |
| 3.1.9 | Төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг ажлын | 20 сая | Сургалтад хамрагдсан ажилтны тоо | 37 | 20 | 2022.01.01-ны өдрөөс ЭМЯ, ЭМХТөвөөс Эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийн цахим бүртгэлийн програмыг нэвтрүүлж, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулах, кредит багц цаг тооцох сургалтууд өдөр бүр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байрнаас нь хөндийрүүлэхгүйгээр мэргэжил дээшлүүлэх болон төрөлжсөн мэргэшил эзэмших, эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг үе шаттайгаар бэлтгэн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ | | | | | мэдээлэгдэж эмч, мэргэжилтнүүд цахим болон танхимын сургалтад хамрагдаж байна.<br><br>Үр.дүн: Хүний нөөцийн сургалт хөгжлийн хөтөлбөрийн дагуу ажлын байрны, дагалдуулах, шавилах, алсын зайн сургалтуудад 100% хамрагдсан.<br>Хувь хүний хөгжлийн сургалтад 11 чиглэлээр 575, ажлын байрны чадавхижуулах сургалтад 14 чиглэлээр 1175, эрдэм шинжилгээ, судалгааны 11 чиглэлээр 98, дадлага сургалтын 9 чиглэлээр 664, цуврал сургалтаар 116, аймаг орон нутагт зохион байгуулагдсан танхимын сургалтанд 37 удаа 1723 гаруй, хэлэлцүүлэг 5 чиглэлээр 643, цахим сургалт 41 удаа 929 эмч эмнэлгийн мэргэжилтэн, Цахимаар БНСУ-ын Кёнги аймагтай хамтын ажиллагааны хүрээнд 24 эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, Япон улс, Америк улсын тоног төхөөрөмжийн сургалт, БНСУ-ын ковидын цар тахлын хариу арга хэмжээний 4 удаагийн сургалтанд 45 мэргэжилтэн хамрагдсан.<br><br>Үр дүн: Давхардсан тоогоор 5992 хамрагдсан байна | |
| 3.1.10 | Орон нутгийн эрүүл мэндийн удирдах ажилтан, эмнэлгийн мэргэжилтэнд олгох урамшууллын багцыг хэрэгжүүлэн ажиллана. | 20 сая | Урамшуулалд хамруулсан байдал | 2021 онд нийт 194 ажилтан шагнал авсан байна | Гүйцэтгэлээр | Засгийн газрын 2022 оны 3-р сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн салбар санхүүжилтийн шинэчлэлтэй холбоотой цалингийн доод жишгийг тогтоож өгсөн. Тус тогтоолын дагуу ЭМС-ын төрийн үйлчилгээний ажилчдын цалинг шинэчлэн тогтоосон. Үүнд: ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, СЭМТ-үүдийн үндсэн цалин 12-14.1 хувь, Өрхийн ЭМТ-үүдийн цалин 20-45% нэмэгдсэн байна.<br>**Төрийн шагнал:** Монгол улсын гавъяат ажилтан 3, “Алтангадас” одон 13, “Хөдөлмөрийн хүндэт” тэмдэг-5<br>Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан-14,<br>Эрүүл мэндийн яамны жуух бичиг- 21<br>Монголын Сувилахуйн Нийгэмлэгийн шагнал -8<br><br>**Аймгийн нэрэмжит шагналд 74 эмч, мэргэжилтэн** шагнагдсан байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2022 онд Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх бодлогын хүрээнд. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг "7:4:10" вебинар сургалтын мэдээллийг тухай бүр түгээж ТЗ-ийн удирдах 5 ажилтан 100% хамрагдсан.<br><br>ЗГ, ЭМЯ, ЭМХТ дээд шатны байгууллагаас зохион байгуулагдсан 27 удаагийн сургалтад 97 удирдах ажилтан<br><br>Аймгийн захиргаа, төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагдсан сургалт, зөвлөлгөөн хэлэлцүүлэгт 14 удаа 48 удирдах ажилтан<br><br>ЭМГ-аас зохион байгуулсан төр хувийн хэвшлийн удирдах ажилтны зөвлөгөөн, семинар, хурал 56 удаа 89 удирдах ажилтан тус тус хамрагдсан. | |
| 3.1.11 | Эмч ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулж, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулна. | 10 сая | -Үзлэгт хамрагдсан ажилтны тоо<br>- Эрүүлжилтийн хувь | -586 эмнэлгийн ажилтан<br><br>Эрүүлжилт 68% | -580 Ажилтан Эрүүлжилт 70% | ЭМБ-ын ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгийг Эрүүл мэндийг дэмжих төвд зохион байгуулж, эмч 224, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн 398, бусад ажилтан 84 ажилтан, нийт 706 хүнийг хамруулж, өвчлөл илэрсэн 243 хүнд эмчилгээ бичиж, зөвлөгөө өгсөн. Эрүүлжилт 70.6% байна | 100 |
| 3.1.12 | Эмч ажилтнуудыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр хангах, орчин нөхцлийг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулна. | 20 сая | -Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийн хангалтийн тоо<br><br>- Зарцуулсан төсөв | - тохижилтын ажилд 107.2 сая төгрөг зарцуулсан | Гүйцэтгэлээр | Дархан сумын Засаг даргын 02 дугаар Албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Хоггүй Дархан хотын төлөө Хамтдаа” уриалгыг дэмжин ЭМБ-ууд хашааны дотор, гадна орчны цэвэрлэгээ хийж, хашаагаа будсан. ЭМГ нь ажилчдын хүүхдийн өрөөг гарган тохижуулсан. Нэгдсэн эмнэлэг “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал”-ын жилийн хүрээнд Уламжлалт эмчилгээний тасгийн хамт олон нь өөрсдийн санаачилга, иргэдийн сэтгэлийн хандив, тусламжаар тасгийнхаа эмчилгээний өрөө, ариун цэврийн өрөө, коридорийг иж бүрнээр нь засварлаж | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилтан болон үйлчлүүлэгчдэд ая тухтай, ээлтэй орчинг бүрдүүлэн ажиллаж байна. Поликлиник I тасаг нь хамт олон, хувь хүмүүсийн дэмжлэг, хандив тусламжаар ажилтнууддаа зориулан амралтын өрөөг иж бүрэн тохижуулсан. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газар, Нэгдсэн эмнэлгийн Сэтгэцийн тасаг хамтран архины хамаарал бүхий зорилтот бүлнийн иргэдийг хэвтэн эмчлүүлэх сэргээн засах өрөөг тохижуулсан. Халдвартын тасгийн амбулаторийн хэсгийг засварласан. **Мэдс-тоб ӨЭМТ** нь төв салбарын гаражийг засварлаж тусламж үйлчилгээний 2 өрөө гаргасан.Коридорыг хулдаасалсан. Хөшиг сольсон. Мөн Мангирт салбарын угаалтуур, 00 өрөөг засварласан. Ажилчдын ая тухтай байдлыг хангаж ус шүүгч авч байршуулсан. **Гэрэлтэй ӨЭМТ** Камержуулалт хийсэн, ажлын хувцас шинэчилсэн. **Шарын гол СЭМТ** Чийрэгжүүлэлтийн өрөөг тохижуулж, 6 төрлийн тоног төхөөрөмжөөр хангасан. **Орхон СЭМТ** нь ЭМТ-ийн дотор талын их засварын ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Дээврийн засвар, цахилгааны монтаж шинэчилэлт, бүх цонх хаалгыг вакум болгон шинэчилсэн. | |
| 3.1.13 | Эрүүл мэндийн байгууллагууд хүүхэд саатуулах, өдөр өнжүүлэх бүлэг ажиллуулах, хүүхэд хөхүүлэх өрөө гаргах зэргээр эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. | 5 сая | Эх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлсэн байдал | - | 10 ЭМБ | Эх, хүүхдэд ээлтэй орчинг Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлэг, өрх сумын эрүүл мэндийн төв , Буянтай, Цээнэ, Саран-Энх, Саран-Элит, Энх-Уламжлал, Цанид эмнэлэг, НДХ, ГБХЗХГ, Татварын хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, ОИЦ, Од цогцолбор сургууль зэрэг төрийн болон төрийн бус байгууллага хувийн хэвшлийн нийт 28 байгууллага хүүхэд саатуулах, хүүхэд хөхүүлэх,хүүхдийн өрөөтэй болсон байна | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилго 4. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд гүйцэтгэлд суурилсан санхүүжүүлэх тогтолцоог хэрэгжүүлж, төсөв санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангана** | | | | | | | |
| **Зорилт 4.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд гүйцэтгэлд суурилсан санхүүжүүлэх тогтолцоог хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 4.1.1 | Хүн амын эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 500.0 мянга | -Зохион байгуулсан үйл ажиллагаа, хамрагдсан иргэд тоо | - ЭМБ-ын 66 ажилтан, иргэдэд 16 удаа 651 | 10 удаа 700 иргэнийг хамруулах | ЭМДҮЗ-ийн 01, 05, 12 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах иргэдэд мэдээ, мэдээлэл хүргэх зорилгоор ЭМБ-аас 5 удаа орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр эрүүл мэндийн даатгалд хамрагдах талаар мэдээлэл хүргэсэн.<br>Эрүүл мэндийн даатгалын цахим шилжилтийн талаарх зөвлөгөө мэдээллийг иргэдэд өгөх, тусламж үйлчилгээний болон тоног төхөөрөмжийн шинэчлэлийг сурталчлах зорилгоор “ИНЭЭМСЭГЛЭЛ –ЭЕРЭГ ХАНДЛАГА” уриатайгаар байгууллага сурталчлах өдөрлөгийг зохион байгуулж 736 иргэд хамрагдсан. ЭМДҮЗ-н 01-р тогтоолын “Эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний оношын хамааралтай бүлгийн жагсаалт, төлбөрийн хэмжээ”-г иргэдэд хүргэхээр хулдаасан хэвлэлээр 4-н байршилд байршуулсан. Нэгдсэн эмнэлгийн даатгалын бага эмч хэвтүүлэн эмчлүүлэгчдэд эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлөлтийг е-баримт аппликейшнээр хэрхэн төлөх талаар зөвлөгөөг тогтмол өгдөг. | 100 |
| 4.1.2 | Эрүүл мэндийн ажилтны гүйцэтгэлд суурилсан цалин, урамшууллын тогтолцоог бий болгоно. | 1.0 сая | гүйцэтгэлд суурилсан санхүүжилт авах | 100% | Гүйцэтгэлээр | “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 3-р сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Эрүүл мэндийн салбар санхүүжилтийн шинэчлэлтэй холбоотой цалингийн доод жишгийг тогтоож өгсөн. Тус тогтоолын дагуу ЭМС-ын төрийн үйлчилгээний ажилчдын цалинг шинэчлэн тогтоосон. Үүнд: ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, СЭМТ-үүдийн үндсэн цалин 12-14.1 хувь, Өрхийн ЭМТ-үүдийн цалин 20-45% нэмэгдсэн байна. Гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдуулж Нэгдсэн эмнэлэг, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | СЭМТ, ӨЭМТ-үүд ажлын үр дүнтэй цалин урамшууллыг уялдуулах ажлууд хийгдэж байна. Нэгдсэн эмнэлэг нь гүйцэтгэлээр санхүүжихтэй холбоотой даатгалын нэхэмжлэл болон цахим өвчний түүхийн бичих сургалтыг эмч нарт 10 удаа хийж давхардсан тоогоор 360 эмч, сувилагч, ажилчид хамрагдсан. ЭМДЕГ-т нэхэмжлэгдсэн өвчний түүхийн 14,316. Үүнээс шалгуур хангасан 13,807 буюу 96.4%тай санхүүжилт авсан байна. Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 2022 онд өссөн дүнгээр үр дүнгийн урамшууллыг 499 эмч эмнэлгийн ажилчдад 655,8 сая төгрөг олгосон. | |
| 4.1.3 | Төсөв санхүүгийн ил тод нээлттэй байдлыг хангана. | 1.0 сая | Шилэн дансны мэдээлэл | Шилэн дансны мэдээлэл 98.5% | Шилэн дансны мэдээлэл 98.8% | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай хуулиуд, ЗГ-ын 2012 оны 17-р тогтоолоор батласан "Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам", 2016 оны 29-р тогтоолоор батласан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ыг тус тус баримтлан төсөв санхүүгийн мэдээллийг ил тод нээлттэй мэдээллэж ажиллаж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар шилэн дансны мэдээллийг ЭМ-ийн 10 байгууллага мэдээллийг бүрэн оруулж мэдээллэсэн боловч 3 байгууллага 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн байна. Үүнд: ЭМГ 2-р сард 1 мэдээлэл, Шарын гол СЭМТ 1 сард 1 мэдээлэл, Түвшинхолбоо 1-р улиралд оруулах 1 мэдээлэл хугацаа хоцроож мэдээллэсэн. Шилэн дансны хэрэгжилт 98.9 хувьтай байна. | 100 |
| 4.1.4 | Үйл ажиллагааны төсвийн зарлагын хэмнэлт, зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулах зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 42, 45, 46 дугаар зүйл, заалтын дагуу Захиалагчид | - | Албан бичгийн тоо | 5 | Тухай бүр | ЭМС-ын санхүүжилтийн шинэчлэлтэй холбоотойгоор төсвийн төлөвлөлтийн Piscal программд төсвийн хуваарийг оруулж ЭМЯ-руу илгээдэг болсон. Нэгдсэн эмнэлэг 7 удаа, Өрх сумын төсөвт 2022 онд 5 удаа өөрчлөлт оруулж батлуулсан. 2022 оны анх батлагдсан төсөв 21,737.0 сая байснаас 7 удаагийн өөрчлөлт хийсний дараах төсөв 30,044.4 сая болж 8,307.4 сая төгрөгөөр нэмэгдсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бичгээр хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ. | | | | | | |
| 4.1.5 | Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4 болон 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон өр, авлага үүсгэсэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын Ерөнхий менежертэй хариуцлага тооцож тооцсон талаарх тайлангаа тухай бүрт нь Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ | Улс, Орон нутгийн төсөв | Өр авлагагүй байх | Өр авлагагүй ажилласан | Өр авлагагүй ажиллах | ЭМ-ийн байгууллагуудыг өр, авлага үүсгэхгүй ажиллах талаар зөвлөмж өгч, хяналт тавьж ажилласан. ЭМ-ийн 10 байгууллагын 10 байгууллага өргүй гарахаар байна. Үүнд:<br>1. Нэгдсэн эмнэлэг нь 2022 оны жилийн эцсээр өргүй ажиллахаар гархаар байна<br>Шарын гол СЭМТ нь түлш халаалтын зардалд 140.9 сая төгрөгийн өртэй гарсан. Учир нь Дулаан Шарын гол ХК нь 2021 оны 11-р сараас эхлэн дулааны үнээ нэмсэнээс өр үүсч эхэлсэн. 2022 оны сумын төсвийн тодотголоор хуримтлагдсан өр болон он дуусталх зардалд 213.0 сая төгрөгийн төсөв нэмж батлагдсанаар оны эцсээр өргүй гарахаар байна. | 100 |
| 4.1.6 | Төсвийн тухай хуулиар Эрүүл мэндийн сайдын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтын дансаар дамжуулж санхүүжүүлнэ. | - | Хэрэгжилтийн хувь | Хэрэгжилт 100.0 | Хэрэгжилт 100.0 | Эрүүл мэндийн сайдын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтын дансаар дамжуулж санхүүжүүлж байна. 2022 оны УТХО-нд ЭМС-ын багцад батлагдсан шилжих хөрөнгө оруулалтаар Хонгор СЭМТ-ийн өргөтгөл нийт 485.2 сая төгрөгөөр батлагдсан. 2022 онд 285.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан. Барилгын ажлын гүйцэтгэл 100% болж ашиглалтанд орсон. Мөн 2021 онд эхэлсэн 2022 онд шилжих хөрөнгө оруулалтаар тусгагдсан Геронтологийн төвийн тоног төхөөрөмж 150.0 сая төгрөг, ГОС ХОТ өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж 48.6 сая төгрөг, Төрөх эмнэлгийн тоног төхөөрөмж 14.8 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтүүдийг олгосон байна. | 100 |
| 4.1.7 | Эрүүл мэндийн сайдын багцаас аймгийн Засаг | - | Мэдээлсэн тоо | 12 | 12 | Төсвийн тухай” хуулийн 8.9.2 дахь заалтын дагуу орон нутаг дахь харъяа бүх байгууллагын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дарга нарт эрх шилжсэн ажлын явцын мэдээллийг сар бүр Эрүүл мэндийн яаманд дараа сарын 5-ны өдрийн дотор хүргүүлж байна. | | | | | 2021 оны аудитлагдсан Санхүүгийн тайланг авч хянан архивласан. 2022 оны жилийн санхүүгийн тайланг ЭМЯ-наас ирэх хуваарьт хугацаанд тушаахаар ажиллаж байна. | |
| **Зорилго 5. Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд нийцсэн, эмнэлзүйн нотолгоонд суурилсан, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх замаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | |
| **Зорилт 5.1. Нотолгоонд суурилсан, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх замаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах** | | | | | | | |
| 5.1.1 | Зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалт /тоног төхөөрөмж, барилга, засвар үйлчилгээ/ бусад дэмжлэгийг Аймгийн Засаг даргын нөөц сан, орон нутгийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлүүлж ажиллана. | 900 сая | Шаардлагатай тоног, төхөөрөмж өөр хангагдсан төрөл тоо | ПГУ<br>Ходоодны дуран<br>КТГ<br>Сэргээн засах тоног төхөөрөмж<br>Шүдний бор машин | 10 нэр төрөл | Зайлшгүй шаардлагатай байгаа хөрөнгө оруулалт бусад дэмжлэгийг аймгийн Засаг дарын нөөц сан, Орон нутгийн төсвийн хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэж байна. Үүнд:<br>1. Аймгийн ИТХ-ын хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын Кёнги аймгийн буцалтгүй тусламжаар Нэгдсэн эмнэлэгт түргэн тусламжийн 2 автомашин, УТХО-аар ЭМЯ-наас 1 автомашин хүлээн авсан.<br>2. Сүрьеэгийн тасгийн олон эмэнд дасалтай сүрьеэтэй өвчтөнүүдийн эмчлэх хэсгийн их засварын ажлыг гүйцэтгэхэд аймгийн ОНХО-оос 102.2 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан. Барилгын засварын ажил хийгдсэн.<br>3. Хүүхдийн тасгийн их засвар үйлчилгээ АЗТГ-н хурлаар орж ОНХО 859,9 сая төсөвлөгдөж "ӨСӨХ БУЯНТ ТУЛГА "ХХК компани тендерт шалгарч их засварын ажил хийгдсэн. "Шарын гол" ХХК хандиваар 100 сая үнэ бүхий 50 хүүхдийн ор, шкафийг бүрэн шинэчилсэн.<br>4. Сувилагч нарын баярыг угтан аймгийн ЗД-ын нөөц хөрөнгөнөөс 58.5 сая төгрөг баталж төр хувийн хэвшилд ажиллаж буй 585 сувилагч тусгай мэргэжилтнүүдэд нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгосон.<br>5. Хүүхдийн зуны сувилал ажиллуулах зардлыг ЗД-ын нөөц хөрөнгөнөөс 11.1 сая төгрөг гаргаж санхүүжүүлж зуны 3 сар хүүхдүүдийг чийрэгжүүлж, сувилах боломжоор хангасан. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5.1.2 | Эрүүл мэндийн байгууллагуудад чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлж тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулна. | 20 сая | ISO нэвтрүүлсэн байгууллага | ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн-1 | ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх-1 | Харзтай шүдний эмнэлэг нь “Чанарын менежментийн тогтолцоо, шаардлага” стандартын дагуу Олон улсын итгэмжлэлтэй, “Монсертф” ХХК аудитын байгууллагаас хийгдсэн баталгаажуулалтын I ба II шатны аудитын үр дүн, Баталгаажуулалтын зөвлөлийн 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хурлын шийдвэрээр ISO 9001:2016 Чанарын менежментийн тогтолцооны баталгаажуулалтын гэрчилгээг авсан.<br><br>**Үр дүн**: ISO олон улсын чанарын менежментийг хэрэгжүүлсэн ЭМБ 1-ээр нэмэгдсэн. | 100 |
| 5.1.3 | Сумын ЭМТ-үүдэд шүдний кабинетын үйл ажиллагааг өргөжүүлж, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 50 сая | СЭМТ шүдний үзлэг, эмчилгээнд хамрагдсан иргэд | Шарын гол сумын эрүүл мэндийн төвийн шүдний кабинетаар 1677 үйлчлүүлэгч үзүүлсэн.<br>Орхон СЭМТ шүдний бор машинтай болсон | Орхон, Хонгор СЭМТ шүдний үзлэг, эмчилгээ хийнэ. | Орхон СЭМТ нь 2021 онд өргөтгөл ашиглалтанд орж шүдний эмчийн үзлэг хийх өрөө тасалгааг бэлтгэж, ЭМЯ-наас “Эрүүл хүүхэд-Эрүүл шүд” хөтөлбөрийн хүрээнд 25 нэр төрлийн 54,4 сая төгрөгийн шүдний бор машин бусад дагалдах хэрэгслийн хамт олгосон. ЭМДҮЗ-ийн 2022 оны 5-р тогтоолоор СЭМТ-үүд шүдний тусламж, үйлчилгээнд ЭМД-аас санхүүжилт авах боломжтой болсоноор үйл ажиллагаа хэвийн явагдаж иргэдэд тусламж үйлчилгээг сумандаа чанартай үзүүлэх боломж бүрдэн ажиллаж байна. Орхон СЭМТ-д амбулаторийн шүдний тусламж үйлчилгээг шинээр нэвтрүүлж, 7 хоногт 1 удаа явуулын байдлаар тусламж үйлчилгээг 64 иргэнд үзүүлсэн ба шүдний кабинетаар 265 иргэн үйлчлүүлж, эрүүлжилт 78,1% байна.<br><br>Хонгор орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 60,0 сая төгрөгийн шүдний тоног төхөөрөмжөөр хангагдан 189 хүүхэд шүдний эмчийн үзлэгт хамрагдаж эмчилгээ хийлгэсэн. Эрүүлжилт 135 хүүхэд буюу 71.4%.<br><br>Шарын голын шүдний үзлэг 1869 илэрсэн өвчлөл 103, эрүүлжилт 72%.<br>Үр дүн: 3 СЭМТ СЭМТ-үүд тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж шүдний эмчийг орон тоогоор ажилллуулан, иж бүрэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тоног төхөөрөмжөөр хanган тусламж үйлчилгээг 2387 иргэнд үзүүлсэн байна. | |
| **Зорилго 6. Хүн амыг чанартай, боломжийн үнэтэй эм, эмнэлгийн хэрэгслээр хангаж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлнэ** | | | | | | | |
| **Зорилт 6.1. Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэн, цахим бүртгэл, хяналтыг сайжруулж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх** | | | | | | | |
| 6.1.1 | Эмийг цахим жороор олгох үйлчилгээг өргөжүүлж ажиллана . | 300 мян | -Цахим жороор үйлчлүүлсэн иргэд | цахим жороор 57392 иргэн үйлчлүүлсэн. | Гүйцэтгэлээр | Цахим жороор 50 эмийн сан үйлчилж байна. Анхан шатны болон лавалгаа шатлалд ажиллаж байгаа 148 их эмч хөнгөлөлттэй эмийн жороор эмч бичиж үйлчилж байна. Шинээр анхан шатны 13 эмч цахим жороор эм бичих эрх авч, ажлаас чөлөөгдсөн 6 эмч цахим жор бичих эрх хаасан.<br>Цахим жорын бичилтэд дэмжлэгт хяналтыг 4 удаа хийж, 8 төрлийн зөвлөмж өгч ажиллсан.<br>Шинээр 6 эмч цахим жороор эм бичих эрх олгуулахаар саналыг ЭМД газарт хүргүүлж эрх нээлгэж ажилласан.<br>Иргэдийн цахим жорын бичилт хийдэг ,олгодог эмийн сан эмч,эмийн мэргжилтэн,жор баригч нарт 3 удаа хэлэлцүүлгийг ЭМД хэлтэс,эмийн сан хамтран зохион байгуулсан нийт давхардсан тоогоор 140 эмч мэргэжилтэн хамрагдаж,тулгамдсан асуудал,хууль эрх зүйн дүрэм журам талаар мэдлэг дээшлүүлж хамтын ажиллагааг сайжруулах тал дээр анхаарах тохиролцсон | 100 |
| 6.1.2 | Эмийн зохистой хэрэглээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааны арга хэмжээ хэрэгжүүлнэ. | 300 мян | -Сургалтын тоо<br>-Хамрагдсан эмч мэргэжилтэн, үйлчлүүлэгчийн тоо | -15 удаагийн үйл ажиллагаанд 450 эмнэлгийн ажилтан сургалтад хамрагдсан.<br>-13 удаа 1700 | -450 эмнэлгийн ажилтан<br><br>-1800 үйлчлүүлэгч | Эмийн зохистой хэрэглээний талаар ЭМГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу “Ковидын болон ковидын өвчлөлийн дараах эмийн зохистой хэрэглээ” сэдэвт 1 сарын аян зохион байгуулж өдөрлөг 2 удаа 1980 иргэн хамрагдсан. Цахим нэвтрүүлэг 3 удаа, хандалт 542 иргэн.<br>Эмийн сангийн жор баригч болон анхан болон лавлагаа шатлалын эмч нар цувралаар сургалтыг МОНОС, САНДОЗ, МЭИК, КРКА, АЗИФАРМ эмийн сангуудтай хамтран зохион байгуулж эмийн зохистой хэрэглээний талаар танхимын сургалтыг 8 удаа зохион байгуулж, 350 эмч мэргэжилтэн оролцсон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | үйлчлүүл эгч | | Хэвтэн эмчлүүлэгчдэд эмийн зохистой хэрэглээ сургалт мэдээ, мэдээллийг 4 удаа давхардсан тоогоор 6180 хүнд мэдээлэл хүргэж ажилласан.<br><br>Гаалийн газрын ажилчдад АШУҮИС-тай хамтран эмийн зохистой хэрэглээ сургалтыг нийт 25 ажилчдад зохион байгуулсан. | |
| 6.1.3 | Эм зүйн салбарт мөрддөг стандартад үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангуулан ажиллана | 200 мян | - Үнэлгээний зөвлөмж, хэрэгжилт Хамрагдсан байгуулага | -60 эм ханган байгууллагат 2 удаагийн хяналт үнэлгээг ээр 93% | -60 эмийн сан, ЭХНБ | Мансууруулах сэтгэц нөлөөт эмээр үйлчилж байгаа 3 байгууллага, Анхан шатны ЭМБ-ын яаралтай тусламжийн эмийн хэрэглээнд дэмжлэгт хяналтыг 6 удаа хийж 11 төрлийн зөвлөмж өгч ажилласан.<br>42 эмийн санд Эм зүйн салбарт мөрддөг стандартад үнэлгээ хийж, 8 төрлийн зөвлөмж өгч ажилласан. | 100 |
| 6.1.4 | Антибиотект тэсвэртэй нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулна. | 200 мян | -Зохион байгуулсан үйл ажиллагаа, хамрагдсан иргэдийн тоо | 11 удаагийн үйл ажиллагаанд 590 иргэн оролцож 6400 сургалт сурталчилгаа | -6500 | ЭМС-н эмийн эмчилгээг зохицуулах хорооны А/414 журмын дагуу эмнэлгийн антибиотик эмийг хэрэглэх журам гарган антибиотик эмийн хэрэглээнд 3 удаа хяналт хийж 7 төрлийн зөвлөмж өгч ажилласан.<br>Антибиотикт нянгийн тэсвэржилтийн байдлыг Gaj. Noloo.mn бүртгэн байршуулж Антибиотикийн мэдрэг үзэх шинжилгээний тоог нэмэгдүүлж Бактерологи лабораторын тасагт 10 нэр төрлийн 4,0 сая төгрөгийн антибиотикийн диск ханган нийлүүлсэн<br>Нянгийн антибиотикт мэдрэгийн шинжилгээг 7000 хүнд хийсэн.<br>Амбулаторит ирсэн нийт сорьцын тоо – 4669 Үүнээс<br>• Хэвийн бичил биетэн – 4380<br>• Эмгэгтөрөгч нян - 1540<br>• Ургалтгүй – 1080<br><br>Тасгаас ирсэн нийт сорьцын тоо – 2331 Үүнээс<br>• Хэвийн бичил биетэн – 1210<br>• Эмгэгтөрөгч нян - 840<br>• Ургалтгүй – 281<br>Антибиотик эмийн сорил тавих, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх талаар 1 удаа сургалт зохион байгуулж нийт 116 сувилагч тусгай мэргэжилтэн хамрагдсан.<br>Эмийн жорын маягт, жор бичилт MNS5376:2014 стандарт жорын сургалтыг эмч нарт 4 удаа | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | явуулж 94 эмчид хийж мөн цахим жорыг нарийн мэргэжлийн эмч нар бүрэн шилжсэн.<br>Антибиотикийн зохистой хэрэглээ сурталчилгаа, шторкийг ЭМБ-ын цахимд байршуулсан.Хандалт 1631 | |
| 6.1.5 | Антибиотекийн хэрэглээнд хяналт тавьж, судалгаа хийж үр дүнг тооцон ажиллана. | 300 мян | -Судалгаан ы үр дүн | -10 нэр төрлийн антибиот ик мэдрэг чанар үзсэн<br>-7785 хүний шинжилг ээнд антибиот ик мэдрэг чанар тодорхой лоход дунджаа р мэдрэг байдал 69,2% | Судалгаан ы үр дүн | Нэгдсэн эмнэлэгт хэрэглэж байгаа антибиотикийн хэргэлээнд судалгаа хийж эмч нарын онол практикийн бага хуралд илтгэл тавьж хэлэцүүлсэн байна.<br>Антибиотик мэдрэг чанарыг бүлэг тус бүрээр илэрхийлбэл<br>Макролид бүлэг-45.9%<br>Цефалоспорины бүлэг 38.3%<br>Аминогликозидын бүлэг 77.1%<br>Хинолины бүлэг-63.2%<br>Пенциллины бүлэг-23.2% байна.<br>Нэгдсэн эмнэлэгт ковид цар тахлын өмнөх ба цар тахлын үед зарцуулагдсан нянгийн эсрэг эмийн нэр төрөл ба зарцуулалтанд ABC шинжилгээ хийж үзэхэд тодорхой өөрчлөлтүүд ажиглагдлаа. А бүлгийн эмүүдээс Цефазолины хэрэглээ буурч, Цефотаксимын зарцуулалт өсөж, Мерепенем шинээр орж, эдгээр эмүүдийн зарцуулалтанд эзлэх хувь хэт өндөр байгаа нь ажиглагдсан.Ковид цар тахлын өмнөх ба цар тахлын үед зарцуулагдсан нянгийн эсрэг эмийн нэр төрөл ба зарцуулалтанд VEN шинжилгээ хийж үзэхэд нийт хэрэглэгдэж буй эмийн нэр төрөл харьцангуй тогтмол боловч Access ангилалын эмүүдээс 2 нэр төрөл хасагдаж, 1 төрөл шинээр нэмэгдсэн, Watch ангилалд 2 нэр төрөл шинээр нэмэгдсэн байна | 100 |
| **Зорилго 7. Эрүүл мэндийн салбарт мэдээллийн технологийг нотолгоонд суурилсан тусламж, үйлчилгээ үзүүлэх, шийдвэр гаргахад үр дүнтэй ашиглана.** | | | | | | | |
| **Зорилт 7.1. Эрүүл мэндийн салбарын мэдээллийн технологийг хөгжүүлэх** | | | | | | | |
| 7.1.1 | Эмчилгээ, оношилгоо, сургалтад алсын зайн анагаах ухааныг (теле медицин) өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бүх | - | -телемедиц ины тусламж үйлчилгээ | -алсын зайн оношилг оо 36 | -гүйцэтгэлэ эр | Эмнэлгийн тусламж үйлчилгээнд Телемедицин алсын зайн оношлогоог телеграм, viber, Zoom, MnCardio, Mohs.da.gov.mn зэрэг програмыг ашиглан дээд шатлалын эмнэлгүүдтэй 680 удаа зөвлөгөө авч, мэдээлэл солилцсон. СЭМТ-тэй 8 удаа зөвөлгөө мэдээлэл солилцож тусламж үйлчилгээний хамрах хүрээнд УНТЭ, УГТЭ, ЭХЭМҮТ, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шатлалд хэрэгжүүлж ажиллана. | | авсан иргэдийн тоо<br>- Алсын зайн сургалтад хамрагдсан эмнэлгийн ажилчид | удаа 85 иргэн<br>-1424 мэргэжилтэн | | ГССҮТ ЭСҮТ,ЦСҮТ, СЭМТ зэрэг эмнэлэгүүдтэй хамтран ажиллаж байна.<br>Цахим сургалт 139 удаа давхардсан тоогоор 4558 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна.<br>**Үр дүн**: Алсын зайн оношилогоо, зөвлөгөө 680 удаа авсан байна. Цахим сургалтад давхардсан тоогоор 4558 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. | |
| 7.1.2 | Эрүүл мэндийн цахим мэдээллийн сангаар иргэдийг эрт илрүүлэгт хамруулж, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ. | - | -Цахимаар эргэн дуудах тогтолцоонд хамрагдсан иргэд | умайн хүзүү-3325, хөх-21839 иргэний мэдээллийг шивж оруулан мэдээллийн сан үүсгэн ажилласан байна | гүйцэтгэлээр | 2020 оны 12 дугаар сарын 31 ны өдрийн А/641 тоот тушаалаар “Умайн хүзүүний хорт хавдрын цогц хяналтын заавар”-ыг шинэчлэх тухай тушаалын 2.3 заалтын дагуу “Умайн хүзүүний хорт хавдрын илрүүлгийн бүртгэл мэдээлэл, дуудах-эргэн дуудах тогтолцоог хэрэгжүүлэх, мэдээлэх үйл ажиллагааг тусган зааварласан.<br>• Хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 20-оос дээш насны **31500** эмэгтэй хамрагдахаас **28249** буюу 89.7%-ийн хамрагдалтай. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 17.0 хувиар өссөн байна. Эмнэл зүйн үзлэгээр эерэг өөрчлөлттэй гарсан 32. 13А маягтаар 2-р шатлалд илгээсэн 32. Эрт илрүүлгээр оношлогдсон хавдар-2.<br>• Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 30-60 насны нийт **6795** эмэгтэйхамрагдахаас **4140** буюу 60.9% -ийн хамрагдалтай. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15.5 хувиар өссөн байна. Хавдрын урьдал илэрсэн 142, байран өмөн илэрсэн 1. эдийн шинжилгээ 15, үрэвслийн эсрэг эмчилгээ 103, Leep эмчилгээ 5 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хийгдсэн байна. Эрт илрүүлэгээр хорт хавдар оношлогдсон-3.<br>УХХХ-ын илрүүлгийн дуудах-эргэн дуудах үйл ажиллагаанд **www.cancer-screening.gov.mn** цахим бүртгэлийн үндэсний систем хэрэгжиж, 2022 онд нийт умайн хүзүү 4100, хөх 28240 иргэний мэдээллийг шивж оруулан мэдээллийн сан үүсгэн ажилласан байна. УХХХ-ын илрүүлгийн дуудах-эргэн дуудах үйл ажиллагаанд оролцох эрх бүхий эрүүл мэндийн 9 байгууллагын 72 эмч, мэргэжилтнүүдийн хандах эрхийг олгосон. | |
| 7.1.3 | Эрүүл мэндийн ажилтны цахим бүртгэлийн программ, цахим үйлчилгээг орон нутагт нэвтрүүлнэ | 5,0 сая | Цахим үйлчилгээг нэвтрүүлсэн байна | Шилжих бэлтгэл үе | Цахим үйлчилгээг нэвтрүүлсэн байна | 2022.01.01-ны өдрөөс ЭМЯ, ЭМХТөвөөс Эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийн цахим бүртгэлийн програмыг нэвтрүүлж, эмч эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулах, кредит багц цаг тооцох сургалтууд өдөр бүр мэдээлэгдэж эмч, мэргэжилтнүүд цахим болон танхимын сургалтад хамрагдаж байна. Цахим бүртгэлийн программд эрүүл мэндийн ажилтнуудын 90% бүртгүүлсэн байна.<br>Аймгийн хэмжээнд 487 эмнэлгийн мэргэжилтэн 48 чиглэлийн 153 удаагийн сургалтад хамрагдаж багц цагийн биелэлтийг хангасан байна. | 90 |
| 7.1.4 | Эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний мэдээ, мэдээлэл, эмчийн үзлэг, өвчний түүхийг цахим хэлбэрээр цуглуулах, боловсруулах, дамжуулахтай холбоотой | - | Цахим системийн хамралт | 90% | 100% | “Цахим Монгол” ЗГ-ын мөрийн хөтөлбөрийн хүрээнд Vypress chat, Zoom, Microsoft Teams дотоод сүлжээ ашиглан, байгууллагын хурал, зөвөлгөөн, шуурхай мэдээг цахимжуулж, байгууллагын дотоод сүлжээнд 100% ашиглаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цахим соёлыг төлөвшүүлнэ. | | | | | Даатгалын нэхэмжлэл болон цахим өвчний түүхийн бичилттэй холбоотой сургалтыг 5 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 126 эмч мэргэжилтэн хамрагдсан.<br><br>НЭ-т ашиглагдаж байгаа эмнэлзүйн "E-Health" программ ашиглаж 13035 цахим өвчний түүхийг шивснээс 11643 өвчний түүхийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газраас нэхэмжилсэн. Үүнээс 11240 өвчний түүхийн санхүүжилтыг авсан. 94%-тай санхүүжилт авсан байна.<br><br>H-info 3 болон E-Health программыг Төрөх эмэгтэйчүүд, Нярай, Эмийн модуль ашиглалтад оруулж бүх тасаг нэгж эмийн захиалгаа цахимаар оруулж ашиглалт 100%-тай. Лабораторийн тоног төхөөрөмж болох C411 иммунологи, URESED, Pentra 80X зэрэг аппаратыг программ хангамжинд бүрэн холбосон. | |
| 7.1.5 | Өрх, сумын эрүүл мэндийн төвийг өндөр хурдны интернетийн шилэн кабель, эрүүл мэндийн салбарын нэгдсэн VPN сүлжээнд холбож, E hospital программ хангамжийн ашиглалтыг сайжруулна | 10 сая | -VPN сүлжээнд холбогдсон ЭМБ<br>-E-hospital программ ашиглалт | - | 5 ЭМБ | Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсэг 2 удаа өрх, сумын эрүүл мэндийн төвүүд болон 4 хувийн хэвшлийн эмнэлгүүдийн цахим системийн бэлэн байдалд мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. E-health болон E-hospital програмууд хэвийн явагдаж байгаа бөгөөд хувийн хэвшлийн 4 эмнэлэг нь E-Clinic програм ашиглаж байна. | 100 |
| 7.1.6 | Сүрьеэгийн цахим эмчилгээний хяналтыг нэвтрүүлнэ. | ХӨСҮТ СТН төслөөр | Нэвтрүүлсэн цахим эмчилгээний үр дүн | - | Эмчилгээтэй өвчний 30% | Амбулаторийн диспансерын хяналтад 181 үйлчлүүлэгч эмчийн хяналтад эм ууж байгаагаас 34 өвчтөнг цахимаар video call хийж эмийг уулгаж эмчилгээнд хамруулж байна. | 70 |
| 7.1.7 | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын үйл ажиллагаанд зориулан ашиглаж буй програм хангамж, цахим системийн мэдээллийн санг чанартай бүрдүүлэн, өдөр тутам хяналт тавьж ажиллах ба иргэдэд дараах мэдээллийг | 5 сая | цахим мэдээллийн сангийн үзүүлэлт | 14393 хүний шинжилгээний хариу олгосон | Тохиолдлын тоогоор | (КОВИД-19)-ын шинжилгээний хариуг цаг тухай бүрт нь чирэгдэлгүйгээр **eruul.gerege.mn сайтад** шивж оруулан 5866 хүнд шинжилгээ хийж, иргэдийн шинжилгээний хариуг олгосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цахимаар гарган өгнө. Үүнд:<br>-КОВИД-19 халдварын шинжилгээний хариу -КОВИД-19 халдварын дархлаажуулалтын сертификат<br>-КОВИД-19 халдварын Эмнэлгийн магадлагаа | | | | | | |
| **Зорилт 7.2 Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, эрүүл мэндийн үзүүлэлтийн цаашдын чиг хандлагыг тодорхойлох чадавхийг бэхжүүлэх.** | | | | | | | |
| 7.2.1 | Эрүүл мэндийн ажилтны статитистик мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, ашиглах чадавхийг бэхжүүлнэ. | 200 мян | -Сургалтад хамрагдсан ажилтны тоо | 7 удаа 120 | 150 | H-INFO3, E-Health, Hics_darkhan_ne программ болон Vypress chat, Zoom, Microsoft Teams дотоод сүлжээ ашиглан программ хангамжийг 100% ашиглан дотоод сүлжээний сервер байршуулж мэдээ, мэдээллээ файл хэлбэрээр байршуулсан.<br>Эрүүл мэндийн ажилтны статитистик мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, ашиглах чадавхийг бэхжүүлэхээр ЭМХТ-өөс “Төвийн үйлчилгээг-орон нутагт” сургалтыг зохион байгуулж 100 эрүүл мэндийн ажилтан хамрагдсан.<br>Статитистик мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, ашиглах чадавхийг сайжруулах сургалтыг ЭМГ-аас зохион байгуулж 51 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдсан. | 100 |
| 7.2.2 | Нэгдсэн эмнэлэг, өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд ашиглаж байгаа E-Health программ хангамжийн ашиглалтыг сайжруулна | - | -E-Health программ ашиглалт<br>-Сургалтад хамрагдсан мэргэжилтэн | - | Сургалтад хамрагдсан мэргэжилтэн 100 | Нэгдсэн эмнэлгийн бүх тасаг нэгжүүд өвчний түүхийг E-HEALTH программ дээр шивж байна. Стационарийн 26 тасгийн цахим эмийн захиалга, лабораторийн урвалжийн үнийн шинэчлэлт, төрөлтийн түүх тус бүр цахимд шилжсэн.<br>E-Health програмд эрт илрүүлэгтэй холбоотой тусламж үйлчилгээ болон лабораторийн тохиргоо хийсэн. E-mongolia төрийн үйлчилгээний нэгдсэн платформ дээр Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээ болох<br>1. Амбулаторын кабинетийн цаг авах | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. Шинжилгээний хариу авах<br>3. Эмнэлгийн магадлагаа<br>4. Цусны бүлгийн мэдээлэл<br>5. Эрт илрүүлэгийн эрсдлийн асуумж, эмчийн дүгнэлт нэвтрүүлэн ашиглаж байна.<br>Үйлчлүүлэгчдийн чирэгдлийг бууруулаж шуурхай үйлчлэх зорилгоор Call-pro үйлчилгээг нэвтрүүлж дуудлагын 2 оператор, цахим бүртгэлийн 5 ажилтан ажиллаж үйлчлүүлэгчийг эргэн дуудах, цаг авсан үйлчлүүлэгчтэй 1 хоногийн өмнө холобогдож үзлэгийн цагийг баталгаажуулан ажиллаж байна. Цахим бүртгэлийн нэгдсэн лавлах 1800-0119 үйлчилгээнд Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлэг холбогдож дуудлагын утсаар цаг авсан иргэд 35856, биеэр ирж цаг авч үйлчлүүлсэн иргэд нийт 294486 байна.<br>Өрх, сумын эрүүл мэндийн төв, хувийн хэвшлийн эмнэлгүүдийн цахим системийн бэлэн байдалд мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан. E-health, E-hospital, E-Clinic програм ашиглаж байна.<br>ЭМЯ, ЭМХТ, НЭМҮТ, ЭМДЕГазар, ЭХЭМҮТ, УГТЭ, СЭМҮТ, ШУГТЭ, ХӨСҮТ, Сувилагчдын нийгэмлэгээс зохион байгуулсан 24 удаагийн сургалтад 358 мэргэжилтэн хамрагдсан байна. | |
| 7.2.3 | Нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрүүл мэндийн байгууллага ялангуяа, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын мэдээ, мэдээллийн үнэн зөв, шуурхай байдлыг хангана. | - | Сар бүр тогтмол мэдээ өгдөг ЭМБ | 100% | 100% | Хувийн хэвшилийн эрүүл мэндийн байгууллагуудын мэдээ, тайланг сар бүр цуглуулан авч нэгтгэн цаг хугацаанд нь цахимаар 11 удаа, цаасан хэлбэрээр 11 удаа илгээж , эргэн мэдээллээр хангаж ажилласан . Ортой 12 эмнэлэг мэдээ тайланг цаг хугацаанд нь 100%, үүдэн 55 эмнэлэг 90% , 60 эмийн сангийн мэдээ, тайлан өгөлт 86%-тай байна. | 100 |
| 7.2.4 | Эмнэлгийн мэргэжилтний судалгааны ажлыг хөгжүүлэхийг дэмжиж ажиллана. | 100 мян | - Судалгаан ы ажилд оролцсон эмнэлгийн | 16 | 20 | Дэлхийн эмч нарын өдрийг тохиолдуулан “PROMOTION-2022” Эрдэм шинжилгээний бага хурлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан 8 илтгэлийн материалыг хүлээн авч хэлэлцүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэргэжилтэн | | | АШУҮИС-ийн Дархан-Уул аймаг дах салбар сургуультай хамтран "СУВИЛАХУЙН ХӨГЖИЛ-22" эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж 14 илтгэл, Олон улсын сувилагчдын өдрийг угтан "СУВИЛАХУЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛЪЯ" эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж 14 илтгэл хэлэлцүүлж, шалгарсан илтгэгч нарыг цалингийн хувиар урамшуулсан.<br><br>**Үр дүн**: Дэлхийн эмч нарын өдрийг угтан онол практикийн хурлаас шалгарсан эхний 5 байрыг, сувилагчийн өдрийг угтан онол практикийн хурал зохион байгуулж шалгарсан эхний 5 байрыг тус бүр цалингийн 15-40%-иар урамшуулсан. | |
| **Зорилт 7.3. Хувь хүн, байгууллага, эрүүл мэндийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах** | | | | | | | |
| 7.3.1 | Хувь хүн, байгууллага, эрүүл мэндийн мэдээ мэдээллийн нууцын аюулгүй байдлыг хангана | 100.0 мян | Сургалтад хамрагдсан ажилтны тоо | -Хувь хүний мэдээллийн нууц 105<br>-Байгууллагын нууцын аюулгүй байдал 112<br>-Мэдээ мэдээллийн нууцын аюулгүй байдал 113 | Хувь хүний мэдээллийн нууц 110<br>-Байгууллагын нууцын аюулгүй байдал 120<br>-Мэдээ мэдээллийн нууцын аюулгүй байдал 120 | НЭ цахим мэдээллийн нууцлал аюулгүй байдал хариуцсан ажилтан томилон хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийн дагуу нийт ажилчдын цаг бүртгэлийг хурууний хээ унших системийг устган нүүр таниулах бүртгэлд шилжсэн.<br>Хувь хүний мэдээллийн аюулгүй байдал, жендэрийн тухай ойлголт сургалтыг АЗДТГ-ХЗХ-ээс зохион байгуулж 48 албан тушаалтан хамрагдсан.<br>Байгууллагын нууцын тухай хууль, хувь хүний нууцын тухай хууль, эрүүл мэндийн мэдээ мэдээллийн нууцлалтай холбоотой 4 удаагийн сургалтыг зохион байгуулж 317 ажилтан хамрагдсан.<br>Компьютер , сүлжээ , камер , вэб сайт зэрэг зүйлсийг ашигладаг бөгөөд төхөөрөмж бүр дээр нууцлал, аюулгүй байдлын нууц үг, программ хангамж суурьлуулан ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр мэдээллийн технологийн 4 мэргэжилтэн чадавхжуулах сургалтад хамрагдсан.<br>сургалт авсан.<br>Ажилтан бүр мэдээллийн аюулгүй байдлыг хангаж компьютерийн код суулгасан.<br>Үр дүн: Хувь хүн, байгууллага, эрүүл мэндийн мэдээ мэдээллийн нууцын аюулгүй байдлыг хангах сургалтад 365 албан хаагч хамрагдсан. | |
| 7.3.2 | Гэмт хэрэг, зөрчилөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтмол зохион байгуулна | 100.0 мян | Сургалтад хамрагдсан ажилтны тоо | 1 удаа 48 ажилтан | Сургалтад хамрагдах ажилтны тоо 100 | Дархан-Уул аймгийн иргэдийн төлөөлөгчдийн Хурал, ГХУСАЗСЗ-өөс гаргасан "Архидалтын эсрэг" уриалгыг дэмжиж Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2 арга хэмжээ 12 ажлыг төлөвлөж хэрэгжилт 96% байна.<br>Сэтгэцийн тасгаас "Архигүй хамт олон" сургалтыг зохион байгуулж 228 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.<br>Эрүүл мэндийн байгууллагуудын дунд ."Архигүй орчин архидалтгүй амьдралын төлөө хамтдаа" уриалгыг дэвшүүлж тик ток челленжид 56 байгууллага нэгдсэн.<br>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх хүрээнд Эрүүл мэндийн газрын даргаар батлуулсан удирдамжийн дагуу 6 чиглэлд үнэлгээ хийж давхардсан тоогоор 18 төрлийн зөвлөмж өгөгдсөн байна. Зөвлөмжийн хэрэгжилт 96.7% байна. | 100 |
| 7.3.3 | Эрүүл мэндийн газар, болон эрүүл мэндийн байгууллагуудын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг шинэчилж, хэрэгжилтийг хангана. | 500.0 мян | Дотоод журам боловсруулан хэвлэгдсэн байна. | 200 ширхэг | Боловсруулсан дотоод журам | Хөдөлмөрийн тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг шинэчилсэн ба өөрчлөлт оруулсан заалтыг бүх ажилчдын хурлаар хэлэлцүүлсэн. | 90 |
| 7.3.4 | Архивын нэгжид зөвлөн туслах үйл ажиллагааг аймгийн Архивын тасаг, ХЗХ-тэй хамтран зохион байгуулна | 200.0 | Стандартын дагуу зохион байгуулсан архивын нэгж | - | Стандартын дагуу зохион байгуулсан архивын нэгж | Ерөнхий архивын газрын 2014 оны "Эрүүл мэндийн салбарын баримт бичгийн нэр, төрөл, хадгалах хугацааны жагсаалт", "Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам"-ын дагуу байгууллагын архивын баримтыг бүрдүүлэх, бүртгэх, нягтлан шалгалт хийх, хадгалах, хамгаалах, мэдээллийн сан үүсгэх, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашиглуулах, төрийн архивын байнгын хадгалалтад шилжүүлэхтэй холбогдсон бичгүүдийн талаарх мэдээлэл зөвлөгөөг аймгийн архивын газраас авсан. ЭМГ-ын архивыг он цагийн дараалллаар болгон Хөмрөг №1, Данс №1-4, буюу нийт ХН№ 1480 бичиг баримтыг холбогдох журам стандартын дагуу хадгалах, хамгаалах, он цагийн дарааллын дагуу байнга хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, түр хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, 70 жил хадгалах хадгаламжийн нэгжийн бүртгэл, 20 жил хадгалах нэгжийн бүртгэл, 50 жил хадгалах нэгжийн баримтууд хадгалагдаж байна. Мөн хадгалах хугацаа дууссан баримтыг устгах 183 материалыг аймгийн архивын газар санал хүргүүлсэн. | |
| 7.3.5 | Эрүүл мэндийн байгууллагуудын “Эцэг эхийн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлаж, үйл ажиллагааг хэрэгжүүлж ажиллана. | 2.0 | зохион байгуулах үйл ажилалгаа | - | зохион байгуулсан үйл ажилалгаа | Хүүхэд хамгааллын жилийн хүрээнд Эрүүл мэндийн салбарын эцэг эхийн зөвлөлийн гишүүдийг байгууллага бүр шинэчлэн батлуулан 2 чиглэлд 10 ажлыг төлөвлөн сар бүр хэрэгжилтийг гарган үр дүнг тооцон ГБХЗХГ-т тайлагнан ажиллаж байна. Үүнд:<br>➢ Эрүүл мэндийн газарт эмнэлгийн ажилчдын хүүхдэд зориулсан хүүхдийн өрөөг тохижуулсан<br>➢ Эрүүл мэндийн сургалт мэдээллийг цахимаар 2 удаа зохион байгуулж албан хаагчдын 21 хүүхэд хамрагдсан.<br>➢ Хүүхдүүдийн дунд гар зураг, зохион бичлэгийн уралдаан зарлаж, урамшуулсан.<br>➢ Эрүүд шүд-Эрүүл хүүхэд аяныг өрнүүлж ЭМБ-ын ажилчдын 52 хүүхдийн шүдийг эмчлүүлсэн.<br>➢ Эмнэлгийн ажилчдын хүүхдийн судалгааг шинэчлэн гаргасан. | 100 |
| 7.3.6 | Аймгийн Жендерийн дэд хөтөлбөрийн хүрээнд Эрүүл мэндийг дэмжих төвд эрчүүдийн эрүүл мэндийн кабинетийг нээж | 3.0 | кабинетаар үйлчлүүлсэн эрэгтэйчүүдийн тоо | - | гүйцэтгэлээр | Эрүүл мэндийн сайдын 2021.09.09-ны өдрийн А/559 дугаар тушаалаар “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөөг 4 зорилт 17 үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжилт 93.8%-тай байна. ”Эрүүл идэвхтэй амьдарцгаая” аяны хүрээнд “Эрчүүдээ хайрлая” урьдчилан сэргийлэх үзлэгт 300 эрэгтэйчүүд хамрагдаж, халдварт бус өвчлөлийн эрсдлийг тодорхойлж, зөвлөгөө, мэдээлэл | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагааг тогтмолжуулна. | | | | | өгсөн. Нэгдсэн эмнэлэг нь Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр Урологийн кабинет шинээр нээж үйл ажиллагаагаа эхлүүлсэн ба түрүү булчирхайн томролттой 14 хүнд дурангаар аргаар мэс засал хийсэн. Эрэгтэйчүүдийн тусламж үйлчилгээг үзүүлдэг 1 хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага ажиллаж байгаа бөгөөд 107 үйлчлүүлэгчид тусламж үйлчилгээг үзүүлж, зөвлөгөө мэдээллээр хангасан байна. Аймгийн засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтэстэй хамтран Жендерийн тухай ойлголт, хийж хэрэгжүүлж байгаа арга хэмжээ сургалтыг зохион байгуулж 84 эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчид хамрагдсан байна. | |
| 7.3.7 | Эрүүл мэндийн газрын даргын зөвлөлийн үйл ажиллагааг сар бүр хуралдуулж, салбарын тулгамдаж байгаа асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ. | 500.000 | шийдэвлүүлэх арга хэмжээ | - | шийдэвлэсэн арга хэмжээ | Эрүүл мэндийн газрын даргын зөвлөл 9 удаа хуралдаж Эмнэлгийн тусламж үйлчилгээ, НЭ, ӨЭМТ,СЭМТ-ийн хийгдэж буй үйл ажиллагаа, тулгамдсан асуудал, Хавдрын тусламж үйлчилгээ, Эх барих эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ, ЭМБ-ын ХШҮ, Эрүүл мэндийн байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн хэрэгжилт, үр бүтээлтэй ажиллаж байгаа эмч эмнэлгийн ажилчдыг шагналд нэр дэвшүүлэх журмын дагуу эмнэлгийн мэргэжилтний материалыг тус тус хэлэлцүүлэн шийдвэрлэж ажилласан. | 100 |
| 7.3.8 | Эрүүл мэндийн байгууллагуудад ХАБЭА-н сарын аяныг өрнүүлж, ажиллах таатай орчин нөхцлийг (гадаад, дотоод) бүрдүүлж ажиллана . | 5.0 | зохион байгуулсан үйл ажиллагаа | - | хууль тогтоомжийн хэрэгжилтийн 95 % | ЭМГ нь ажилчдын хүүхдийн өрөөг гарган тохижуулсан. Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 850 сая төгрөгийн их засвар хийгдсэн. Сүрьеэгийн лабораторийн урсгал засвар, Сүрьеэгийн олон эмийн дасалтай 1 давхрын их засварыг ОНХО-оор, Нэгдсэн Эмнэлэг дулааны узель шинээр хийж дулааны тоноглолыг бүрэн суурилуулсан. Гэмтлийн тасгийн ажилчдын амралтын өрөөг эмнэлгийн эмч, ажилтны хандив тусламжаар засварласан. Уламжлалт тасаг иргэдийн хандив, тусламжаар тасгийнхаа эмчилгээний өрөө, ариун цэврийн өрөө, коридорийг иж бүрнээр нь засварласан. Поликлиник I тасаг нь хамт олон, хувь хүмүүсийн дэмжлэг, хандив тусламжаар ажилтнууддаа | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зориулан амралтын өрөөг иж бүрэн тохижуулсан. Поликлиник-2 тасаг өөрсдийн нөөц бололцоогоор тасагтаа сургалтын өрөөг шинээр засварлан тохижуулсан. ХАЯТ-ын тасаг амралтын өрөөнд урсгал засвар хийж ажилчдыг дулаан хувцасаар хангасан.<br>Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газар, Нэгдсэн эмнэлгийн Сэтгэцийн тасаг хамтран архины хамаарал бүхий зорилтот бүлгийн иргэдийг хэвтэн эмчлүүлэх сэргээн засах өрөөг тохижуулсан. Дархан сумын Засаг даргын 02 дугаар Албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Хоггүй Дархан хотын төлөө Хамтдаа” уриалгыг дэмжин ЭМБ-ууд хашааны дотор, гадна орчны цэвэрлэгээ хийж, хашаагаа будсан. Поликлиник-2 тасгийн хамт олон Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн сарын аянд хамт олон ажилчид болон үйлчлүүлэгчдэд ая тухтай орчинг бүрдүүлэн ажиллах зорилтын дагуу тасгийнхаа коридор, өрөө тасалгааны гэрэлтүүлэг, цахилгааны аюулгүй байдлыг засварлан, үйлчлүүлэгчдийн хүлээлгийн сандлыг шинэчилсэн. Халдвартын тасгийн Сүрьеэгийн лаборатори байрлаж байсан корпусыг халдвартын тасгийн амбулатори болгон **“Ковид -19” халдварын PCR шинжилгээний цэгийг** байршуулан ажиллаж байгаа бөгөөд байгууллага болон тасгийн хамтын тусламж дэмжлэгээр засварласан.<br>Мэдс-тоб ӨЭМТ нь төв салбарын гаражийг засварлаж тусламж үйлчилгээний 2 өрөө гаргасан.Коридорыг хулдаасалж, хөшиг сольсон. Эмнэлгийн гаднах пасадыг өнгөлөсөн. Мангирт салбарын угаалтуур, 00 өрөөг засварласан. Ажилчдын ая тухтай байдлыг хангаж ус шүүгч авч байршуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Гэрэлтэй ӨЭМТ Камержуулалт хийсэн, ажлын хувцас шинэчилсэн. Орхон СЭМТ эмнэлгийн дотор их засвар хийсэн. Шарын гол СЭМТ Чийрэгжүүлэлтийн өрөөг тохижуулж, 6 төрлийн 21ш тоног төхөөрөмжөөр хангасан. | |
| **Зорилго 8. Эрүүл мэндийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгон, ил тод байдлыг дэмжиж ажиллана.** | | | | | | | |
| **Зорилт 8.1. Эрүүл мэндийн салбарын бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгож, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хамруулахад төр, хувийн хэвшлийн түншлэлийг өргөжүүлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний ил тод байдлыг хангаж, хамтын удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 8.1.1 | Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулж эмнэлгийн ачаалал хуваалцах, оношилгоо, эмчилгээний дутууг нөхөн тусламж үйлчилгээний тасралтгүй, шуурхай хүртээмжтэй байдлыг ханган үр дүнг тооцож ажиллана | 1 сая | -гэрээ байгуулан ажилласан эмнэлэг<br>-Ачаалал хуваалцсан хувь | -12 ортой эмнэлэг -50% | 20 эмнэлэг 50% | Дархан-Уул аймагт тусгай зөвшөөрөл бүхий 70 эмнэлэг үйл ажиллагаа явуулж, эмнэлгийн ачаалал хуваалцах, оношилгоо, эмчилгээний дутууг нөхөн тусламж үйлчилгээний тасралтгүй, шуурхай хүртээмжтэй байдлыг ханган ажиллаж байна. Хувийн эмнэлэт хэвтэн эмчлүүлсэн 11314 буюу нийт хэвтэн эмчлүүлсэн хүний 39%, амбулаторийн үзлэг 142847 буюу нийт үзлэгийн 22.2% эзэлж байна. Хувийн хэвшлийн ортой эмнэлгийн үзлэг 72056 буюу 11.2% , шүдний эмнэлгийн үзлэг 49707 буюу 70.7%, үүдэн эмнэлгийн үзлэг 3.2% эзлэж байна . Эмэгтэйчүүдийн эмчийн үзлэгийн 46.6%, хүүхдийн эмчийн үзлэгийн 26.3%-ийг эзлэж эмнэлгийн тусламж үйлчилгээний ачааллын хуваалцаж байна. | 100 |
| 8.1.2 | Нэгдсэн эмнэлгийг хамтын удирдлагатай, хагас бие даасан засаглалтай болгож,тусламж үйлчилгээг сайжруулна. | - | Төлөөлөн удирдах зөвлөл байгуулсан байна | - | - Төлөөлөн удирдах зөвлөлтэй болсон байна | Нэгдсэн эмнэлэгт ТУЗ байгуулахтай холбоотой аймгийн Засаг даргын 2022 оны 3 сарын 2 өдрийн 01-А/47 тоот захирамжаар орон нутгийн өмчит нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн олон нийтийн төлөөллийг сонгон шалгаруулах хороог 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулсан. Тус хороо нээлттэй сонгон шалгаруулалтын зарыг 14 хоногоор тус бүр 2 удаа цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлаж нэр дэвшигч 5 гишүүний холбогдох бичиг баримтыг хүлээн | 70 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | авсан. Хороо урьдчилсан сонгон шалгаруулалтыг 3 удаа хуралдсан. Нэр дэвшигчийн материалтай танилцан, ярилцлага хэлбэрээр зохион байгуулсан. Даатгуулагчийн олонхийн эрх , хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан байгууллагын төлөөлөл, Эрүүл мэндийн мэргэжлийн нийгэмлэг, холбоо, мэргэжлийн салбар зөвлөлийн төлөөллийг сонгон шалгаруулсан. | |
| 8.1.3 | Эрүүл мэндийг дэмжих төвийг байгуулж, шаардлагатай тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтыг хийж ажиллана. | 1.8 тэрбум | -Хүний нөөц<br>-Тоног төхөөрөмж | - | -Хангагдсан тоног төхөөрөмж | ”Эрүүл мэндийн дэмжих төв"-ийг улсын төсвийн 1850.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар иж бүрэн засвар үйлчилгээг хийж, чих хамар хоолойн үзлэгийн дуран, тимпанаметр, аудиометр, спирометр, биеийн бүтэц тодорхойлох аппарат, автомат жин (өндөр хэмжигчтэй), ясны сийрэгжилт үзэх аппарат, тархины доплер, ачаалалтай зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, зүрхний цахилгаан бичлэгийн аппарат, нүдний хараа шалгах таблиц, слит ламп, авторефракто /кератометр аппарат/, суурин ЭХО аппарат Зөөврийн ЭХО аппарат, уян дуран, шүдний кресло, автоклав, ломбоны гэрэл, шүдний рентген аппарат /зөөврийн/, шүдний чулуу өнгөр цэвэрлэх чичиргээт машин, шүлс соруулах, зөөврийн аппарат, соруулагчийн гар зэрэг 34 нэр төрлийн 95 ширхэг 796.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авч суурилуулсан. Нэгдсэн эмнэлгийн ерөнхий эмчийн 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/47 дугаар тушаалын дагуу хүний нөөцийн төлөвлөлт, бүтэц зохион байгуулалт төлөвлөж, нийт 7 албан хаагч томилогдсон. Амбулторийн эмч нарын зохицуулалт хийж ажиллаж байна.<br><br>**Үр дүн**: 34 нэр төрлийн 95 ширхэг 796.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авч суурилуулан 4 сараас үйл ажиллагаа эхлүүлсэн. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Эмнэлгийн ажилчдыг ажлын байранд чадавхижуулах сургалтыг ЭМЯ болон ЭМХТ-тэй хамтран цахим сургалтад 5 удаа нийт давхардсан тоогоор 54 ажилтан хамрагдсан. | |
| 8.1.4 | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг хангана.<br>-Хүний нөөцийн<br>-Үйл ажиллагааны<br>-Төсөв, санхүүгийн<br>-Мэдээллийн | 300 мян | -Мэдээлэл тавигдсан байдал<br>-Хэрэгжилтийн хувь | -Хэрэгжилтийн хувь 98% | Хэрэгжилтийн хувь 98% | Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай хуулиуд, ЗГ-ын 2012 оны 17-р тогтоолоор батласан **“Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад** дагаж мөрдөх журам”, 2016 оны 29-р тогтоолоор батласан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг тус тус баримтлан төсөв санхүүгийн мэдээллийг ил тод нээлттэй мэдээллэж ажиллаж байна. Шилэн дансны мэдээллийг ЭМ-ийн 10 байгууллага мэдээллийг бүрэн оруулж мэдээллэсэн боловч 3 байгууллага 3 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн байна. Үүнд: ЭМГ 2-р сард 1 мэдээлэл, Шарын гол СЭМТ 1 сард 1 мэдээлэл, Түвшинхолбоо 1-р улиралд оруулах 1 мэдээлэл хугацаа хоцроож мэдээллэсэн. Шилэн дансны хэрэгжилт 98.9 хувьтай байна.<br>**Хүний нөөцийн ил тод байдал**: 2022 онд нийт төрийн үйлчилгээний эрүүл мэндийн байгууллагуудад шинээр ажилд орсон 67, ажлаас гарсан 56 байна. Эрүүл мэндийн байгууллагууд сул орон тоо гарсан тухайн алба, тасаг нэгжээс ажлын байрны зарыг ЭМХТ-ийн цахим сайт hr.hdc.gov.mn 85 удаа, өөрийн www.mohs.da.gov.mn вэб сайт, фэйсбүүк хаягаар 67 удаа орон нутгийн өргөн нэвтрүүлгийн телевиз DBS-ийн нээлттэй зараар 18 удаа, хөдөлмөр халамж үйлчилгээний газрын ажлын зар мэдээгээр 2 удаа ил тод байршуулан зар түгээж ажилласан. Нийт 172 удаа мэдээлэл таьж ажилласан. ЭМГДаргын тушаалаар сонгон шалгаруултын комисс ажилладаг.<br>**Үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдал**:<br><br>ЭМБ-уудын үйл ажиллагааны болон мэдээллийн ил тод байдлыг хангаж ЭМГ болон ЭМЯ-ны цахимд тухай бүр мэдээллийг байршуулан | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллаж байна. Эрүүл мэндийн газар нь өөрийн Вэб сайт, цахим хуудас болон Орон нутгийн мэдээлэл технологийн алба, ДИ БИ ЭС, Аа ЖИ БИ, ЦЭЦ.МН сайт, Нэгдсэн эмнэлэг, 5 өрхийн эрүүл мэндийн төв, 3 сумын эрүүл мэндийн төвийн цахим хуудсаар дамжуулан салбарын үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг өдөр бүр иргэд олон нийтэд хүргэж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллаж байна. **Цахим хуудасны нийт хандалт 74200. Нийт дагагч 10900.**<br><br>Эрүүл мэндийн газар нь Аа Жи Би, Ди Би Эс телевиз, Цэц.мн сайттай хамтран ажиллах гэрээний хүрээнд тодруулга мэдээлэл 56, Хэвлэлийн бага хурал 3, Үйл явдлын мэдээлэл 72, НЭМ-ийн тэмдэглэлт өдрүүдийн үйл ажиллагааны мэдээлэл 23, Урьдчилан сэргийлэх шторк, зөвлөмж 52, нийт 218 удаа 789 дугаарын давтамжтайгаар тус телевизийн сувгаар иргэд олон нийтэд түгээсэн байна.<br><br>Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газрын мэдээлэл технологийн хэлтэстэй хамтран Залуучууд театрын гадна дэлгэцэд зурган мэдээлэл, зөвлөмжийг 300 удаагийн давтамжтай олон нийтэд түгээсэн. Орон нутагийн 1900-1945 зарын сонинд 7 хоног бүр зөвлөмж, мэдээлэл хэвлүүлэн гаргаж байна. | |
| 8.1.5 | Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад иргэн, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж Нийгмийн эгэх хариуцлагын сайн туршлагыг нэвтрүүлэн ажиллана. | - | Хамтран ажилласан байгууллага | 7 | 10 | 2022 оныг ЭМЯ-аас “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах” жил болгосонтой холбоотой Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад иргэн, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж Нийгмийн эгэх хариуцлагыг дээшлүүлэхээр ЭМБ-аас 5 удаагийн хэлэлцүүлэг, нээлттэй хаалганы өдрийг 2 удаа тус тус зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт АЗДТГ-ын НБХ, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төвийн удирдлагууд, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, ХХЭМБ, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ахмадын холбоо, Эмэгтэйчүүдийн холбоо, ХБИ-ийн холбоо, Ажил олгогч эздийн холбоо болон 82 иргэдийн төлөөлөл оролцсон ба тусламж үйлчилгээг сайжруулахад олон нийтийн эрүүл мэндийн ажилтан 10 бэлтгэж сайн туршлага нэвтрүүлсэн.<br>" Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн холбоо"-той хамтран "Тэмүүлэлтэй хүүхдүүд-Тэвчээртэй ээжүүд" сэдэвт аяны хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн төлөөл болсон 37 эцэг эхчүүдэд ''Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөдөлгөөн засал эмчилгээ''- сэдвээр сургалт хийж, мэдээлэл зөвлөмжийг өгч ажилласан. Мөн хүүхдийн тасаг "Good new bors" төрийн бус байгууллагатай хамтран амжиргааны түвшин доогуур айлын хүүхдүүдэд ХӨЦМ-ийн сургалтыг зохион байгуулж, витаминжуулалтын ажлыг зохион байгуулсан.<br>Дархан гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг, Залуус хөгжлийн төвтэй хамтран мэргэжилтэн О.Ган-Эрдэнэтэй хамтран ДОХ/БЗДХ талаар 25 иргэн, 50 эмнэлгийн ажилчдадсургалт зохион байгуулсан.<br>Үр дүн: 10 ТББ-тай Нийгмийн эгэх хариуцлагын хүрээнд хамтран ажилласан байна. | |
| 8.1.6 | Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллагын асуудлыг шийдвэрлэж ажиллана | - | -тусгай зөвшөөрлийн комиссын хурлын тоо<br>-захирамж гаргасан тоо<br>-ААНБ тоо | Хурал-4<br>Захирамж-4<br>Байгууллага-90 | Хурал-3<br>Захирамж 3<br>Байгууллага 20 | Тусгай зөвшөөрлийн ажлын алба 4 удаа, Эрүүл мэндийн чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох комисс 4 удаа хуралдаж, Аймгийн засаг даргын 01-А/185, 01-А/219, 01-А/306, 01-А/332 тоот захирамжаар Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуй нэгж байгууллагын нийт 52 асуудлыг шийдвэрлэж ажилласан. Үүнд:<br>➢ Хугацаа сунгах 37<br>➢ Шинээр зөвшөөрөл олгосон 12<br>➢ Хаяг байршилд өөрчлөлт оруулсан 2 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ➢ Хүчингүй болгосон 1 байна.<br>Шинээр хүсэлт ирүүлсэн байгуулагад шинжээч ажиллаж, дүгнэлтээ комисст танилцуулж, шинээр тусгай зөвшөөрлийг 12 байгууллагад олгож хүсэлтийг шийдвэрлэж ажилласан.<br>Үр дүн: 52 байгууллагын асуудлыг шийдвэрлэж ажилласан. | |
| 8.1.7 | Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандарт, удирдамжийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх, мэргэжлийн удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлнэ | 1 сая | Өгсөн зөвлөмж<br><br>Хэрэгжилтийн хувь | ХШҮ 3 удаа хийсэн 51 төрлийн зөвлөмж Хэрэгжилт 95.6% | ХШҮ 4 удаа зөвлөмж Хэрэгжилт 96% | ЭМГ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Эрүүл мэндийн салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний стандарт, удирдамжийн хэрэгжилтэд 4 удаа хяналт-шинжилгээ үнэлгээ хийж 28 төрлийн зөвлөмж, мэргэжлийн удирдлага арга зүйн дэмжлэг үзүүлж ажилласан ба зөвлөмжийн хэрэгжилт 96.4% байна.<br>Үр дүн: ЭМБ-уудад 4 удаа ХШҮ хийж, 28 төрлийн зөвлөмж өгч, зөвлөмжийн хэрэгжилт 96.4% байна. | 100 |
| 8.1.8 | Аймгийн иргэдийн хурал болон иргэний танхимаар тусламж үйлчилгээтэй холбоотой асуудлыг хэлэлцүүлж холбогдох шийдвэрийг гаргуулж хэрэгжүүлж ажиллана | - | Хэлэлцэх асуудал | 4 | 5 | Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/360 дугаар захирамжийн дагуу аймгийн Эрүүл мэндийн салбар зөвлөлийн хурлаар хүн амын халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг оношилгооны зохион байгуулалт хэрэгжилт, Эх хүүхдийн эндэгдлийг бууруулах талаар аймгийн хэмжээнд зохион байгуулж буй арга хэмжээ, Хүн амын зөв зохистой хооллолт сургалт нөлөөллийн үйл ажиллагааны үр дүн, Халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх арга хэмжээ зэрэг 4 асуудлыг хэлэлцэж 3 асуудлыг шийдвэрлэсэн.<br>АИТХ-аар “Сүрьеэгийн тусламж үйлчилгээ, тулгамдсан асуудал”-ыг хэлэлцүүлсэн.<br>Үр дүн: АИХ болон аймгийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн хурлаар нийт 5 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. | 100 |
| 8.1.9 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбар | - | -Хурлын тоо<br>-хамрагдсан хүүхэд | 19 удаа хуралдаж 413 хүүхдийн асуудлыг 100% | -Хурал 20 удаа<br>-Шийдвэрлэлт | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс 20 удаа хуралдаж 347 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг үнэлэн салбар комиссоор хэлэлцүүлж, асаргаа сунгаж, хөгжлийн бэрхшээлийн тодорхойлолт олгосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана | | - Шийдвэрлэлтийн тоо, хувь | шийдвэрлэсэн. | гүйцэтгэлэ эр | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд нийгэм хамгаалал, хүүхдийн суурь өвчний эрт үеийн оношлогоо эмчилгээ сэдвээр сургалт хийж, 97 хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч хамрагдсан.<br>Үр дүн: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбар комисс 347 хүүхдийн асуудлыг шийдвэрлэж ажилласан. | |
| **Зорилт 8.2. Эрүүл мэндийн байгууллагуудад өргөтгөл, засвар үйлчилгээ хийх, орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх** | | | | | | | |
| 8.2.1 | Сумын эрүүл мэндийн төвийн байр ашиглалт, урсгал засварын зардлыг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн дагуу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ. | - | -Урсгал засварт зарцуулсан төсөв | - | Шарын гол сумын байранд урсгал засвар хийнэ | Эрүүл мэндийг дэмжих төв нь улсын төсвийн 1850,0 сая хөрөнгө оруулалтаар иж бүрэн засвар үйлчилгээ хийж , ЭМЯ-наас 34 нэр төрлийн 95 ширхэг тавилга, тоног төхөөрөмжөөр хангагдсан ба хүний нөөцийн төлөвлөлт, бүтэц зохион байгуулалт хийж үйл ажиллагааг 4 сараас эхлүүлсэн.<br>Хонгор сумын ЭМТ улсын төсвөөр /486,000,000/ төгрөгний 23х13 299м2 бүхий 8 өрөө 1 давхар өргөтгөл хийгдэж, ашиглалтад орсон. Урсгал засварын зардалд 18,2 сая төгрөгийг зарцуулсан байна. Үүнд: Ковид халдварт өвчнөөс сэргийлэх тусгаарлах вакум хаалт, хаалга, цонх, Камер суурьлуулах, хөргөгч засвар, түргэн тусламжийн дуудлагын фургон машинд сэлбэгийн засвар, өргөтгөлийн арк гаргах, эмийн өрөө, коридорын засвар.<br>Шарын гол СЭМТ-ийн барилгын дотоод урсгал засвар, тохижилтод 33.0 сая төгрөг зарцуулсан.<br><br>Орхон СЭМТ-ийн дотор талын их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн, зарцуулсан төсөв 58.0 сая | 100 |
| 8.2.2 | Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгийн засвар, тохижилтийн ажлыг хийнэ. | - | -Хүүхдийн тасгийн завсар хийгдсэн байна. | - | Хүүхдийн тасгийн завсар хийгдсэн байна. | Хүүхдийн тасгийн засвар үйлчилгээг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 859.900.000 төгрөгийн санхүүжилтээр бүрэн засварлаж, 50 хүүхдийн ор, шкафийг шинэчлэсэн.<br>Хүүхдийн тасгийн их засвар үйлчилгээг ОНХО 859,9 сая төсөвлөгдөж "ӨСӨХ БУЯНТ ТУЛГА" ХХК гүйцэтгэгч компани тендерт шалгарч, 2022 оны 8 сараас их засварын | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажил эхэлж 10 дугаар сарын 31-нд засварын ажил дууся хүлээлгэн өгсөн. “Шарийн гол” ХХК х 100 сая үнэ бүхий хүүхдийн ор, тавилгыг хандивласан. | |
| 8.2.3 | Гадаад дотоодын төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг дэмжиж хамтран ажиллана. | - | -Хэрэгжсэн төсөл хөтөлбөр, үр дүн | 1 (ДЭМБ) | 1 | МОНПЭН санаачлагын хүрээнд ХБӨ/ЗСӨ-өөс сэргийлэх, хянах тусламж үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай багцыг ЭМАШТҮ-ний түвшинд хэрэгжүүлэхэд мэргэжил аргазүйгээр хангах, үр дүнг тооцож, зөвлөмж өгөх зорилгоор 5 сард ЭМГ-ын даргын баталсан удтрдамжийн дагуу сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд дэмжлэгт хяналт, үнэлгээ хийж 18 төрлийн зөвлөмж хүргүүлж ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилтийн дагуу дэмжлэгт хяналтыг 2 удаа зохион байгуулсан. Дэмжлэгт хяналтыг 4 чиглэлээр 18 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийж 8 төрлийн зөвлөмж өгч арга зүйгээр ханган ажилласан. ЭМГ-аас Монпэн санаачлагын хэрэгжилтийг сайжруулах, эмч мэргэжилтний чадавхийг сайжруулахаар сургалт зохион байгуулж ӨЭМТ, СЭМТ-ийн 14 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан. Монпэн санаачлагын хүрээнд ашиглагдаж буй MN.Cardio цахим програмын ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор УГТЭ-н мэргэжилтэнтэй хамтран ZOOM-р сургалт зохион байгуулж 17 эмч хамрагдсан. MN.Cardio цахим програмд нэвтрэх эрхийг өрх, сумын ЭМТ-ийн 12 эмчид шинээр нээж, ашиглах видео хичээлийг хүргүүлсэн. | 100 |
| **Зорилго 9. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, бэлэн байдлыг ханган ажиллана.** | | | | | | | |
| **Зорилт 9.1.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх чиглэлээр шуурхай арга хэмжээ хэрэгжүүлж ажиллана.** | | | | | | | |
| 9.1.1 | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас сэргийлэх, цар тахалтай тэмцэх чиглэлээр салбар дундын оролцоо бүхий багаар халдварын нөхцөл байдал, эрсдэлд тухай | - | -Эрсдлийн үнэлгээ -Төлөвлөлт хийсэн байдал -Хэрэгжилт | -Эрсдлийн үнэлгээ 4 удаа “ӨНДӨР”, “МАШ ӨНДӨР” -Ковид-оос | -Эрсдлийн үнэлгээ шаардлагатай тухай бүр хийх -Төлөвлөлт тухай бүр | Гамшгийн үеийн болон халдвар цар тахлын үеийн бэлэн байдлыг хангах төлөвлөгөөнд тодотгол хийж байгууллагын төлөвлөгөөг аймгийн онцгой байдлын газраар хянуулан батлуулан ажиллаж байна. Эм, эмнэлгийн хэрэгсэл, хүний нөөц, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган ажилласан. Нөөцийн бэлэн | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бүрт үнэлгээ хийж, хариу арга хэмжээний төлөвлөгөөгөө тодотгон төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. | | | сэргийлэх бэлэн байдлын төлөвлөлт 4 удаа Ковидын халдварын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 98% | - Хэрэгжилт 98% | байдлын үнэлгээг 3 удаа хийж, 11 төрлийн зөвлөмж өгч ажилласан.<br><br>Аймгийн ЗД-ын захирамжаар томилогдсон эрсдэлийн үнэлгээний ажлын хэсэг SARS-CoV-2 вирусийн омикрон BA4, BA5 хувилбараар үүсгэгдсэн халдварын улмаас үүсэх эрсдэл ямар вэ? гэсэн сэдвээр эрсдэлийг тодорхойлж **ӨНДӨР** эрсдэлтэй үнэлэгдсэн. Үнэлгээний үр дүнд цаашид хэрэгжүүлэх нийт 15 заалт бүхий үйл ажиллагаа, төлөвлөгөөний саналыг АОК-т хүргүүлсэн.<br>Долоо хоног бүр Короновируст халдварын тархалын үе шатны үнэлгээг ЭМС-ын 2022 оны 207 дугаар тушаалын дагуу хийж байгаа бөгөөд 2022 оны 47-р долоо хоногийн байдлаар Дархан-уул аймгийн хэмжээнд шинээр илэрсэн тохиолдлын тоогоор ногоон түвшинд байна.<br>**Үр дүн:** 2022 оны 47-р долоо хоногийн байдлаар Дархан-уул аймгийн хэмжээнд шинээр илэрсэн тохиолдлын тоогоор ногоон түвшинд байна. | |
| 9.1.2 | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээг шуурхай авах зорилгоор эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн бэлэн байдлын талаарх мэдээллийн санг бүрдүүлж, **burtgel.moh.mn**-д мэдээллийг тогтмол бүртгэж, шаардлагатай тохиолдолд Засаг Даргын хурлаар хэлэлцэж хариу арга хэмжээг шуурхай авч ажиллана. | - | burtgel.moh.mn бүртгэл мэдээ оруулсан байдал | **burtgel.moh.mn бүртгэл 100%** | **burtgel.moh.mn бүртгэл 100%** | Эм, эмнэлгийн хэрэгслийн хамгаалах хувцас, халдваргүйжүүлэх бодис, лабораторийн урвалжийн хэрэглээний орлого, зарлагыг Burtgel.mohs.mn цахим бүртгэлд 72 удаа шивэлт оруулж эм эмнэлгийн хэрэгсэл “Хяналт зохицуулалт”-ын газарт эмийн сангийн нөөц бүрдүүлэлтээ хянуулсан.<br>Эм, эмнэлгийн хэрэгсэл, хүний нөөц, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган ажилласан. Нөөцийн бэлэн байдлын үнэлгээг 3 удаа хийж, 11 төрлийн зөвлөмж өгч ажилласан.<br>Эрүүл мэндийн байгууллагуудад<br>• хамгаалах хувцас хэрэгсэл 10 нэр төрлийн 218592 ширхэг,<br>• эмнэлгийн бусад хэрэгсэл 13 төрлийн 93388 ширхэг,<br>• вирусын эсрэг эм 9 төрлийн 83448 ширхэг,<br>• антибиотик 8 төрлийн 20144 ширхэг,<br>• тарилгын шингэн 7 төрлийн 14850 ширхэг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | • амьлуулах суурь тусламжийн эм 3 төрлийн 269 ширхэг<br>• бусад эм 6 төрлийн 33650 ширхэг тус тус байна.<br>**Үр дүн**:Эм, эмнэлгийн хэрэгсэл 1-2 сарын нөөцтэй байна. | |
| 9.1.3 | Аймгийн нэгдсэн эмнэлгийн лабораторит полимеразын гинжин урвал (ПГУ) шинжилгээ хийх урвалж, бодисооор тасралтгүй хангана. | 10 сая | ПГУ шинжилгээ хийсэн тоо | Түргэвчилсэн шинжилгээ 93038 хийснээс эерэг 19143 гарсан. Эерэг илрэлтийн хувь 20.6% PCR шинжилгээ 52577 хийж эерэг 12410 тохиолдол батлагдаж эмчилгээнд орсон байна. Эерэг илрэлтийн хувь 23.6% | Шаардлагатай тохиолдол бүрт | Ковидын шинжилгээний оношлуурыг нэгдсэн эмнэлгийн санхүүжилтээр, томуугийн шинжилгээний оношлуурыг ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораториас хангаж байгаа.<br><br>PCR шинжилгээний урвалж оношлуурыг 207.7 сая төгрөгний татан авалт хийж бэлэн байдал хангаж эхний 11 сарын байдлаар 5866 хүнд шинжилгээ хийж ажилласан.<br><br>**Үр дүн**: Короновируст халдвар /Ковид-19/-ын тодорхойлох оношлуур 5184, ялгах оношлуур 3300 ширхэг нөөцтэй байна. | 100 |
| 9.1.4 | Нийт хүн ам болон зорилтот бүлэгт зориулсан коронавируст халдвар (КОВИД-19)-ын | - | Цахим мэдээлэл, сургалт, сурталчилг | давхардсан тоогоор 89624 иргэд | давхардсан тоогоор 60000 иргэд | Ковид-19 халдвараас сэргийлэх чиглэлээр:<br><br>• Ковид-19 халдварын тандалт судалгааг өдөр бүр ЕБС нийт 39 сургууль , 26 СӨББ-тай хамтран хийж хариу арга хэмжээг зохион | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | цар тахалтай тэмцэх, сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг цахим хэлбэрээр тогтмол зохион байгуулна. | | ааанд хамрагдсан иргэдийн тоо | | | байгуулах, халдваргүйтгэл ариутгал хийх талаар зөвөлгөө өгч ажилласан.<br>• Сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа эхлэхтэй холбоотой ЭМС, БСУГС-ын хамтарсан А/36 тоот тушаалын дагуу хариу арга хэмжээ авах талаар сургалт, мэдээлэл 3 удаа 64 цэцэрлэг, сургуулийн эмч, удирдлагад өгсөн.<br>• “Ковид-19 халдвараас сэргийлье”, “Амны хаалтаа зүүцгээе” зөвлөмжүүдийг 250-300 ширхэгийг иргэдэд түгээсэн.<br>• Коронавируст халдвар “COVID-19” омикрон хувилбараас урьдчилан сэргийлэх, нэмэлт дархлаажуулалтын ач холбогдол сэдвээр 113 удаагийн мэдээлэл, сурталчилгаанд 18007 хүн хамрагдсан. Коронавирус халдвараас сэргийлье зөвлөмжийг 6-8 удаагийн давтамжтайгаар RGB, DBS телевизүүдээр хүн амд хүргэсэн байна. Коронавируст халдвараас сэргийлэх, дархлаажуулалтын нэмэлт тунг идэвхижүүлэх үйл ажиллагааны хүрээнд ярилцлага, сурталчилгаа бэлтгэж олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийт 36 видео зөвлөмж, постер-56, эмчийн цахим зөвөлгөө-20. Хандалтын тоо-53213<br>• Ковид-19 халдвараас сэргийлэх дархлаажуулалтыг эрчимжүүлэх зорилгоор:<br>✓ Цахим мэдээлэл<br>✓ Постер<br>Шууд ярилцлагуудыг 7 хоног бүр зохион байгуулан ажилласан.<br>**Үр дүн**: Сургалтад 164, Мэдээлэл, сурталчилгаанд 18007 хүн, RGB, DBS телевизүүдээр зөвлөмжийг 6-8 удаагийн давтамжтайгаар хүргэсэн байна. Орон нутгийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ТВ-ээр мэдээлэл 6 удаа, олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийт 36 видео зөвлөмж, постер 56, эмчийн цахим зөвөлгөө 20. Хандалтын тоо-53213 | |
| 9.1.5 | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед ариутгал, халдваргүйтгэлийн бодисын нөөц бүрдүүлэх, тасралтгүй хуваарилах ажлыг зохион байгуулахын зэрэгцээ урьдчилан сэргийлэх, голомтын халдваргүйжүүлэлтийн байдалд үнэлгээ хийж, шаардлагатай арга хэмжээг зохион байгуулна. | 10 сая | -Нөөц бүрдүүлэлт<br>-Халдваргүйтгэл хийсэн талбай | Эцсийн халдваргүйтгэлийг 518 обьектийн 411040 м2 талбайд хийсэн. | -Нөөц бүрдүүлэлт 15-30 хоног<br>-Тухай бүр | Халдвар бүртгэгдсэн аж ахуй нэгж байгууллагууд, хүүхдийн байгууллагуудад голомтын халдваргүйтгэл 9000 мкв талбайд хийсэн байна.<br>Ковид-19 халдварын тандалт судалгааг өдөр бүр 39 ерөнхий боловсролын сургууль, 26 сургуулийн өмнөх боловсролын байгууллагатай хамтран хийж хариу арга хэмжээг зохион байгуулах, халдваргүйтгэл ариутгал зөвлөмж чиглэл өгч ажилласан.<br>Дархан-Уул аймгийн Засаг даргын 2022.05.27-ны өдрийн 01-А/150 тоот захирамжийн дагуу ЭМГ-ын даргын 2022.07.04-ний өдрийн А/96 тоот тушаал гарч баяр наадмын үйл ажиллагаа зохион байгуулагдах 3 хэсэгт давхардсан тоогоор нийт 20696 мкв талбайд урьдчилан сэргийлэх халдваргүйтгэлийг хийсэн. Халдваргүйтгэлд 454.920 төгрөг зарцуулсан. | 100 |
| 9.1.6 | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, халдвар хамгааллын дэглэм баримтлах, халдварын үеийн оношилгоо, эмчилгээ зэрэг сэдвээр эрүүл мэндийн ажилтнуудад тасралтгүй сургалт зохион байгуулах, сургалтад цахимаар хамрагдах боломж, | - | -Хамрагдсан ажилтны тоо, хувь | 185 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 2926 хүн хамрагдсан. 100% | Хамрагдах ажилтан 100% | ХӨСҮТ-өөс эмч, мэргэжилтнүүдэд ТТӨ-ий эрсдэлийн үнэлгээ хийх арга аргачлал сургалтыг зохион байгуулж аймгийн томуугийн 9 тандалтын нэгжийн 5 жилийн томуугийн тоо баримт дээр тулгуурлан судалгаа хийж, PISA үнэлгээний босго үзүүлэлттэй болсон.<br>Менингококкт халдвараас сэргийлэх, эмчилгээ, ялган оношилгооны талаар өрх, сумын 15 эмч танхимаар, 17 эмч цахимаар сургалтад хамрагдсан.<br>“ЭМБ-уудын хог хаягдлын менежмент” сэдвээр ЭМБ-ын эмч, мэргэжилтэнүүдэд 2 удаагийн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | нөхцлийг бүрдүүлэн ажиллана. | | | | | сургалтыг зохион байгуулж 87 мэргэжилтэн хамрагдсан.<br>Томуу, коронавируст халдвар (КОВИД-19)-ын харуулдан тандалтыг бэхжүүлэх, салбар хоорондын оролцоог нэмэгдүүлэх, тоон мэдээний чанарыг сайжруулах, хариу арга хэмжээ, бэлэн байдлыг хангах, хяналт тавих зорилгоор “ТТӨ-ий бэлэн байдал, хариу арга хэмжээ, тандалтын тогтолцоог бэхжүүлэх”, “5-11 насны хүүхдийн Короновируст халдвараас сэргийлэх дархлаажуулалтыг эрчимжүүлэх, мэдээлэл, сурталчилгааны арга зүй”, “Томуу, томуу төст өвчний үеийн оношлогоо эмчилгээний менежемент, сүүлийн үеийн чиг хандлага” сургалтыг өрх, сумдын ЭМТ-үүд, хүүхдийн байгууллагуудын эмч, мэргэжилтэнүүд нийт 100 хүнд зохион байгуулсан.<br><br>Короновируст халдвар /Ковид-19/-ын эсрэг вакцин болон товлолын дархлаажуулалтын чиглэлээр дэмжлэгт хяналт хийх, тарилгатай халдварт өвчний тандалт, дархлаажуулалтын менежмент сэдвээр өрх, сумдын ЭМТ-үүдийн вакцинатори сувилагч, эмч нарт нийт 23 хүнд сургалт зохион байгуулсан. Коронавируст халдвар /КОВИД-19/-аас сэргийлэх, халдварын үеийн оношилгоо, эмчилгээ сэдвээр танхимын сургалт 8, цахим сургалт 2, халдвар хамгааллын дэглэмийн чиглэлээр 4 удаа нийт 332 эрүүл мэндийн ажилтнууд хамрагдсан. Эмнэлгийн улаан бүсэд ажиллах 56 эмч, эмнэлгийн ажилчдад халдвар хамгаалал, хувцас өмсөх тайлах чиглэлээр дадлага сургалтыг 4 удаа зохион байгуулсан.<br><br>Орон нутгийн түвшинд шинэ болон нутагшмал халдварын тохиолдол, дэгдэлт, нийгмийн эрүүл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэндийн онцгой байдал үүссэн үед хариу арга хэмжээг хамтран зохион байгуулах, үр дүнг үнэлэх, дүгнэх, сургамж, туршлагаа хэлэлцэх, хамтарсан хариу арга хэмжээг сайжруулах, халдвараас сэргийлэх хяналтын чиглэлээр мэргэжилтэнүүдийг чадавхижуулах зорилгоор ЗӨСҮТ сургалт зохион байгуулсан. Сургалтанд ЭМГ, Нэгдсэн эмнэлэг, ОБГ, МХГ, Мал эмнэлгийн газар, БОАЖГ, Өрхийн ЭМТ-үүдийн холбогдох мэргэжилтэнүүд нийт 50 хүн оролцсон. Сургалтанд 240.000 төгрөг зарцуулсан.<br><br>**Үр дүн**: Аймгийн томуугийн тоо баримт дээр тулгуурлан судалгаа хийж, PISA үнэлгээний босго үзүүлэлттэй болсон. Халдварт өвчний талаар чадавхжуулах сургалтад 680 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. | |
| 9.1.7 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал болон коронавируст халдвар (КОВИД-19)-ын голомтод ажилласан эрүүл мэндийн ажилтны цалин, урамшууллын асуудлыг Эрүүл мэндийн тухай хууль, Гамшгийн тухай хууль болон Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд заасны дагуу шийдвэрлэж ажиллана. | - | Олгосон хувь хэмжээ | 100% | 100% | Салбарын хэмжээнд ковидын өвчлөлийн үед идэвх санаачлагатай ажилласан 653 эмч, ажичдад нийт 1.325.6 тэрбум төгрөгийн цалин хөлс, нэмэгдэл урамшуулал олгосон байна. Сувилагч нарын баярыг тохиолдуулан аймгийн ЗД-ын нөөц хөрөнгөнөөс салбарт ажиллаж буй 585 сувилагч тусгай мэргэжилтэнд 100.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. ЭМЯ-наас КОВИД-ын үед ажилласан ажилтнуудыг урамшуулахад зориулж 2021 оны сүүлд олгосон 5.0 сая төгрөгийн дэмжлэгийг эмнэлгийн бусад мэргэжлийн буюу арын албанд үр бүтээлтэй ажилласан 10 ажилтанд олгосон. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9.1.8 | Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх чиглэлээр тухай бүрт гарч байгаа хууль, дүрэм, тушаал, зааврыг хэрэгжүүлэн ажиллаж, хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллана. | - | -Гарсан тушаал, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт хийсэн тоо<br>-Өгсөн зөвлөмж | -Хяналт хийсэн тоо 64<br>-өгсөн зөвлөмж 115 | Тухай бүр | ЭМГ-ын даргын 2022 оны А/30, 31 тоот тушаалын хэрэгжилт, Анхан шатны Эрүүл мэндийн байгууллагуудын Томуу, томуу төст өвчний бэлэн байдал, хариу арга хэмжээнд дэмжлэгт хяналт хийж, 5 төрлийн зөвлөмж өгч ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 96.6%.<br>Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтын хүйтэн хэлхээний чанар, аюулгүй байдал, иргэдийн дархлаажуулалтад хамрагдалт, вакцины ач холбогдлын талаархи сурталчилгааны байдалд явцын хяналт үнэлгээ хийж 4 төрлийн зөвөлмж өгч ажилласан. Зөвлөмжийн хэрэгжилт 94.9%.<br>Короновируст халдвар /Ковид-19/-аас сэргийлэх, хариу арга хэмжээний бэлэн байдлын үнэлгээг өрх, сумдын ЭМТ-үүдэд үнэлгээ хийж, ХСХ-ын дэглэмийг сайжруулах, бэлэн байдлыг хангах, Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөөний тодотгол хийх, халдвараас сэргийлэх 5-11 насны хүүхдийн дархлаажуулалтыг зохион байгуулах талаар ажлын байран дахь сургалтыг зохион байгуулсан. Үнэлгээний үр дүнд 14 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлсэн. Хэрэгжилт 92.2%<br>ЭМС-ын А/378 тоот тушаалын дагуу 5-11 насны хүүхдийн ковид-19 эсрэг дархлаажуулалтын бэлэн байдалд үнэлгээ хийж, 8 төрлийн зөвлөмж өгсөн Хэрэгжилт 95.3% байна | 100 |
| 9.1.9 | Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх голомтын болон шуурхай хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх үед эрүүл мэндийн ажилтнуудыг халдвараас сэргийлэх, тэдний дархлааг дэмжих, ажлын байрны эрүүл ахуйн шаардлага хангасан | 10 сая | -Зарцуулсан төсөв | -10 сая | - 10 сая | Халдвар бүртгэгдсэн аж ахуй нэгж байгууллагууд, хүүхдийн байгууллагуудад голомтын халдваргүйтгэл 9000 мкв талбайд хийсэн байна.<br>Ковид-19 халдварын тандалт судалгааг өдөр бүр 39 ерөнхий боловсролын сургууль, 26 сургуулийн өмнөх боловсролын байгууллагатай хамтран хийж хариу арга хэмжээг зохион байгуулах, халдваргүйтгэл ариутгал зөвлөмж чиглэл өгч ажилласан.<br>Хонгор СЭМТ: ЭМТ-ийн ажилчдын дархлааг дэмжих зохирлгоор өглөө халуун аарц, уулгаж | 90 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | орчинг бүрдүүлэхэд анхаарч ажиллана | | | | | байна. Дархлаа дэмжих дусал тариаг 22 эмч, ажилчдад өгсөн.<br>Гэрэлтэй ӨЭМТ: Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээ, халдвар хамгааллын дэглэм, халдварын үеийн оношилгоо эмчилгээ гэх мэт чиглэлээр эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхижуулах тасралтгүй сургалт цахимаар зохион байгуулсан.<br>Цахим сургалтын тоо-12 нийт давхардсан тоогоор/214/<br>ГОС ХОТ ӨЭМТ: Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээ, халдвар хамгааллын дэглэм, халдварын үеийн оношилгоо эмчилгээ сэдвээр эрүүл мэндийн ажилтнуудыг чадавхижуулах тасралтгүй сургалт цахимаар зохион байгуулсан.<br>Цахим сургалтын тоо-29 нийт давхардсан тоогоор/421/ | |
| Хэрэгжилт 97.5 % | | | | | | | |

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХШҮМХ-ийн мэргэжилтэн Ч.Мөнхцэцэг

ХЯНАСАН.

ХШҮМХ-ийн дарга Б.Золбаясах

БАТАЛГААЖУУЛСАН:

Эрүүл мэндийн газрын даргыг түр орлон гүйцэтгэгч Б.Эрдэнэтулга